

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 7667 дугаарт бүртгэв

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 06 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 18

Эрдэнэбулган сум

ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дах хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Хэрэглэгчийн эрчим хүчний тарифын саналыг хянах, шалгах журам”, “Галтзүрх” ХХК-ийн 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Зохицуулах зөвлөлөөс БАТЛАХ нь:

1.“Галтзүрх” ХХК-ны дулаан түгээх сүлжээнд холбогдсон Булган сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тарифыг 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Архангай аймгийн Булган сумын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч “Галтзүрх” ХХК /Д.Пүрэвсүрэн/-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд орон тооны гишүүн /А.Алтанчимэг/-т даалгасугай.

ДАРГА

А.АЛТАНЧИМЭГ

ГИШҮҮН
ГИШҮҮН

С.БАТСҮХ
А.БАТБОЛД

*Архангай аймгийн Зохицуулах зөвлөлийн
2026 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн
18 дугаар тогтоолын хавсралт*

**“ГАЛТЗҮРХ” ХХК-ИЙН ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН
ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

1.Архангай аймгийн “Галтзүрх” ХХК-ийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон Булган сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно.

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт		Төг/м ³	2,256
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ	38,678
		Тогтмол	Төг/м ³	1,158
3	Орон сууцны халаалт (хүн амьдарч буй талбай хамаарна)		Төг/м ²	1,000

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 7668 дугаарт бүртгэв

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 6 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 77

Улаанбаатар
хот

“БАРИЛГЫН ДЭЭВЭР ДЭЭРХ ХОЛБООНЫ АНТЕНЫ СУУРИЙН БАЙГУУЛАМЖИЙН СУУРИЛУУЛАЛТ” ХАРИЛЦАА ХОЛБООНЫ НОРМ БА ДҮРМИЙН БАРИМТ БИЧГИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.“Барилгын дээвэр дээрх холбооны антенны суурийн байгууламжийн суурилуулалт”-ын харилцаа холбооны норм ба дүрмийн баримт бичгийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР
Ц.ГАНЗОРИГ
Б.ДАГВАСҮМБЭРЭЛ
Ч.ЗОЛБАЯР
С.ТАМИР
А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

**МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
НОРМ БА ДҮРЭМ**

**БАРИЛГЫН ДЭЭВЭР ДЭЭРХ ХОЛБООНЫ
АНТЕНЫ СУУРИЙН БАЙГУУЛАМЖИЙН
СУУРИЛУУЛАЛТ
ХХНБД-01**

Албан ёсны хэвлэл

Улаанбаатар хот
2026 он

*Харилцаа холбооны зохицуулах хорооны
2026 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн
77 дугаар тогтоолын хавсралт*

**БАРИЛГЫН ДЭЭВЭР ДЭЭРХ ХОЛБООНЫ АНТЕНЫ
СУУРИЙН БАЙГУУЛАМЖИЙН СУУРИЛУУЛАЛТ**

1.ХАМРАХ ХҮРЭЭ

1.1.Энэхүү норм ба дүрмийг барилга байгууламжийн дээвэр дээр харилцаа холбооны антен суурилуулах зориулалт бүхий антенны суурь (цаашид рүүфтоп/rooftop гэх) байгуулахад тавигдах ерөнхий шаардлагыг тодорхойлж, харилцаа холбооны сүлжээ, үүрэн холбоо, хөдөлгөөнт болон утасгүй холбооны сүлжээнд зориулсан рүүфтопыг төлөвлөх, байгуулах, ашиглахад мөрдөнө.

1.2.Энэхүү норм ба дүрэм нь шинэчлэн суурилуулах, өргөтгөх, шилжүүлэх рүүфтоп байгууламжид нэгэн адил хамаарна.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

2.1.Энэхүү норм ба дүрэмд дараах эш татсан баримт бичгийг хэрэглэнэ. Хугацаа заасан эшлэлийн хувьд эш татсан хэвлэл, харин хугацаа заагаагүй эшлэлийн хувьд хамгийн сүүлийн хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

2.2.MNS 2361:1977, Дамжуулан нэвтрүүлэх радио зангилааны станц болон утсан холбооны суурин төхөөрөмжийн газардуулга.

2.3.MNS 5596:2020, “Мэдээлэл холбооны сүлжээний байгууламжид ажиллагсад тавих аюулгүй ажиллагааны шаардлага”

2.4.БД 43-101-03/*12, Цахилгаан байгууламжийн дүрэм. Бүлэг 1,6 “Газардуулга ба цахилгааны аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ”

2.5.БД43-108-24 "Барилгын холбоо дохиоллын зураг төслийн төлөвлөлтийн дүрэм"-ийн 11.3.

2.6.БНБД 20-102-21, “Ачаалал ба үйлчлэл” зэрэг бичиг баримтуудын холбогдох заалтуудын баримтална.

2.7.MNS 6605:2016, “Үүрэн холбооны бааз станцуудын давтамж, орон зайн тусгаарлалт, илүүдэл цацаргалтын хэмжээ, хэмжих арга”

2.8.MTSFB 001:2023, Малайз “Радио холбооны сүлжээний дэд бүтцийн техникийн стандарт ба дэд бүтцийн шаардлага”

2.9.ANSI/TIA-222-G, “Антен ба антенны цамхгийн бүтцийн стандарт”

3. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү норм ба дүрэмд дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1.рүүфтоп (rooftop)

Барилгын дээвэр дээр холбооны антен, тоног төхөөрөмжийг суурилуулах зориулалттай тулгуур хийцийг;

3.2.суурь

рүүфтопын үндсэн ачааг хүлээн авч барилгын дээвэрт дамжуулах, тогтворыг хангах үүрэгтэй эсрэг ачаа болох хүндрүүлэгч, эсхүл бэхэлгээг;

3.3.татлага

рүүфтопийн тогтвор хангах зориулалттай татлага хийцийг;

3.4.антен

цамхаг болон антены суурьт байрлуулсан, цахилгаан соронзон долгионыг цацаргах, хүлээн авах зориулалт бүхий утасгүй холбооны төхөөрөмж

3.5.ажлын тавцан

рүүфтопд тоног төхөөрөмж угсрах, суурилуулах, засвар үйлчилгээ хийж ажиллах, түр амрах зориулалтай, MNS 5596:2020 “Мэдээлэл холбооны сүлжээний байгууламжид ажиллагсдад тавих аюулгүй ажиллагааны шаардлага” стандартын шаардлагыг хангасан талбай, гишгүүрийг

3.6. шат

рүүфтопд авирах, рүүфтопын их бие дагуу ажил гүйцэтгэх зориулалттай ажилтныг аюулгүй ажиллах шаардлагыг хангасан хийцийг

3.7.кабелийн тавиур

фидер болон бусад холболтын кабелийг татаж бэхлэх, зориулалт бүхий замчлал хийцийг

3.8.цэгэн бэхэлгээ

кабель татах замчлалын дагуу хоорондоо 1-2 м зайтай хананд цэгэн байдлаар бэхлэгдсэн кабель татах замчлалыг

3.9.зураг төсөл

рүүфтопыг төлөвлөх, угсралтын ажил гүйцэтгэхэд шаардагдах загвар зураг /эскиз/, техникийн болон ажлын зураг, инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг;

4. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

4.1.Барилгын дээвэр дээрх рүүфтопд радио долгион ашиглаж цахилгаан холбоо, үүрэн холбоо, хөдөлгөөнт болон утасгүй холбооны дохионуудыг тасралтгүй дамжуулал хийх нөхцөлийг бүрдүүлэх зориулалттай нэвтрүүлэх хүлээн авах антеныг суурилуулахад зориулагдсан байна.

4.2.Рүүфтоп нь баталгаажсан зураг төсөлтэй байна.

4.3.Рүүфтопыг угсарч суурилуулах ажлыг холбооны угсралт суурилуулалтын үйл ажиллагааг харилцаа холбооны сүлжээ, дэд

бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ.

4.4.Рүүфтопын загвар, хэмжээ, өндөр болон байрлуулах байршлыг үйлчилгээний төрөл, сүлжээний хамрах хүрээ, барилгын бүтээцийн даац болон орчны нөхцөлийг харгалзан сонгоно.

4.5.Захиалагч байгууллага хянан баталгаажуулж ашиглалтад хүлээж авсан акт болон рүүфтопын зураг төслийг бусад холбогдох дүгнэлт, баримт бичгийн хамт тухайн байгууламжийг эзэмшигч архив үүсгэн хадгална.

5. ЗУРАГ ТӨСӨЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

5.1.Зураг төсөл нь “Нэг маягийн” эсхүл “Нэг удаагийн” зураг байна.

5.2.Рүүфтопын зураг төсөл нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдсэн байна. Үүнд:

5.2.1.Барилгын бүтээцийн хэсэг;

5.2.2.Газардуулгын хэсэг;

5.2.3.Аянга хамгааллын хэсэг;

5.2.4.Антен болон тоног төхөөрөмжийн байрлалын төлөвлөлтийн хэсэг;

5.2.5.Кабелийн замчлал, бэхэлгээний хэсэг.

5.3.Ажлын зураг төсөл нь рүүфтопын аюулгүй, найдвартай ашиглалтыг хангах техникийн шийдэл, инженерийн тооцоо болон холбогдох мэдээллийг агуулсан байна.

5.4.Ажлын зураг төсөлд дараах мэдээллийг тусгасан байна. Үүнд:

5.4.1.Антену тоо, хэмжээ, жин;

5.4.2.Антенуыг бэхлэх хийц, холбох төхөөрөмжийн тоо;

5.4.3.Рүүфтопын их биеийн өндөр, бүтэц, хэмжээ

5.4.4.Салхи болон газар хөдлөлтийн ачааллын тооцоо;

5.4.5.Суурийн хийц, бэхэлгээ, хүндрүүлэгчийн төрөл, хэмжээ байрлал;

5.4.6.Их биеийн бүтэц, хэмжээ;

5.4.7.Ашиглах материалын төрөл, хэмжээ;

5.4.8.Боолтын хатуулга, шинж чанар;

5.4.9.Газардуулга болон аянга хамгааллын схем

5.4.10.Кабелийн замчлал, бэхэлгээ болон тоног төхөөрөмжийн байршлын зураг;

5.5.Зураг төслийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, эрх бүхий байгууллагын магадлалаар баталгаажуулсан байна.

6. АНТЕНУ СУУРИЙН АНГИЛАЛ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

6.1.Рүүфтоп нь хүндрүүлэгч суурь, их бие, дээвэр хамгаалах дэвсгэр, аянга зайлуулагч, бэхэлгээ зэргээс бүрдэж, ажлын тавцан, шатны гишгүүр, газардуулгын шин-ээр тоноглогдсон байх ба рүүфтопын өндөр, хийцийн онцлогоос хамаарч хамаарч татлагатай байж болно.

6.2.Рүүфтопын металл хийц, холболтын эд анги нь зэврэлтээс, хүндрүүлэгч хийц эвдрэл, элэгдлээс хамгаалагдсан, гадна орчны нөлөөлөлд тэсвэртэй байна.

6.3.Рүүфтопын их биеийн боолт нь зэвэрдэггүй эсхүл цайрдсан төмөр материалаар хийгдсэн байна.

6.4.Хот байгуулалт, архитектур, орчны зохицуулалтын шаардлагын дагуу рүүфтопын өнгө будаг, өнгөлгөө болон гадна үзэмжийг орчинд зохицуулан төлөвлөж болно.

6.5.Рүүфтопыг зөвхөн баталгаажсан зураг төслийн дагуу угсарч, суурилуулна.

6.6.Рүүфтопыг дараах төрлөөр ангилна.

6.6.1.Хүндрүүлэгчтэй рүүфтоп

Барилгын үндсэн хийцэд бэхлэгдээгүй, суурийн хүндрүүлэгчийн жингээр тогтворжилтоо хангахаар тооцоологдсон рүүфтопыг хэлнэ.


6.6.1.1.Хүндрүүлэгч нь төмөр гулдмайгаас бүрдэх ба бетоны анги нь зураг төсөлд тусгагдсан байна.

6.6.1.2.Хүндрүүлэгчийн доор 1см-аас багагүй зузаантай, ус чийг болон механик үйлчлэлд тэсвэртэй, зуурамтгай чанартай хамгаалалтын материал дэвсэж, барилгын дээврийг хамгаална.

6.6.1.3.Рүүфтопын суурийн хүндрүүлэгчийг холбосон резба, боолт, металл эд ангид зэврэлтээс хамгаалах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.

6.6.1.4.Хүндрүүлэгчтэй рүүфтоп нь салхи болон газар хөдлөлтийн үйлчлэлийн үед шилжилт, хазайлт үүсэхгүй байхаар инженерийн тооцоогоор баталгаажсан байна.

6.6.1.5.Барилгын дээврийн даац, ус тусгаарлалтын бүтээцэд сөрөг нөлөө үзүүлхээргүйгээр хүндрүүлэгчийн байрлалыг төлөвлөсөн байна.



Зураг 1. Рүүфтопын хүндрүүлэгч тэдгээрийн бэхэлгээний загвар зураг

6.6.2 Булангийн рүүфтоп


Барилгын парапет болон хана болон үндсэн бүтээцэд анкер бэхэлгээгээр холбогдож тогтворжилтоо хангахаар тооцоологдсон рүүфтопыг хэлнэ.

6.6.2.1. Булангийн рүүфтопын тулгуур хийцийн хоёр талын хэмжээ 80 см-ээс багагүй байна.

6.6.2.2. Булангийн рүүфтопыг бэхлэх анкер боолтын хэмжээ 8мм-ээс багагүй голчтой, 80 мм-ээс багагүй урттай байна.

6.6.2.3.Парапет болон хананд хийх өрөмдлөг, бэхэлгээний хэсгийг үс чийг нэвтрэхээс хамгаалсан байна.

6.6.2.4. Булангийн рүүфтопын металл хийц, анкер болон бэхэлгээний эд анги нь зэврэлтээс хамгаалагдсан байна.



Зураг 2. Булангийн рүүфтопын загвар зураг

6.6.3.Орон зайт рүүфтоп

Гурав ба түүнээс дээш талын тулгуур хийцээс бүрдсэн, дундаа орон зай бүхий тогтворжилтыг орон зайн хийцээр хангасан рүүфтопыг хэлнэ.

6.6.3.1.Орон зайт рүүфтопын тулгуур, холбоос болон бэхэлгээний хийц нь тогтворжилтыг хангахуйц хатвуу холбоостой байна.

6.6.3.2.Орон зайт рүүфтопын металл хийц, холбоос болон бэхлэгээний эд анги нь зэврэлтээс хамгаалагдсан байна.

6.6.3.3.Орон зайт рүүфтопын суурилуулалт нь барилгын үндсэн бүтээцийн даац, ус тусгаарлалтын үе болон ашиглалтын аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байна.

7. АНТЕНЫ СУУРИЙН СУУРИЛУУЛАЛТЫН ШААРДЛАГА

7.1.Барилгын дээвэр дээр рүүфтопыг суурилуулахдаа тухайн барилгын дээврийн зай талбай, бүтээцийн даацын нормтой нийцүүлсэн байна.

7.2.Рүүфтоп болон харилцаа холбооны тоног төхөөрөмжийг байрлуулах байршил, талбайн хэмжээг барилгын зориулалт, дээврийн ашиглалтын нөхцөл, инженерийн байгууламжийн байрлал болон бүтээцийн даацын тооцоонд үндэслэн тогтооно.

7.3.Антену суурийн байршлыг түүний өндрөөс болон тухайн барилгын дээврийн талбайн хэмжээнээс хамааруулан сонгож, радио

долгион сааданд өртөхгүй, шууд харалтын зарчмаар дамжих нөхцөлийг хангана.

7.4.Рүүфтопыг суурилуулахдаа барилгын ус тусгаарлалтын үе, инженерийн шугам сүлжээ, агааржуулалтын тоног төхөөрөмж болон бусад ашиглалтын байгууламжид саад учруулахгүйгээр төлөвлөсөн байна.

7.5.Өөр өөр үйлчилгээ үзүүлэгчийн антен, тоног төхөөрөмжийг техникийн болон радио давтамжийн хувьд харилцан нөлөөлөл үүсгэхгүй нөхцөлөөр нэг байршилд хамтран суурилуулж болно.

7.6.Рүүфтопд антенг байршуулахдаа MNS: 6605:2016 "Үүрэн холбооны бааз станцуудын давтамж, орон зайн тусгаарлалт, илүүдэл цацаргалтын хэмжээ, хэмжих арга"-д заасны дагуу тооцооллыг хийж байршуулна.

7.7.Рүүфтопын эргэн тойронд засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай аюулгүй нэвтрэх зам, ажлын талбай болон хамгаалалтын нөхцөлийг бүрдүүлсэн байна.

7.8.Рүүфтопын суурилуулалтын явцад барилгын бүтээц, фасад, ус тусгаарлалтын үе болон бусад инженерийн хийцэд гэмтэл учруулахыг хориглоно.

8. БАРИЛГЫН ДЭЭВЭРТ КАБЕЛИЙН ТАВИУР СУУРИЛУУЛАХ ШААРДЛАГА

8.1.Кабелийн тоо, төрөл, жин болон багцлалтын нөхцөлөөс хамааруулан кабелийн тавиур, цэгэн бэхэлгээ, хүндрүүлэгчтэй замчлал зэрэг кабель бэхлэх тохирох шийдлийг сонгон хэрэглэнэ.

8.2.Кабелийг бетон блокон хүндрүүлэгч ашиглан суурилуулах тохиолдолд хүндрүүлэгчийг хооронд нь 1–2 м-ээс ихгүй зайтай байрлуулж, түүнд кабелийг зориулалтын бэхэлгээгээр тогтвортой бэхэлсэн байна.

8.3.Хүндрүүлэгчтэй кабелийн замчлал нь дээврийн хавтгай хэсэгт байрлуулсан хүндрүүлэгчийг ашиглан кабелийг бэхэлж татах хийцтэй байна.

8.4.Нэг хүндрүүлэгчийн жин, хэмжээ болон материалын төрлийг инженерийн тооцоонд үндэслэн сонгох бөгөөд хүндрүүлэгчийн дээвэртэй харьцах гадаргуу нь ус тусгаарлалтын үе болон дээврийн материалыг гэмтээхгүй байна.

8.5.Кабелийн тавиур, цэгэн бэхэлгээ болон кабелийн замчлалыг барилгын парпет болон хана дагуу төлөвлөн суурилуулна.

8.6.Холболтын болон тэжээлийн кабелиудыг их биед зориулалтын баригч ашиглан зам, тавиурт зохих зай хэмжээтэйгээр байрлуулж бэхэлнэ.

8.7.Кабелийн тавиур болон замчлал нь засвар үйлчилгээ хийхэд саад учруулахгүй, аюулгүй нэвтрэх нөхцөлийг хангасан байна.

9. АЯНГА САРНИУЛАГЧ БА ГАЗАРДУУЛГА

9.1.Рүүфтоп нь аянга сарниулагч болон газардуулгын системтэй байна.

9.2.Рүүфтопын аянга хамгаалалт болон газардуулгын системийг Д 43-101-03/*12, Цахилгаан байгууламжийн дүрэм. Бүлэг 1,6, болон зураг төсөлд заасны дагуу нийцүүлэн төлөвлөж угсарч, суурилуулна.

10. АШИГЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

10.1.Рүүфтопын их бие төмөр хийцийн чанар муудахаас урьдчилан сэргийлэх, сэргээн засварлах зорилгоор чанарын үзлэг шалгалтыг хуваарийн дагуу тогтмол зохион байгуулж, түүний металл хийцүүд болох их бие, тоноглол, боолт, гагнаас, анкер боолт зэргийг бүхэлд нь зэврэлтээс хамгаалах ажлыг тогтмол хийнэ.

10.2.Бетон хүндрүүлэгч, суурь эдэлгээний явцад хагарсан, бутарсан тохиолдолд тухай бүрд шинээр солино.

10.3.Рүүфтопд төхөөрөмж нэмэх, нэмэлт тоноглол суурилуулахдаа рүүфтопын их бие, үндсэн хийцэд гагнуур хийх, гагнуураар цоолох зэрэг дулааны боловсруулалт болон механик гэмтэл учруулахыг хориглоно.

10.4.Рүүфтопын ашиглалт, засвар үйлчилгээний ажлыг өндөрт ажиллах аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, мэргэшсэн ажилтан гүйцэтгэнэ.

11. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХҮЙ

11.1.Барилгын дээвэрт ажиллах инженер, техникийн ажилтан нь нийт ажилтны болон эрсдэлтэй ажлын байр /Өндөрт ажиллах аюулгүй ажиллагааны/-ны ХАБЭА-н сургалтад хамрагдсан, шалгалт өгч, тэнцсэн, өндөрт ажиллах эрхтэй ажилтан байна.

11.2.Өндөрт ажил гүйцэтгэх үед хамгаалах бүс, хамгаалах олс, хамгаалах малгай болон бусад шаардлагатай нэг бүрийн хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэнэ.

11.3.Салхи, аадар бороо, аянга цахилгаан, мөстөлт болон хүний аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй цаг агаарын нөхцөлд дээврийн ажил гүйцэтгэхийг хориглоно.

11.4.Рүүфтопын угсралт, суурилуулалт болон засвар үйлчилгээний ажлыг гүйцэтгэх үед ажлын бүсэд зөвшөөрөлгүй хүн нэвтрэхээс сэргийлсэн хамгаалалт, тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан байна.

11.5.Рүүфтопыг угсрах, суурилуулах ашиглалтын үеийн хөдөлмөрийн аюулгүй байдал нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын дагуу ХАБЭА-н зүйл заалтаар зохицуулагдана.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 7669 дүгээрт бүртгэв

**КИНО УРЛАГИЙН ЗӨВЛӨЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ХАМТАРСАН ТОГТООЛ**

2026 оны 7 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 22/100

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Кино урлагийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.16.7 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Кино урлагийн зөвлөл, Харилцаа холбооны зохицуулах хорооноос **ТОГТООХ нь:**

1.“Кинонд насны ангилал тогтоох шалгуур, түгээхэд баримтлах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Батлагдсан журмыг олон нийтэд сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Кино урлагийн зөвлөлийн Ажлын алба /Ч.Ундрал/-нд, Харилцаа холбооны зохицуулах хорооны Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газар /Э.Золбаяр/-т тус тус даалгасугай.

КИНО УРЛАГИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА: Ч.УНДРАЛ

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДАРГА: Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД:
Д.НАРАНЦЭЦЭГ
Ж.ДЭЛГЭРЖАРГАЛ
Ч.ЭРДЭНЭБАЯР
Г.ЭНХБАЯР
Н.ОНОН
Д.ЭНХБОЛД
Г.БАТСУУРЬ
Д.ЦЭНГЭЛ
Ц.ХҮСЭЛБААТАР
Э.ЭРДЭНЭЧУЛУУН

ГИШҮҮД:
Б.АНХБААТАР
Ц.ГАНЗОРИГ
Б.ДАГВАСҮМБЭРЭЛ
Ч.ЗОЛБАЯР
С.ТАМИР
А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

*Кино урлагийн зөвлөл,
Харилцаа холбооны зохицуулах хорооны
2026 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн
22/100 дугаар хамтарсан тогтоолын хавсралт*

КИНОНД НАСНЫ АНГИЛАЛ ТОГТООХ ШАЛГУУР, ТҮГЭЭХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт түгээх кинонд насны ангилал тогтоох шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, уг шалгуурт үндэслэн насны ангилал тогтоох, тогтоосон насны ангиллыг баримтлан түгээхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэхүү журам нь Кино урлагийг дэмжих тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хууль, Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актад нийцсэн байна.

1.3.Монгол Улсын нутаг дэвсгэрт кино бүтээх, түгээх үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, хуулийн этгээд, киноны эрх эзэмшигч, кино зуучлагч болон бусад холбогдох этгээд Монгол болон гадаад кинонд насны ангилал тогтоож, бүх төрлийн сувгаар түгээхэд энэ журмыг баримтлана.

Хоёр. Насны ангилал тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлал

2.1.Тухайн киноны эрх эзэмшигч нь кинонд насны ангилал тогтоохдоо энэхүү журмаар тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлгээ хийнэ.

2.2.Насны ангилал тогтоохдоо дараах үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг авч үзнэ. Үүнд:

2.2.1.Гэмт хэрэг, хууль бус үйлдэл бүхий агуулга;

2.2.2.Хүчирхийлэл болон хүчирхийллийн шинжтэй дүрслэл;

2.2.3.Бэлгийн агуулга ба садар самуун үйлдэл бүхий илэрхийлэл;

2.2.4.Мансууруулах бодис, архи, тамхи хэрэглэх, түүнийг сурталчлах;

2.2.5.Хараалын үг, зохисгүй хэллэг;

2.2.6.Айдас төрүүлэх, сэтгэл зүйд хүчтэй нөлөөлөх дүрслэл.

2.3.Киноны агуулгыг энэхүү журмын хавсралтад заасан насны ангилал тогтоох шалгуур үзүүлэлт бүрээр үнэлж, өгүүлэмж, дүрслэл, дуу авианы хамгийн хүнд (өндөр) үзүүлэлтэд үндэслэн насны ангиллыг тогтооно.

2.4.Гадаад киног Монгол Улсад түгээх эрх бүхий кино зуучлагч, кино түгээх үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, хуулийн этгээд нь энэхүү журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу агуулгыг нягталж, нийцээгүй тохиолдолд насны ангиллыг дахин тогтооно.

2.5.Кино урлагийн зөвлөл нь насны ангилал тогтоох шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлал, асуумж, тайлбарыг олон нийтэд нээлттэй байршуулах ба уран бүтээлч тухайн кино аль насны ангилалд хамаарахыг урьдчилан тооцоолж, нийцүүлэх боломжтой байна.

2.6.Тухайн киноны эрх эзэмшигч болон кино зуучлагч нь киноны нэр, үргэлжлэх хугацаа, төрөл, энэхүү журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, тогтоосон насны ангиллын талаарх мэдээллийг Кино урлагийн зөвлөлд төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан цахим хэлбэрээр хүргүүлснээр кино түгээх боломжтой.

2.7.Кино урлагийн зөвлөл нь энэхүү журмын 2.6-д заасан мэдээллийг хүлээн авч, төрөлжсөн мэдээллийн санд бүртгэл үүсгэх бөгөөд кинонд тогтоосон насны ангилал, тэмдэг, тэмдэглэгээг байршуулахтай холбоотой маргаан, санал гомдлыг шийдвэрлэхэд ашиглана.

Гурав. Кино түгээхэд баримтлах шаардлага

3.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт кино түгээх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хуульд заасан цагийн хязгаарлалтыг мөрдөж, насны ангиллыг харуулсан тэмдэг тэмдэглэгээг Кино урлагийг дэмжих тухай хуульд заасныг баримтлан заавал байршуулах, киног аудио хэлбэрээр түгээх тохиолдолд эхлэл хэсэгт сонсогдохуйц байдлаар мэдээлнэ.

3.2.Кино, кино сурталчилгааны видео дүрс, зурагт хуудсыг хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин, кино театр, үзвэрийн цэг, үзвэрийн танхим зэрэг бүх төрлийн сувгаар түгээхэд насны ангиллын тэмдэглэгээг харааны тусгай хэрэгсэл ашиглахгүйгээр харагдахуйц байдлаар байршуулна. Үүнд:

3.2.1.Кино театрын дэлгэц, компьютер, гар утас болон дүрс бичлэг дамжуулах, үзүүлэх зориулалттай бүх төрлийн дэлгэцийн өргөний зургааны нэгтэй тэнцэх хэмжээтэй байх;

3.2.2.Кино театр, үзвэрийн цэг, үзвэрийн танхимаар киног түгээхдээ үзвэрийн өмнө 5 секундээс доошгүй дэлгэцэд харуулах;

3.2.3.Сурталчилгааны видео дүрсний эхэнд 3 секундээс доошгүй харуулах;

3.2.4.Зурагт хуудасны аль нэг буланд 15 миллиметрээс доошгүй өндөртэй, бусад төрлийн сурталчилгааны материалын 8–10 хувьтай тэнцэх хэмжээтэйгээр байрлуулах;

3.2.5.Насны ангиллын тэмдэглэгээг дэлгэцийн баруун доод буланд эсвэл сувгийн логоны эсрэг талд байрлуулах бөгөөд дүрсийг

халхлахгүй, арын дэвсгэрээс тод ялгарахуйц өнгөтэй байна.

3.3.Үндсэн шалгуур үзүүлэлтээс тухайн кинонд хамгийн хүнд (өндөр) агуулга, дүрслэлийн мэдээллийг насны ангиллын тоон тэмдэглэгээний хажууд бичгээр харуулна.

3.4. 18 ба түүнээс дээш насныханд зөвшөөрөх насны ангилалтай кино сурталчилгааны видео дүрс, зурагт хуудсыг хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин, видео сан, сурталчилгааны зурагт самбар, дэлгэц зэрэг бүх төрлийн сувгаар байршуулах, нийтэд түгээхдээ энэхүү журмын 2.2-т заасан шалгуурт хамаарах ил задгай, бэлгийн илэрхийлэлтэй буюу садар самуун, хүчирхийллийг ил тод дүрсэлсэн агуулга болон ёс зүйд нийцэхгүй агуулгыг ил тод байршуулахгүй байна.

Дөрөв. Гомдол хүлээн авах, шийдвэрлэх

4.1.Хүн, хуулийн этгээд аливаа сувгаар түгээж буй киноны насны ангиллыг энэхүү журамд нийцээгүй гэж үзвэл, эсхүл насны ангиллын тэмдэг тэмдэглэгээг байршуулаагүй түгээсэн тохиолдолд Кино урлагийн зөвлөлд гомдол, мэдээлэл хүргүүлнэ.

4.2.Кино урлагийн зөвлөл нь гомдол, мэдээллийг хүлээн авч, ирүүлсэн гомдлыг киноны эрх эзэмшигч, кино зуучлагч, түгээгчид хүргүүлж, холбогдох баримт мэдээлэл, хариу тайлбар гаргуулан авна.

4.3.Кино урлагийн зөвлөл нь тухайн кино бүтээлд хяналтын үзлэг хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагуудаас тодруулга, зөвлөмж авч ажиллана.

4.4.Гомдлын дагуу хийгдсэн хяналт, үзлэгийн үр дүнг Кино урлагийн зөвлөл баталгаажуулж, шаардлагатай тохиолдолд тухайн киноны эрх эзэмшигч, кино зуучлагч болон түгээлтийн байгууллагад тогтоосон хугацаанд киноны насны ангиллыг шинэчлэн тогтоолгох арга хэмжээ авахыг мэдэгдэнэ.

4.5.Энэхүү журмын 4.4-т заасны дагуу хүргүүлсэн мэдэгдэл шаардлагыг тогтоосон хугацаанд хэрэгжүүлээгүй бол Кино урлагийн зөвлөл нь уг зөрчлийг арилгахтай холбоотой шаардлагатай арга хэмжээ авна.

4.6.Кино урлагийн зөвлөл нь зөрчилтэй холбоотой бүртгэл үүсгэх бөгөөд Кино урлагийн тухай хуульд заасан чиг үүргийн хүрээнд холбогдох шийдвэр гаргах ажиллагаанд харгалзан үзнэ.

4.7.Кино урлагийн зөвлөл гомдол, мэдээллийг хүлээн авч ажлын 10 хоногт хянан шалгасны дараа, гомдлын дагуу авсан арга хэмжээ, энэ талаарх шийдвэрээ тодорхой тайлбар, үндэслэлтэйгээр гомдол гаргагч талд хүргүүлж, энэ талаар олон нийтэд мэдээлнэ.

4.8. 18 ба түүнээс дээш насныханд зөвшөөрөх ангиллын киног радио, телевизийн нийтийн сувгаар өдрийн буюу 06.00-22.00 цагт нэвтрүүлсэн, эсхүл кино театр, үзвэрийн цэг, үзвэрийн танхимаар

насанд хүрээгүй хүнд үзүүлсэн бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээнэ.

Тав. Хяналт

5.1. Киноны эрх эзэмшигч, кино зуучлагч нь насны ангиллыг энэхүү журмын шалгуур үзүүлэлтийн дагуу үнэн зөв тодорхойлох, насны ангиллын тэмдэг, тэмдэглэгээг шаардлагын дагуу байршуулж, түгээлтэд гаргахад баримтлах мөн насны ангиллын мэдээллийг олон нийтэд ил тод хүргэх үүргийг хүлээнэ.

5.2. Кино түгээх үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, хуулийн этгээд тухайн кинонд тогтоосон насны ангиллыг мөрдөж, насны ангиллын тэмдэг тэмдэглэгээг шаардлагын дагуу байршуулан түгээх үүрэгтэй бөгөөд энэхүү журмын хэрэгжилтийг хангах зорилгоор дотоод хяналт тавьж ажиллана.

5.3. Кино түгээх үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, хуулийн этгээд насны ангилалд нийцсэн үзэгчдэд тасалбар, үзвэрийн эрхийг борлуулах, үйлчилгээний эрх нээх, 18 + ангилалтай кино түгээлтийн үед насанд хүрэгчдэд зориулсан тохиргоо, түгжээ бүхий хязгаарлалтын арга хэмжээг хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд хувийн мэдээллийг шалгах үүргийг хүлээнэ.

5.4. Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн насны ангиллын тэмдэг, тэмдэглэгээ байршуулах болон цагийн хязгаарлалт мөрдөхтэй холбоотой шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

5.5. Кино урлагийн зөвлөл энэхүү Журмын хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллана.

Насны ангилал тогтоох шалгуур, кино түгээхэд
баримтлах журмын Хавсралт

Насны ангилал тогтоох шалгуур үзүүлэлтийн хүснэгт

№	Үндсэн шалгуур	Шалгуурт хамаарах агуулга	Бүх насныханд	13+		18+	
				Дүрслэгдэх байдал	Анхаарах зүйлс	Дүрслэгдэх байдал	Анхаарах зүйлс
1	Гэмт хэрэг, хууль бус үйлдэл	Гэмт хэрэг: Хүнд, хөнгөн бүх төрлийн гэмт хэрэг	Хүхэд дуурайх эрсдэл бүхий үйлдэл тусгахгүй.	Гэмт хэрэг, хууль бус үйлдлийг уран сайхны аргаар (амьдралын бодит үйл явдал, дүр, орчныг уран сэтгэмж, гоо зүйтэйгээр найруулан илэрхийлэх) дүрсэлсэн бол; Кино зохиолын өгүүлэмж нь гэмт хэрэг, хууль бус үйлдлийг дүрслэхийн хамт, түүний сөрөг үр дагавар тодорхой дүрслэгдсэн, хууль ёсны хариуцлага, шуударга ёсны илэрхийлэлтэй хосолсон байх шаардлагатай.	Өвөр насны хүүхдийн сэтгэхүйд цочирдол өгөхүйц, хэт хүчтэй дүрслэл, цус, бие махбодид гэмтэл учруулж буй хэсгийг хязгаарлана.	Хүнд гэмт хэрэг (хар тамхины наймаа, аллага, хорлон сүйтгэх ажиллагаа, хүн худалдаалах, авлигын гэмт хэрэг гэх мэт)-ийн үйлдлийг бодитой, нарийвчлан хүчирхийлэл агуулсан байдлаар дүрслэн үзүүлсэн бол;	Гэмт хэргийн үйлдлийг зөвтгөх, үзэгчдийг гэмт үйлдэлд өдөөн турхирах, гэмт хэргийг сайн үлгэр дуурайл болгох утга агуулаагүй байх; Дэлгэцийн бүтээлийн дүрслэн үзүүлэх гоо зүйг баримтлах;
					Аливаа гэмт үйлдлийг сурталчлах, зөвтгөх, үлгэр дуурайл болгохуйц байдлаар дүрслэхгүй.		

	Ялгаварлан гадуурхалт: Тухайн кинонд арьс өнгө, хүйс, шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үндэс угсаа, нийгмийн бүлэг гэх мэт үндэслэлээр бусдыг дорд үзэх, гадуурхах, доромжилх хэлбэрээр илэрч буй агуулга юм.	Ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрийг ялгаварласан агуулга агуулагдахгүй.	Ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэр (доромж үг, үйлдэл гэх мэт)-ийн илэрхийллийг богино хугацаанд, киноны сэдвийн хүрээнд сургамж (ялгааварлалыг илчилж, жиешлүүц)-тай уур амьсгалтай үзүүлсэн, мөн ялгаварлан гадуурхалтаас үүдэх сөрөг үр дагавар (доромжлол, дээрэлхэлт, амиа хорлолт зэрэг)-ыг дүрсэлсэн бол;	Энэ ангилалд зөвшөөрөгдсөн дүрслэл нь өсвөр үеийнхний насны онцлогт нийцэхгүй, ойлгоход хүнд, сэтгэлзүйн дарамт үзүүлж болзошгүй, цочролд оруулахуйц дүрслэл, илэрхийлэлгүй байх;	Ялгаварлан гадуурхалтыг зөвтгөсөн, сурталчилсан аливаа агуулгагүй байх;	Уран сайхны илэрхийллийн хүрээнд ялгаварлан гадуурхалт, түүний үр нөлөөг чөлөөтэй тусгахдаа дэлгэцийн бүтээлийн дүрслэн үзүүлэх гоо зүйг баримтлах;
	Хүчирхийлэл: Биеэр үйлдэх аливаа хүчирхийлэл болон хүчирхийллийн бүхий л төрлүүд (сэтгэл санаа, гэр бүлийн, эрх чөлөө, эдийн засгийн, нэр төр, үл хайхрах, цахим хүчирхийлэл гэх мэт)	Бодит бус, тоглоомын шинжтэй, сэтгэл зүйд хортой нөлөөгүй байх.	Дайн байлдаан, тулаан тэмцэлдээн (зодолдох, буудалцах гэх мэт), аливаа харгис үйлдэл зэрэг хүчирхийллийн дүр дүрслэл, үүнээс үүдэх нөхцөл байдал (цус, бие махбодын гэмтэл гэх мэт зураглал) нь өсвөр насны хүүхдэд цочрол төрүүлэхгүй байдлаар дүрсэлдсэн байна.	Хүчирхийллийг сурталчилсан, өдөөн турхирсан, баатарлаг амжилтад хүрэх арга хэрэгсэл болгон харуулахгүй байх;	Хүчирхийллийг аливаа хэлбэрийг илүү тод томруун, бодит дүрслэх боловч дүрслэн үзүүлэх уран сайхны хэм хэмжээ, гоо зүйг баримтлах;	Хэт харгис хүчирхийлэл нь уран сайхны санаа эсхүл нийгмийн асуудлыг хөндсөн, шүүмжлэл агуулсан, урьдчилан сэргийлэх зорилготой агуулгад хязгаартайгаар хамаарна.
2	Хүчирхийлэл					

[illegible]

	Романтик харилцаа ба бэлгийн харилцаа	Романтик харилцааны зөөлөн илэрхийлэл үзүүлэх, бэлгийн харилцааны аливаа дүрслэлийг хориглох	Романтик харилцааны зөөлөн илэрхийлэл дүрслэгдэж болох бөгөөд бэлгийн үйлдлийн тодорхой байдал, хөдөлгөөний нарийвчилсан дүрслэл, дуу авиа, өдөөн хатгасан яриа, сэтгэл хөдлөлийг хэт илэрхийлсэн байдалгүй, товч, далд байдлаар дүрслэнэ. Мөн бэлгийн харилцаа, эротик, садар самуун үйлдлийг илэрхийлсэн биеийн хөдөлгөөнийг хэлэмжийг үзүүлэхгүй.	Дүрслэгдсэн бэлгийн харилцааны аливаа дүрслэл нь өсвөр насны хүүхдэд бэлгийн боловсролын зөв ойлголт төрүүлэхүйц байна.	Бэлгийн харилцааны аливаа дүрслэл нь ил тод тодорхой дүрслэлтэй байж болох боловч уран сайхны хэв маягаар дэлгэцийн бүтээлийн дүрслэл үзүүлэх гоо зүйг баримтлан дүрслэх бөгөөд садар самуун шинжтэй илэрхийлэл байж болохгүй.	Бэлгийн харилцааг ил тод, нарийвчилсан хөдөлгөөнтэй, хүчтэй сэтгэл хөдлөл, дуу авиа дагалдсан байдлаар дүрслэсэн бол радио, телевизийн нийтийн сувагаар түгээхгүй байх.
3	Бэлгийн агуулга ба садар самуун					

	Хүний нүцгэн биеийг харуулах	Бэлгийн утгагүй, хүний энгийн нүцгэн төрхийг хязгаарлагдмал хэмжээнд дүрслэх	Нүцгэн байдал нь цухас, тодорхой бус, бэлгийн утга агуулаагүй, богино хугацаатай, нөхцөл байдлын хүрээнд дүрслэгдсэн байна. Бие махбодыг үзүүлсэн тохиолдолд бэлэг эрхтэн, хөх, биеийн доод хэсгийг илт, тодоор харуулахгүй.	Энэхүү дүрслэл нь өсвөр насны хүүхдэд буруу ойлголт, сэдэл, өдөөлт төрүүлэхгүй байдлаар дүрслэх шаардлагатай.	Нүцгэн бие ил тод дүрслэгдэх бөгөөд бэлгийн агуулгатай байж болно. Гэвч садар самуун шинжтэй илэрхийлэл байж болохгүй.	Энэхүү дүрслэл нь кино театр, эхсүл Видео сан, төлбөртэй сувгуудад зөвшөөрөгдөх боловч телевизийн нийтийн сувагар нүцгэн байдлыг цухас, тодорхой бус, бэлгийн утгагүй, нөхцөл байдлаас шалтгаалсан байдлаар хязгаарлагдмал хүрээнд зөвшөөрнө. Бэлэг эрхтэн, хөх, биеийн доод хэсгийг ил тод харуулахгүй.
	Биеэ үнэлэх үйлдлийг харуулах	Биеэ үнэлэх үйлдлийг дүрслэн үзүүлэхгүй.	Биеэ үнэлэлтийг нийгэмд байх сөрөг үзэгдэл бөгөөд хувь хүний хөгжил, нийгмийн харилцаанд хор уршигтай гэсэн агуулгаар хэт задтай зураглал, гоёчилсон байдалгүй дүрслэх;	Энэхүү дүрслэл нь өсвөр насны хүүхдэд буруу ойлголт, сэдэл, өдөөлт төрүүлэхгүй байдлаар дүрслэх шаардлагатай.	Биеэ үнэлэлтийн үйлдлийг садар самуун хэв шинжгүй, амьдралын бодит үнэн дүр төрхөд нийцүүлэн, зохистой байдлаар дүрслэх;	Энэхүү сэдэв нь нийгмийн эмзэг, олон талт асуудалтай тулгардаг тул хүний эрхийг дээдэлсэн байдалд анхаарах шаардлагатай.

4	Мансууруулах бодис, архи, тамхи	Архи, тамхины хэрэглээг дүрслэх харуулах	Тамхины хэрэглээг хязгаартай, хөнгөн хэлбэрээр үйл явдлын орчны нэгэн хэсэг, соёлын элемент (гаансаар тамхи татах) байдлаар халт дүрслэхийг зөвшөөрөх;	Зохихолын учир холбогдлын дагуу, дүрийн зан байдлыг үзүүлэх зайлшгүй шаардлагатай бол архи, тамхийг гоёчилсон хэв маяггүй үзүүлэх эсвэл архи, тамхины сөрөг үр дагавар (архи, тамхины нөлөөгөөр эрүүл мэнд муудах, алдаа гарах гэх мэт)-ыг дүрслэнэ. Ингэхдээ насанд хүрээгүй хүүхэд архи, тамхи хэрэглэж байгаа байдлаар дүрслэхгүй.	Дүрүүд архи, тамхийг хэрэглэх нь тэднийг «эр зоригтой», «загваарлаг» гэх мэтээр харагдуулж өсвөр насны хүүхдэд даган дуурайх сэдэл төрүүлэхүйц байж болохгүй. Эдгээр нь сөрөг үйлдэл гэдгийг ухуулсан агуулгатай байвал зохино.	Архи, тамхины хэрэглээг бодитоор дүрслэх боломжтой. Ингэхдээ сурталчилгааны шинжийг агуулахгүй. Мөн эдгээр хорт зууршилд донтох сэтгэлзүйн үйл явц, бусадтай харилцах харилцаанд нөлөөлөх сөрөг үр дагаварыг ч бодитоор дүрслэх нь зохимжтой.	Энэ ангилалд архи, тамхины хэрэглээг илүү уян хатан дүрслэх ч гэсэн ёс зүй, уран сайхны шаардлага, нийгмийн хармуцлага гэсэн хүчин зүйлсийг зайлшгүй анхаарах хэрэгтэй.
---	---------------------------------------	---	--	--	--	---	--

		Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, үр нөлөөг харуулах	Ямар ч хэлбэрээр мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бодисыг тусгахгүй.	Боловсрол олгох ,нийгмийн зөв хандлагыг төлөвшүүлэх урьдчилан сэргийлэх зорилготой бүтээлд хязгаарлагдмал хэмжээнд зөвшөөрөгдөнө. Үүнд: • Эрүүл мэнд, нийгэмд үзүүлэх хор уршгийг тайлбарласан • Хууль эрхзүйн зохицуулалт, хориглолт, үр дагаврын талаарх мэдээлэл өгсөн • Урьдчилан сэргийлэх арга хэмжээ, тусламж, үйлчилгээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээ, тайлбар,баримтат контент Уран сайхны бүтээлд зөвшөөрөгдөх нөхцөл:	Агуулгын үзэл баримтлал чухал: • Сөрөг үр дагаврыг ойлгуулах, сургамж өгөх зорилготой дүрслэл байх. • Хэрэглээнээс татгалзах урам зориг,тусламж авах боломж, эерэг үлгэр дуурайлыг харуулсан бол зохимжтойд тооцно.	Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээний нээлттэй, тод томруун дүрслэл байж болно. Харин хуулиар хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хэрэглэхийг аргачлан заах, уг хэрэглээтэй холбоотой хэт задгай, зааварчилгаа шиг дүрслэл, агуулга хориглоно. Хуулиар хязгаарласан агуулгыг чанд мөрдсөн байх.	Мансууруулах бодис, архи, тамхины хэрэглээг харуулсан уран сайхны бүтээл нь нийгмийн асуудлыг хөндсөн, ёс суртахууны хэм хэмжээг баримтгасан, үзэгчдэд зөв үнэт зүйл, хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн агуулгатай байна. Уг хэрэглээтэй холбоотой хэт задгай, зааварчилгаа шиг дүрслэл, агуулга хориглоно.
--	--	---	--	---	--	---	---

• Ерөнхий үзэл санааг
хэрэглээний сөрөг үр
ддаагаар хариулах
• Мансууруулах
бодис хэрэглэх буй
сүр нь сөрөг дүр
байх ба, агуула
х нь уг үйлдлийг
шүүмжилсэн байр
суурь илхийсэн
байх
• Агуула нь хэрэглээг
сөдөх, сурталчлах
шинжгүй, эергээр
уулуулж шинжгүй
байх
Дүрслэл болон
илэрхийлэлд тавих
хязгаар. Үүнд:
• Хэрэглээний үйл
явц, нэр төрлийг
дэдлэгэнгүй,
дэдлэгэмтэй
харуулахгүй.
• Уянгын, баатарлаг,
хошин өнгө
харуураагүй, сөрөг
дүрлэг, сөрөг
дүрлэг эергээр
харгалдуулахгүй.

5	Хараалын үг, хэллэг	Дурийн хэл ярианд илрэх доромж үг, хэллэг	Ердийн доромж үгийг хязгаарлагдмал байдлаар агуулж болно.	Дурийн хувийн, онцгой зан байдлыг харуулах үүднээс ердийн доромж үгийг цөөн давталттай хэрэглэх; Энэхүү үг хэллэг нь нэн бүдүүлэг, эрээ цээргүй зохисгүй үг хэллэг (бэлгийн утгатай, улс төр, шашин, арьс өнгө, хүйсийн талаар бүдүүлэг үг хэллэг биш байх) хэрэглэхгүй байх	Энэхүү үг, хэллэг нь өсвөр үеийнхний насны онцлогт нийцэхгүй, ойлгоход хүнд, даган дуурайх сэдлийг төрүүлэхгүй байх;	Хараалын үг, бүдүүлэг хэллэгийн хэрэглээ онцгой хязгааргүй боловч давтамж нь хязгаартай, дурийн зан байдалтай нийцэж байх ёстой.	Нийтийн ярианы соёлыг хүндэтгэж, бүдүүлэг хэл яриаг сурталчлах бус дурийн зан байдал, сэтгэлзүйн онцлогтой уялдуулан учир шалтгаантай боловсруулсан байна.
6	Айдас төрүүлэх, сэтгэл зүйд нөлөөлөх дүрслэл	Хүний сэтгэл зүйн уналт: солилгол, сэтгэцийн эмгэг, эмгэг, хардалт, ганцаардал гэх мэт	Ерөнхийлөн дүрслэх	Хүний сэтгэл зүйн эмгэг байдал, сэтгэцийн эмгэгийг товч, шууд бус байдлаар дурдсан байж болох ч, уг агуулга нь нарийн дүрслэлгүй, сэтгэлзүйн хувьд өдөөлт өгөхгүй, зөвтгөсөн шинжгүй дүрслэл байна.	Эдгээр дүрслэл нь хэт айдас төрүүлэх, сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх дүрслэл байж болохгүй.	Хүний сэтгэл зүйн эмзэг байдал, сэтгэцийн эмгэгийг ил тод, нээлттэй дүрслэхдээ дүрслэлийн уран арга, уран сайхны илэрхийлэлийг баримтлан дүрслэх;	Үзэгчийн дотоод сэтгэл зүйд хэт айдас, түгшүүр, таагүй байдал төрүүлэхээс зайлсхийх

		Хүнд аймшигт төрүүлэхүйц дүр зураглал: <i>нийтлэг хамарсан золгүй осол, Хүнүй бие өөрчлөгдөх, задрах, гаж буруу болох, Бодит ба хийсвэр дүрслэл хосолсон, ойлгомжгүй, нууцлаг, айдас төрүүлэх дүрслэл, байгалийн гамшиг, араатан амьтны байралт гэх мэт</i>	Ерөнхийлөн дүрслэх	Зохиолын үйл явдлын орчны аймшигтай, аюултай, учир битүүлэг зэрэг нөхцөл байдлын уур амьсгалыг үзэгчид мэдрүүлэх зорилгоор товч, хэт хүнд дүрслэлгүй дүрслэн үзүүлэх;	Өсвөр насны хүүхдийн сэтгэхүүд цочирдол өгөхүйц, хэт хүчтэй дүрслэлийг хязгаарлана.	Аймшигт дүр зураг, аюулт нөхцөл байдлыг чөлөөтэй дүрслэх боловч дэлгэцийн бүтээлийн дүрслэн үзүүлэх гоо зүйг баримтлах;	Үзэгчийн дотоод сэтгэл зүйд хэт айдас, түгшүүр, таагүй байдал төрүүлэхээс зайлсхийх
--	--	---	--------------------	---	---	---	---

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 8 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар
хот

НЭРИЙН ДАНСНЫ 2025 ОНЫ ОРЛОГОД ТООЦОХ ХҮҮГИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.7 дахь хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.8 дахь хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Даатгуулагчдын тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны эцсийн үлдэгдэл, 2025 онд бүртгэсэн шимтгэлийн орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 11.28 хувиар баталсугай.

2. Баталсан хүүгийн хэмжээг үндэслэн даатгуулагчдын тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны эцсийн үлдэгдэл, 2025 онд бүртгэсэн шимтгэлийн орлогод тус тус хүү тооцох ажлыг 2026 оны 3 дугаар улиралд багтаан зохион байгуулж, даатгуулагчдыг шаардлагатай мэдээллээр хангаж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Б.Батжаргал)-т үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Г.Банзрагч)-нд даалгасугай.

ДАРГА

Т.АУБАКИР

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 7671 дүгээрт бүртгэв

МАЛ ЭМНЭЛЭГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 7 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар А/205

Улаанбаатар
хот

БИОБЭЛДМЭЛИЙН УЛСЫН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ, ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ХЭВИЙН ХОРОГДОЛ ТООЦОХ, БИОАЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ЭГҮҮЛЭН ТАТАХ, УСТГАХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь, 8.4 дэх хэсэг, Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Мал эмнэлгийн байгууллагын биобэлдмэлийн улсын нөөц бүрдүүлэх, хадгалах,тээвэрлэх, хэвийн хорогдол тооцох, биоаюултай хог хаягдлыг эгүүлэн татах, устгах журмыг нэгдүгээр хавсралтаар баталсугай

2.Тушаалын хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, мэргэжил аргазүйгээр хангаж ажиллахыг Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах газрын дарга (Б.Болдбаатар)-т, хяналт тавьж ажиллахыг мал эмнэлгийн хяналт баталгаажуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Чулуунчимэг)-т, тус тус даалгасугай.

3.Уг тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори, Малын эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар, өмчийн бүх хэлбэрийн мал эмнэлгийн байгууллагуудын дарга, захирал нарт даалгасугай.

4.Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг жил бүрийн төсөвтөө тусгахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Мягмаржав болон нийт харьяа байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Х. АЛТАНГЭРЭЛ

*Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын
2026 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн
А/205 дугаар тушаалын хавсралт*

БИОБЭЛДМЭЛИЙН УЛСЫН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ, ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ХЭВИЙН ХОРОГДОЛ ТООЦОХ, БИОАЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ЭГҮҮЛЭН ТАТАХ, УСТГАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь мал, амьтны халдварт, гоц халдварт, шинэ болон дахин сэргэж буй өвчнөөс урьдчилан сэргийлэхэд ашиглах биобэлдмэлийн улсын нөөцийг бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэх, хэрэглэх үеийн хэвийн хорогдлыг тооцох, биобэлдмэлийн үлдэгдэл, сав баглаа боодол болон бусад биоаюултай хог хаягдлыг эгүүлэн татах, халдваргүйжүүлэх, устгах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү үйл ажиллагаагаар биоаюулгүй байдлыг хангаж, хүний эрүүл мэнд, мал, амьтны эрүүл мэнд, хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хамгаална.

1.3. Энэхүү журмыг Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хууль, Хог хаягдлын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн 13.10 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлж хэрэгжүүлнэ.

1.4. Журмыг хэрэгжүүлэхдээ хуульд үндэслэх, ил тод, нээлттэй байх, шийдвэр нь үндэслэл бүхий байх, биоаюулгүй байдлыг хангах, хүний болон мал, амьтны эрүүл мэнд, хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг дээдлэх, эрсдэлд суурилсан удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг баримтална.

1.5. Энэхүү журам нь биобэлдмэлийн улсын нөөц бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэх, ашиглах, бүртгэх, хянах, биоаюултай хог хаягдлыг эгүүлэн татах, устгахтай холбогдох харилцаанд оролцогч төрийн байгууллага, хуулийн этгээд, мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, малын эмч, мэргэжилтэн болон бусад оролцогч этгээдэд хамаарна.

ХОЁР. БИОБЭЛДМЭЛИЙН УЛСЫН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ

2.1. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нөөц бүрдүүлэх биобэлдмэлийн жагсаалт, тоо хэмжээг мэргэжлийн зөвлөлийн зөвлөмжид үндэслэн жил бүр шинэчлэн батална.

2.2. Мал, амьтны халдварт, гоц халдварт, шинэ болон дахин сэргэж буй өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ашиглах биобэлдмэлийн нөөцийг тархвар зүйн нөхцөл байдал, бүс нутгийн онцлог, мал сүргийн

тоо толгой, бүтэц, байршил, вакцинжуулалтын хамрагдалт зэрэг үзүүлэлтийг цогцоор нь харгалзан нөөцийн нэр төрөл, тоо хэмжээг тодорхойлж холбогдох хууль тогтоомжид заасан захиргааны актын хэлбэрээр баталгаажуулна.

2.3.Дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжгүй, гоц халдварт болон хил дамжин тархах өндөр эрсдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх биобэлдмэлийн нөөцийг бүрдүүлэхдээ дотоодын болон бүс нутгийн улс орнуудын өвчний тархварзүйн мэдээлэлийг харгалзан тогтооно.

2.4.Биобэлдмэлийн нөөц бүрдүүлэх үйл ажиллагаанд оролцогч байгууллага, албан тушаалтнууд нь холбогдох хууль тогтоомж, энэхүү журмын шаардлагыг мөрдөж, нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалтад ил тод байдал, хариуцлагыг хангаж ажиллана.

2.5.Өвчний гаралт,дэгдэлтээс шалтгаалан нөөцийн биобэлдмэлийг хэрэглэнэ. Өвчний гаралт тайван үед нөөцөлсөн биобэлдмэлийн хүчинтэй хугацаа дуусах тохиолдол байж болно.

2.6.Нөөцөлсөн биобэлдмэлийг “Мал амьтны эм, биобэлдмэлийн бүртгэл мэдээллийн цахим систем”-ээр бүртгэж, зарцуулалт, үлдэгдэлд хяналт тавина.

2.7.Нөөцийн биобэлдмэлийг хадгалах хугацаа дуусахаас өмнө эргэлтэд оруулж, шинээр нөөц бүрдүүлнэ.

2.8.Нөөцийн биобэлдмэлийн хадгалалтын нөхцөл шаардлагыг энэхүү журмын 3 дугаар бүлгээр зохицуулна.

2.9.Нөөцөлсөн биобэлдмэлийн хадгалах хугацаа дууссан тохиолдолд энэхүү журмын 6 дугаар бүлгийн дагуу устгана.

ГУРАВ. БИОБЭЛДМЭЛИЙГ ХАДГАЛАХ

3.1.Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх биобэлдмэлийг үйлдвэрлэгчийн хэрэглэх зааварт заасан хадгалалтын нөхцөл, температурын горимыг мөрдөж, зориулалтын агуулах, хөргүүртэй өрөө, хөргүүрт хадгална.

3.2.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, биобэлдмэл үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь биобэлдмэлийг хадгалах зориулалтын агуулах, хөргүүртэй өрөө, автомашин, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байх бөгөөд хадгалалтын горим зөрчсөнөөс үүсэх үр дагаврыг хариуцна.

3.3.Биобэлдмэлийг хадгалах зориулалтын агуулахгүй тохиолдолд шаардлага хангасан агуулах, тоног төхөөрөмж бүхий аж ахуй нэгжтэй гэрээний үндсэн дээр биобэлдмэлийг хадгална.

3.4.Биобэлдмэлийг агуулахад агаар сэлгэх боломжтой байдлаар хадгална.

3.5. Сум, дүүргийн мал эмнэлгийн тасаг болон гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь биобэлдмэлийг хадгалах зориулалтын суурин болон зөөврийн хөргүүр, агуулахын өрөөтэй байх бөгөөд хадгалалтын горим зөрчсөнөөс үүсэх үр дагаврыг хариуцна.

3.6. Биобэлдмэл хадгалах агуулах, хөргүүрийн өрөө, хөргүүрт биобэлдмэлээс өөр бараа, бүтээгдэхүүн хадгалахыг хориглоно.

3.7. Биобэлдмэл хадгалах явцад температурын горимыг өдөр тутам, эсхүл автомат бүртгэлийн системээр тасралтгүй хянаж, бүртгэл хөтөлж, биобэлдмэлийн чанар, аюулгүй байдлыг хангана.

3.8. Импортоор нийлүүлэгдсэн биобэлдмэл нь хүйтэн хэлхээний температурын хяналтын мэдрэгч, индикатортой ирсэн тохиолдолд түүний заалтыг улсын байцаагч шалгаж, биобэлдмэлийг “мал, амьтны эм, биобэлдмэлийн бүртгэл мэдээллийн цахим систем” болон санхүүгийн бүртгэлд шилжүүлнэ.

3.9. Биобэлдмэлийг бүх шатанд хадгалах явцад сав баглаа, боодол, хаяг шошгын бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй байж, гэмтэл, зөрчил илэрсэн тохиолдолд дээд шатны чанар, аюулгүй байдал алдагдсан, алдагдах нөхцөл байдал үүссэн тохиолдолд хариуцагч нь эрх бүхий албан тушаалтанд яаралтай мэдэгдэж, шуурхай арга хэмжээ авна.

3.10. Биобэлдмэлийг хадгалахдаа нэр төрөл, тоо хэмжээ, цувралын дугаар, үйлдвэрлэсэн болон хүчинтэй хугацаа, хадгалалтын хэмийн бүртгэл, орлого, зарлагын хөдөлгөөнийг бүртгэлийн журналд тухай бүр бүртгэнэ.

3.11. Биобэлдмэлийн хадгалах үеийн температурын хэмийг өдөр тутам хянаж, бүртгэлийг хөтөлнө.

3.12. Биобэлдмэлийн хадгалалтын температурын бүртгэл, орлого, зарлагын бүртгэл хөтлөлтөд мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч хяналт тавьж ажиллана.

3.13. Хадгалалтын горим алдагдсан, чанар аюулгүй байдал алдагдсан нь тогтоогдсон биобэлдмэлийг ашиглах, хадгалах, түгээхийг хориглож, биоаюултай хог хаягдалд тооцон энэ журмын дагуу устгана.

ДӨРӨВ. БИОБЭЛДМЭЛИЙГ ТЭЭВЭРЛЭХ

4.1. Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх биобэлдмэлийг тээвэрлэхдээ үйлдвэрлэгчийн хэрэглэх зааварт заасан хадгалалтын горим, нөхцөлийг бүрэн хангаж, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

4.2. Биобэлдмэлийг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь тээвэрлэлтийн үеийн хэмийг тасралтгүй хянах төхөөрөмж, эсхүл зайнаас цахим системээр хянах мэдрэгч (sensor)-ээр тоноглогдсон байна.

4.3. Хэрэв тээврийн хэрэгсэл нь температурын тасралтгүй

хяналтын төхөөрөмжөөр тоноглогдоогүй тохиолдолд тээвэрлэлтийн явцад хэмийн хяналтыг мэргэжилтэн гүйцэтгэж, тодорхой давтамжаар (дор хаяж 4 цаг тутам) хэмийн бүртгэлийг хөтөлж баталгаажуулна.

4.4.Тээвэрлэлтийн үеийн хэмийн бүртгэлийг хоёр хувь үйлдэж, нэг хувийг хүлээн авагч байгууллагад, нөгөө хувийг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчид тус тус хүлээлгэн өгнө.

4.5.Тээврийн хэрэгсэлээр биобэлдмэлийг агаар сэлгэх боломжтой байдлаар тээвэрлэнэ.

4.6.Аймаг, нийслэл, сум, дүүргийн мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нь тээвэрлэлтийн үеийн хэмийн бүртгэлийг хянаж, тэмдэглэл үйлдэн биобэлдмэлийг хүлээн авна. Хэрэв тээвэрлэлтийн горим алдагдсан нь нотлох баримт (температурын бүртгэл, мэдрэгчийн мэдээлэл зэрэг)-аар тогтоогдсон тохиолдолд тухайн биобэлдмэлийг хүлээн авахаас татгалзана.

4.7.Гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь биобэлдмэлийг хүлээн авснаас хойш мал, амьтанд хэрэглэж дуусах хүртэлх хугацаанд хүйтэн хэлхээний горимыг бүрэн хангаж, түүний зөрчлөөс үүсэх хохирлыг хариуцна.

4.8.Биобэлдмэлийн тээвэрлэлтийн явцад температурын горим алдагдаж, чанарын шаардлага хангахгүй болсон нь тогтоогдсон тохиолдолд тухайн биобэлдмэлийг ашиглахыг хориглож, биоаюултай хог хаягдалд тооцон энэ журмын дагуу устгана.

4.9.Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн явцад хүйтэн хэлхээний горим алдагдсанаас үүсэх хохирол, гарсан зардлыг бүрэн хариуцна.

ТАВ. БИОБЭЛДМЭЛИЙГ ХЭРЭГЛЭХ ҮЕИЙН ХЭВИЙН ХОРОГДОЛ ТООЦОХ

5.1.Биобэлдмэлийг задалсан, найруулснаас хойш тухайн биобэлдмэлийн хэрэглэх батлагдсан зааварт заасан хугацаанд бүрэн хэрэглэж амжаагүй үлдсэн болон зүү, тариур, лонхонд тунлагдаагүй /сорогдоогүй/ үлдсэн болон тариур шалгах үед шахагдсан биобэлдмэлийг хэвийн хорогдолд тооцно.

5.2.Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх биобэлдмэлийг мал, амьтанд хэрэглэх явцад үүсэх хэвийн хорогдлын нормативыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар батална.

5.3.Биобэлдмэлийн хэвийн хорогдлын нормативыг тогтоох судалгааг мал эмнэлгийн мэргэжлийн болон холбогдох судалгааны байгууллага, мэргэжлийн төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор гүйцэтгүүлнэ.

5.4.Гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь биобэлдмэлийн зарцуулалт, мал, амьтны дархлаажуулалтын бүртгэл, тайланг гаргахдаа

батлагдсан хэвийн хорогдлын нормативыг мөрдөж тооцно.

5.5.Хэвийн хорогдлын нормативыг мөрдсөн эсэхэд улсын байцаагч хяналт тавьна.

5.6.Хэвийн хорогдлын нормативыг үндэслэлгүйгээр хэтрүүлсэн, буруу тооцсон, эсхүл зориудаар зөрчсөн нь тогтоогдсон тохиолдлыг зөрчилд тооцож, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.7.Сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нь гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн биобэлдмэлийн зарцуулалт, хэвийн хорогдол, мал, амьтны дархлаажуулалтын бүртгэл, тайланд хяналт тавина.

ЗУРГАА. БИОАЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ЭГҮҮЛЭН ТАТАХ, УСТГАХ

6.1.Дараах биобэлдмэл, материалуудыг биоаюултай хог хаягдалд тооцно:

6.1.1.Хадгалалтын хугацаа дууссан,

6.1.2.Чанарын баталгаажуулалтгүй,

6.1.3.Монгол улсын малын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, хуурамч, гарал үүсэл тодорхойгүй биобэлдмэл,

6.1.4.Хадгалалт, тээвэрлэлтийн горим алдагдсан,

6.1.5.Хил, гаалийн байгууллагаар бүртгэгдээгүй дотоодод нэвтрүүлсэн,

6.1.6.Хэрэглэсэн биобэлдмэлийн үлдэгдэл,

6.1.7.Хоосон сав,

6.1.8.Бусад

6.2.Энэ зүйлийн 6.1-д заасан биоаюултай хог хаягдлыг ашиглах, хадгалах, худалдах, түгээхийг хориглоно.

6.3.Мал эмнэлгийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь биоаюултай хог хаягдлыг эгүүлэн татах, устгах ажлыг үйлдвэрлэгч, нийлүүлэгчтэй хамтран зохион байгуулна.

6.4.Дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх албан ёсны зөвшөөрөлтэй байгууллагатай гэрээ хийж, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газартай хамтран ажиллана.

6.5.Мал эмнэлгийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын баталсан стандарт ажиллагааны зааврын дагуу аюултай хог хаягдлыг устгах ажлыг зохион байгуулна.

6.6.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь биобэлдмэлийг хэрэглэж дууссаны дараах үлдэгдэл, шил сав, вакцины үлдэгдэл зэрэг биоаюултай хог хаягдлыг бүртгэл, тэмдэглэл үйлдэн сум, дүүргийн мал эмнэлгийн тасагт хүлээлгэн өгнө.

6.7.Сум, дүүргийн мал эмнэлгийн тасаг нь хүлээн авсан биоаюултай хог хаягдлыг төвлөрүүлж, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газарт

хүлээлгэн өгнө.

6.8.Мал, амьтны гоц халдварт өвчин гарсан голомтын бүс нутагт дархлаажуулалтад хэрэглэсэн биобэлдмэлийн үлдэгдэл, сав баглаа боодлыг Мал эмнэлгийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын баталсан стандарт ажиллагааны зааврын дагуу (аюултай хог хаягдлыг) улсын байцаагчийн хяналтын дор устгана.

6.9.Аюултай хог хаягдлыг дагалдах бичигт заасан хог хаягдал мөн эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалган гарын үсэг зурж, тулган хүлээн авна.

6.10.Аюултай хог хаягдлыг эгүүлэн татах, хүлээн авах зорилгоор тээвэрлэхдээ Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах,тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам”-ыг баримтлана.

6.11.Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар нь стандарт ажиллагааны заавар болон аюултай хог хаягдал устгах албан ёсны зөвшөөрөлтэй байгууллагаар устгах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

6.12.Биобэлдмэл үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь гэрээний дагуу хүлээн авсан, эгүүлэн татсан биоаюултай хог хаягдлыг холбогдох стандарт ажиллагааны заавар, шаардлагад нийцүүлэн ариутгаж, аюулгүй болгон устгана.

6.13.Биоаюултай хог хаягдлыг устгахдаа комисс томилж, үйл ажиллагааг баримтжуулан устгалын актын үйлдэж, зураг, бичлэг зэрэг нотлох баримтаар баталгаажуулна.

6.14.Устгалын акт нь устгасан бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, цувралын дугаар, устгалын арга, огноо, байршил, комиссын бүрэлдэхүүн, оролцогч этгээдийн гарын үсгийг агуулсан байна.

6.15.Биоаюултай хог хаягдлыг устгасан тухай тэмдэглэл, нотлох баримтыг дээд шатны байгууллагад тухай бүр тайлагнаж, архивлана.

6.16.МЭЭГ, АНМЭГ-аас аюултай хог хаягдлыг хадгалах, устгах, эгүүлэн татах, үйл ажиллагааны талаар оролцогчдод сургалт зохион байгуулна.

6.17.Биоаюултай хог хаягдлыг устгаагүй, буруу хадгалсан, хууль бусаар ашигласан, устгалын бүртгэл, акт хөтлөөгүй үйлдлийг хууль зөрчсөнд тооцож, Зөрчлийн тухай хуулийн 13.10 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.18.Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лаборатори нь аюултай хог хаягдлыг цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх албан ёсны зөвшөөрөлтэй байгууллагаар гэрээний дагуу устгуулна.

ДОЛОО. ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ

7.1. Энэхүү журмын хэрэгжилтэд мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүх шатны мал эмнэлгийн хяналтын улсын (ахлах) байцаагч хяналт тавина.

7.2. Мал эмнэлгийн хяналтын улсын (ахлах) байцаагч нь биобэлдмэлийн улсын нөөц бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэх, ашиглах, хэвийн хорогдол тооцох, биоаяуултай хог хаягдлыг эгүүлэн татах, устгах үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт явуулна.

7.3. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг тогтоосон хугацаанд арилгуулах талаар албан шаардлага, дүгнэлт, акт үйлдэж, холбогдох этгээдэд хүргүүлэн хэрэгжилтийг хянаана.

7.4. Иргэн, аж ахуй нэгж байгууллагаас ирсэн мэдээлэл, гомдлыг хянан шийдвэрлэж, хариу мэдэгдэнэ. Мэдээлэгчийн нэрийг нууцалж, хамгаалах арга хэмжээ авна.

7.5. Хадгалалт, тээвэрлэлтийн горим зөрчсөнөөс үүсэх үр дагаврыг гэрээлэгч талуудын буруутай тал хариуцна.

7.6. Энэхүү журмыг зөрчсөн үйлдэл нь Зөрчлийн тухай хуулийн 13.10 дугаар зүйлд заасан зөрчилд хамаарах бөгөөд тухайн зөрчилд холбогдох этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 7672 дугаарт бүртгэв

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 7 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 86

Улаанбаатар
хот

НОРМАТИВЫН БАРИМТ БИЧГИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.“Харилцаа холбооны цамхгийн байгууламжийн суурилуулалт”-ын норматив баримт бичгийг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР
Ц.ГАНЗОРИГ
Б.ДАГВАСҮМБЭРЭЛ
Ч.ЗОЛБАЯР
С.ТАМИР
А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
НОРМ БА ДҮРЭМ

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЦАМХГИЙН
БАЙГУУЛАМЖИЙН СУУРИЛУУЛАЛТ

ХХН6Д-02

Албан ёсны хэвлэл

Улаанбаатар хот
2026 он

*Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны 07 дугаар сарын
09-ний өдрийн 86 дугаар тогтоолын хавсралт*

1. ХАМРАХ ХҮРЭЭ

1.1.Энэхүү норм ба дүрэм нь харилцаа холбооны цамхаг байгуулахад тавих ерөнхий шаардлагыг тогтоож, харилцаа холбооны сүлжээ, хөдөлгөөнт холбоо, утасгүй холбоо болон радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн зориулалтаар холбооны цамхаг барьж байгуулах, угсрах, ашиглахад хэрэглэнэ.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

2.1.Энэхүү норм ба дүрэмд дараах эш татсан баримт бичгийг хэрэглэнэ. Хугацаа заасан эшлэлийн хувьд эш татсан хэвлэл, харин хугацаа заагаагүй эшлэлийн хувьд хамгийн сүүлийн хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

2.2.MNS 4990:2015, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага

2.3.MNS 2361:1977 Дамжуулан нэвтрүүлэх радио зангилааны станц болон утсан холбооны суурин төхөөрөмжийн газардуулга

2.4.MNS 5762:2007, Цамхагт суурилуулсан антен фидерийн байгууламж. Аюулгүй ажиллагааны шаардлага

2.5.MNS 5594: 2020 "Цахилгаан орон, соронзон орон ба цахилгаан соронзон оронгоос хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшин (ОГц - 300ГГц хүртэл)"

2.6.MTSFB 001:2023, Малайз "Радио холбооны сүлжээний дэд бүтцийн техникийн стандарт ба дэд бүтцийн шаардлага"

2.7.ANSI/TIA-222-G, "Антен ба антены цамхгийн бүтцийн стандарт"

3. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

Энэ норм ба дүрэмд дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1.ажлын тавцан

цамхагт антен болон дагалдах төхөөрөмжийг угсрах, суурилуулах, ашиглалт, засвар үйлчилгээ хийхээр цамхагт ажиллах инженер, техникийн ажилтнуудын ажиллах, түр амрах зориулалт бүхий аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан, тодорхой өндөрт байрласан, нээлхийтэй болон нээлхийгүй хамгаалагдсан талбай;

3.2.цамхаг

харилцаа холбооны антен, радио тоног төхөөрөмж түүнд шаардлагатай цахилгаан тэжээл, сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжийг газрын гадаргаас дээш тодорхой өндөрт байрлуулах зориулалт бүхий байгууламжийг;

3.3.антен

цахилгаан соронзон долгионыг дамжуулах, хүлээн авах зориулалт бүхий радио холбооны төхөөрөмжийг;

3.4.нэг маягийн зураг

эрх бүхий байгууллагаар баталгаажуулж, ижил төрлийн байгууламжид давтан хэрэглэхээр зөвшөөрөгдсөн зураг төслийн баримт бичгийг.

3.5.зураг төсөл

цамхгийг төлөвлөх, барьж байгуулах, суурилуулах, угсрах, ашиглалтад оруулах ажил гүйцэтгэхэд шаардагдах загвар зураг /эскиз/, техникийн болон ажлын зураг, инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг;

3.6.хамгаалалтын зурвас

цамхаг, антены суурийн эргэн тойронд хуулиар тогтоосон хамгаалалтын стандарт бүс

3.7.ядралын зэрэг (насжилт)

Давтагдах ачаалал, орчны нөлөөллийн улмаас бүтээцийн материалын механик шинж чанар буурч, ашиглалтын найдвартай байдал доройтох үзэгдлийг;

3.8.Ган хоолойт цамхаг (Monopole Tower)

Нэг үндсэн тулгуур их биетэй, ган хоолой эсхүл төмөр бетон хийцээр хийгдсэн цамхгийг;

3.9.Угсармал цамхаг (Lattice Tower)

Ган булан төмөр, хоолой болон бусад ган элементийг угсарч бүрдүүлсэн сараалжин бүтээцтэй цамхгийг;

3.10.Татлагат цамхаг (Guyed Tower)

Татлагаар тогтворжуулсан өндөр цамхгийг;

3.11.Тусгай тоноглолт цамхаг (Camouflage Tower)

Орчны өнгө үзэмж, архитектурын шаардлагад нийцүүлэн өнгөлөн далдлах буюу тусгай хийцээр тоногдосон цамхгийг.

3.12.Газардуулгын систем

Цамхаг болон түүнд холбогдох тоног төхөөрөмжийг цахилгаан болон аянгын нөлөөллөөс хамгаалах зориулалттай газардуулгын иж бүрэн байгууламжийг.

4. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

4.1.Радио долгион ашиглаж цахилгаан холбоо, үүрэн холбоо, хөдөлгөөнт болон утасгүй холбооны системүүдэд нэвтрүүлэх хүлээн авах антеныг газрын гадаргаас дээш тодорхой өндөрт байрлуулж дамжуулал хийх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор харилцаа холбооны цамхаг ашиглана.

5. ЦАМХГИЙН ТӨРӨЛ, ХИЙЦ ЗАГВАР БА ХЭМЖЭЭ

5.1. Харилцаа холбооны цамхгийг хийц, бүтцийн онцлогоос нь хамааруулан дараах төрөлд ангилна.

5.1.1. Ган хоолойт цамхаг (monopole tower)

5.1.1.1. Хөндий огтлолтой шон хэлбэрийн цамхаг (monopole)

Нэг үндсэн тулгуур биетэй, хөндий огтлолтой шон хэлбэрийн, ган хоолой эсхүл төмөр болон бетон хийцээр хийгдсэн цамхгийг;

5.1.1.2. Нийтийн эзэмшлийн зам талбайд байрлуулахад зориулсан антен болон холбооны тоног төхөөрөмж суурилуулах бага оврын тулгуур байгууламжийг;

5.1.2. Угсармал цамхаг (Lattice tower)

5.1.2.1. Булан төмөр хийцтэй угсармал цамхаг /Angular tower/

5.1.2.2. Төмөр хоолойт хийцтэй угсармал цамхаг /Tubular tower/

Угсармал цамхаг нь гурвалжин, дөрвөлжин, конус эсхүл шулуун хэлбэрийн хийцтэй байж болно.

5.1.3. Тусгай тоноглолт цамхаг (decorated/camouflage)

5.1.1, 5.1.2-т заасан цамхгуудыг орчны өнгө үзэмж, архитектурын шаардлагад нийцүүлэн өнгөлөн далдлах байдлаар эсхүл тусгай хийцээр тоноглогсон цамхгийг;


5.1.4. Татлагат цамхаг (Guyed Tower)

Татлагаар тогтворжуулсан өндөр цамхгийг;

5.2. Цамхгийн татлага

Цамхгийг татлагатай байх эсэхийг тогтворын тооцоонд үндэслэнэ.

5.3. Цамхгийн үндсэн төрлүүдийн жишээ зургийг зураг 1-т харуулав.



1-р зураг Цамхгийн төрлүүд

5.4.Хэрэглээ, захиалагчийн шаардлага, орчны өнгө үзэмж, газар зүйн байрлал, радио долгионы тархалт зэрэг хүчин зүйлүүдээс хамааруулан аль нэг загварыг сонгон ашиглана. Мөн эдгээр загваруудыг гоёл чимэглэлийн байдлаар тоноглон ашиглаж болно.

5.5.Харилцаа холбооны зориулалтаар ашиглах цамхаг нь түүний төрлөөс хамаарч 1-р хүснэгтэд үзүүлсэн өндөртэй байна.

1-р хүснэгт. Цамхгийн төрөл, үйлчилгээ ба өндрийн хамаарал

Цамхгийн төрөл	Ашиглалтын зориулалт	Өндрийн хэмжээ
Ган хоолойт (monopole)	Радио, телевизийн өргөн нэвтрүүлэг, Хөдөлгөөнт холбоо, Цэгээс цэгт радио дамжуулал	60м хүртэл
Угсармал, Татлагат цамхаг	Радио, телевизийн өргөн нэвтрүүлэг, Хөдөлгөөнт холбоо, Цэгээс цэгт радио дамжуулал	120м хүртэл ба түүнээс дээш

6. ЦАМХАГ БАЙГУУЛАХАД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

6.1.Харилцаа холбооны үйлчилгээний зориулалтаар шинээр цамхаг байгуулахдаа дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

6.1.1.Үйлчилгээний зориулалт, хамрах хүрээ, техникийн шаардлага, инженерийн тооцоонд үндэслэн цамхгийн төрөл, өндөр байршлыг сонгоно.

6.1.2.Цамхаг нь эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан зураг төсөлтэй байна.

6.1.3.Инженер геологийн судалгаа, шинжилгээ хийлгэсэн байна.

6.1.4.Цамхгийн угсралтын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэсэн байна.

6.1.5.Цамхаг нь газардуулга болон аянга хамгаалалтын системтэй байна.

6.1.6.Цамхагт шаардлагатай гэрэлтүүлэг, таних тэмдэглэгээг суурилуулсан байна.

6.1.7.Хамгаалалтын хашаатай байна.

6.1.8.Цамхгийг захиалагч болон холбогдох байгууллагын хяналт шалгалтаар баталгаажуулж ашиглалтад хүлээн авсан байна.

6.2.Ашиглалтад хүлээн авсан акт, зураг төсөл, инженерийн тооцоо, туршилт хэмжилтийн үр дүн болон бусад холбогдох баримт бичгийг цамхгийг эзэмшигч архивлан хадгална.

6.3.Цамхгийн угсралт, суурилуулалтын ажлыг харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ.

6.4.Өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам ба цамхаг хоорондын хамгийн бага зайг тогтоохдоо эрх бүхий байгууллагаас баталсан “Цахилгаан байгууламжийн дүрэм”-ийн 2-р бүлгийг мөрдлөг болгоно.

7. ЦАМХГИЙН ЗУРАГ ТӨСӨЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 7.1.Зураг төсөл нь “Нэг маягийн” эсхүл “Нэг удаагийн” зураг байна.
- 7.2.Зураг төслийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, эрх бүхий байгууллагын магадлалаар баталгаажуулсан байна.
- 7.3.Ажлын зураг төсөлд дараах мэдээллийг тусгасан байна. Үүнд:
 - 7.3.1.Цамхагт байрлах антены тоо, хэмжээ, жин;
 - 7.3.2.Фидер болон кабелийн ачаалал;
 - 7.3.3.Цамхгийн хийц бүтээцийн төрөл;
 - 7.3.4.Ашиглах материалын төрөл, хэмжээ
 - 7.3.5.Бэхэлгээний зохион байгуулалт,
 - 7.3.6.Салхины хүч, даралт тооцсон байдал;
 - 7.3.7.Хөрс, газар хөдлөлтийг тооцсон байх;
 - 7.3.8.Газардуулга болон аянга хамгаалалтын шийдэл;
 - 7.3.9.Ашиглалтын хугацааны тооцоо;

8.ЦАМХГИЙН БАЙРШИЛД ТАВИХ ШААРДЛАГА

8.1.Цамхагт байрлах харилцаа холбооны төхөөрөмжүүдээс үүсэх радио давтамжийн цацаргалтын чадал нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн хувьд холбогдох стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэхгүй байна.

8.2.Сургууль, цэцэрлэг, эмнэлэг болон хүн ам олноор төвлөрсөн бүсэд цамхаг байгуулах тохиолдолд MNS 5594:2020, Радио давтамжтай цахилгаан соронзон орны хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшин (3 кГц-ээс 300 ГГц хүртэл) стандартын дагуу зохих хэмжилтийг хийлгэж, стандартын шаардлагыг хангасан байна.

8.3.Харилцаа холбооны цамхаг нь гал түймрийн аюулгүй байдлыг хангах хамгаалалтын зурвастай байна.

8.4.Харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хувьд техникийн болон радио давтамжийн хувьд өөр хоорондоо харилцан нөлөөлөл үүсэхээргүй тохиолдолд нэг байрлалд, нэг цамхаг ашиглах зарчмыг баримтална.

8.5.Хамтран ашиглах боломжгүй тохиолдолд цамхгийн байршил, хоорондын зай, бүтээцийн аюулгүй байдал, радио давтамжийн харилцан нөлөөлөл, ашиглалтын нөхцөлийг харгалзан зураг төслөөр тогтооно.

8.6.Зайлшгүй шаардлагатай тохиолдолд цамхгийг өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамаас цамхгийн өндрийн 120%-аас багагүй зайд байгуулна.

8.7.Цамхгийн хийц, загвар, өндөр болон байршлаас хамаарч нийтийн болон хувийн эзэмшлийн зам, талбайгаас алслагдах хэмжээ нь 2-р хүснэгтэд заасан хэмжээнээс багагүй байна.

2-р хүснэгт. Цамхгийн нийтийн эзэмшлийн зам, талбайгаас алслагдах хамгийн бага зай;

Цамхгийн өндөр (м)	30м хүртэл	30м-60м хүртэл	60м-ээс дээш
Нийтийн эзэмшил зай талбайгаас	3м-ээс багагүй	5м-ээс багагүй.	10м-ээс багагүй.
Хувийн эзэмшлийн зай талбайгаас	1м -ээс багагүй	3м-ээс багагүй.	5м-ээс багагүй

8.8.Цамхгийн байршлыг сонгохдоо хот байгуулалт, газрын ашиглалт, байгаль орчин, нисэхийн аюулгүй байдал болон холбогдох бусад шаардлагыг харгалзан үзнэ.

9. ЦАМХАГТ ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

9.1.Цамхгийн байршил, өндөр, бүтээцийн төрөл, антен болон тоног төхөөрөмжийн ачааллаас хамааран суурийн хэмжээ, хамгаалалтын бүс болон шаардлагатай талбайн хэмжээг инженерийн тооцоогоор тодорхойлно.

9.2.Цамхгийн бүтээц нь өөрийн жин, антен, фидер, кабель, шат, ажлын тавцан болон бусад тоног төхөөрөмжийн ачааллыг аюулгүй даах чадвартай байна.


9.3.Цамхгийн үндсэн бүтээцийн холболт, боолт, анкер болон бэхэлгээ нь тооцоот ачааллыг найдвартай даах чадвартай байна.

9.4.Татлагат цамхаг байгуулахад шаардагдах нийт талбайн хэмжээ, түүний татлага утас, бэхэлгээний байрлах талбайг оролцуулан тооцоолох ба энэ нь тухайн цамхгийн өндрийн 80 хувиар тодорхойлогдоно.

9.5.Татлагат цамхаг байгуулахад шаардагдах хамгийн бага талбайн хэмжээ нь тэгш өнцөгт хэлбэртэй байх бөгөөд урт тал нь цамхгийн өндрийн 139%-аас багагүй, богино тал нь цамхгийн өндрийн 120%-аас багагүй байна (2а зураг, 3-р хүснэгт)

9.6.Татлагат цамхаг байгуулахад шаардагдах тохиромжит талбайн хэмжээ нь квадрат хэлбэртэй байх бөгөөд талууд нь цамхгийн өндрийн 139%-аас багагүй байна (2b зураг ба 3-р хүснэгт).

9.7.Гурван татлага ашигласан тохиолдолд шаардагдах талбайн хэмжээг хамгийн бага хэмжээгээр (2а зураг), 3-аас дээш татлага ашигласан тохиолдолд шаардагдах талбайн хэмжээг тохиромжит хэмжээгээр (2b зураг) тодорхойлно.



2-р зураг - Татлагат цамхаг байгуулахад шаардагдах талбайн хэмжээ
а. Хамгийн бага хэмжээ б. Тохиромжтой хэмжээ

3-р хүснэгт - Татлагат цамхаг байгуулахад шаардагдах талбайн хэмжээ

Тохиромжит талбай		Хамгийн бага талбай	
Цамхгийн өндөр (м)	Талбайн хэмжээ (м х м)	Цамхгийн өндөр (м)	Талбайн хэмжээ(м х м)
10	27x27	10	16x27
20	31x31	20	27x31
30	45x45	30	39x45
40	59x59	40	51x59
50	73x73	50	63x73
60	86x86	60	75x86
70	100x100	70	87x100
80	114x114	80	99x114
90	128x128	90	111x128
100	142x142	100	123x142
110	156x156	110	135x156
120	170x170	120	147x170
130	184x184	130	159x184
140	198x198	140	171x198
150	211x211	150	183x211

9.8.Угсармал цамхаг нь хийцийн хувьд 3 хөлтэй эсвэл 4 хөлтэй байна.

9.9.Гурван хөлтэй угсармал цамхгийн суурийн тэгш өнцөг үүсгэж байгаа талуудад тус тус 1 хөл нь байрлах ба талуудын урт нь цамхгийн өндрөөс хамаарч 4-р хүснэгтэд үзүүлсэн байдлаар тодорхойлогдоно.

4-р хүснэгт - Гурван хөлтэй угсармал цамхаг байгуулахад
шаардагдах хамгийн бага талбайн хэмжээ

Цамхгийн өндөр (м)	Урт талын хэмжээ(м)	Өргөн талын хэмжээ(м)
10	8	7
15	9	8
25	10	9
30	11	10
40	12	11
45	13	12
55	14	13
60	15	14
70	16	15
80	17	16
85	18	17
90	19	18
100	20	19
105	21	20
120	22	21

9.10.Дөрвөн хөлтэй угсармал цамхгийн суурийн талууд нь цамхгийн
өндрөөс хамаарч 5-р хүснэгтэд үзүүлсэн байдлаар тодорхойлогдоно.

5-р хүснэгт - Дөрвөн хөлтэй угсармал цамхаг байгуулахад
шаардагдах хамгийн бага талбайн хэмжээ

Цамхгийн өндөр (м)	Талын уртын хэмжээ (м)
10	6
15	7
25	8
30	9
40	10
45	11
55	12
60	13
70	14
80	15
85	16
90	17
100	18
105	19
120	20

9.11.Цамхгийн хүлээгдэж буй ашиглалтын хугацаа нь гучин (30)
жилээс доошгүй байх ба дизайн, үйлдвэрлэх материал, суурилуулах

арга хэрэгслүүд, аюулгүй байдлын хүчин зүйл болон цамхгийн ачаалал нь стандартад нийцэж, хүлээгдэж буй ашиглалтын хугацаанд үргэлжлэх ёстой.

9.12.Цамхгийн их биеийн бүх хэсгүүд нь мушгирах, мушгирахаас сэргийлж шулуун дөрвөлжин хэлбэртэй байна.

9.13.Цамхгийн бэхэлгээний тохиргоо, тэнхлэгийн суурийн хэсгүүдийг бүхэлд нь ган, цайрдсан хоолойгоор хийнэ.

9.14.Гулсах холбооснууд нь залгаас дахь туйлын диаметрээс хамгийн багадаа 1.5 дахин их давхцах, хоолойн голч нь доороос дээш доошоо буурсан байдалтай байна.

9.15.Хүссэн өндөрт хүрэх хүртэл хоолойнууд нь нэг нь нөгөөгийнхөө оройд таарч байхаар нарийссан байх, хоолойн хоорондох холбооснууд давхацсан байна.

9.16.Давхардлын гүн, суурийн өргөн, багана дахь хоолойн тоо нь хүлээгдэж буй цамхгийн өндөр, хананы зузаан, суурийн диаметр, цамхагт бэхлэгдсэн байдлаас хамаарна.

9.17.Цамхгийн хөл хөшүүн байдлыг сайжруулж, мушгирах, найгахад тохиромжтой байлгах үүднээс гуурсан эсвэл цул байна.

9.18.Цамхгийн их биед цахилгаан тэжээлийн болон радио давтамжийн дохио дамжуулах кабель, фидер, долгион хөтлүүрийг бэхлэх, тогтоох зориулалтын тавиурыг суурилуулсан байна. Тавиур нь авирах шатны орчимд хүний гар хүрэх зайд байрласан байна. Ингэхдээ цамхгийн тэнцвэрт байдлыг тооцож үзнэ.


10.ЦАМХГИЙН ТОНОГЛОЛ БОЛОН СУУРИЛУУЛАЛТЫН ШААРДЛАГА

10.1.Цамхаг нь ашиглалт, засвар үйлчилгээний ажлыг аюулгүй гүйцэтгэх нөхцөлийг хангасан авирах шат, ажлын болон амрах тавцантай байна.

10.2.Цамхгийн өндрийн 20 м тутамд түр амрах тавцан, антен суурилуулах цэг бүрд ажлын тавцан тус тус байрлуулна.


10.3.Ажлын тавцангийн хамгаалалтын хашлага нь 1,2 м-ээс багагүй өндөртэй, хоёроос доошгүй хамгаалалтын хөндлөн эсхүл чагтан хашилт төмөртэй, 3 ба түүнээс дээш талтай, эсвэл тойрог хэлбэртэй байна.

10.4.Цамхагт авирах шат (3-р зураг) заавал байх ба шатны өргөн нь 45 см-ээс багагүй, гишгүүр хоорондын алхам нь нэгэн жигд, зай нь 30 см-ээс ихгүй байх ба 150 кг хүртэлх ачааны даацтай байна. Гишгүүрийн өргөний хэмжээ нь 16 мм-ээс 22 мм-ийн хооронд байна.



3-р зураг – Цамхгийн шатны жишиг зураг

- 10.5.Цамхагт 5 м-ээс дээш өндөртэй цамхагт ажиллагсдыг гэдэрэг унахаас сэргийлж 3 м өндрөөс эхлэн авирлах шатанд нум хэлбэрийн хаалт хийнэ.
- 10.6.Цамхагт 20 м болон түүнээс дээш цамхагт авирч буй ажилтныг уналтаас хамгаалах, уналтыг сааруулах зориулалт бүхий уналтаас хамгаалах системийг (4-р зураг) цамхгийн шатанд бэхэлнэ.
- 10.7.Нум хэлбэрийн хаалтын гол цэг ба шатны гишгүүр хоорондын зай 80 см-ээс багагүй байх ба тэдгээрийг хооронд нь 3-аас дээш босоо холбоосоор холбосон байна.
- 10.8.Авирах шат нь амрах тавцангаас дээш үргэлжлэх тохиолдолд шатны үргэлжлэл нь ажилтны аюулгүй байдлыг хангахуйц байрлалтай байна.
- 10.9.Авирах шатны хажуу ирмэг дагуулан кабелийн замчлалыг суурилуулна. Тэгэхдээ цамхгийн тэнцвэрт байдлыг тооцож үзнэ.
- 10.10.10м-ээс дээш өндөртэй цамхагт 10м тутам фидер газардуулах зориулалтын шин суурилуулна.



4-р зураг - Цамхагт ажиллагсдыг уналтаас хамгаалах системийн жишиг зураг

10.11.Цамхгийн эргэн тойронд аюулгүй байдлыг хангах үүднээс хамгаалалтын хашаатай байж болно. Энэ хашаа нь тухайн орчны нөхцөл, тохижилтод нийцсэн байна.

10.12.Антен, радио холбооны төхөөрөмж болон тэдгээрийн дагалдах тоноглолыг үйлдвэрлэгчийн заавар, зураг төслийн шийдлийн дагуу зориулалтын бэхэлгээ ашиглан суурилуулна.

10.13.Радио төхөөрөмжийг суурилуулах байршлыг цамхгийн бүтээцийн даац, ашиглалтын аюулгүй байдал болон засвар үйлчилгээний нөхцөлийг харгалзан тогтооно.

10.14.Холболтын болон тэжээлийн кабелиудыг их биед тусгай зориулалтын төмөр хомучик, хуванцар чангалагч ашиглан бэхэлнэ.

10.15.Кабелийн бэхэлгээг үйлдвэрлэгчийн заасан зай хэмжээний дагуу гүйцэтгэх бөгөөд босоо чиглэлд байрлах кабелийг 1.0 м-ээс ихгүй зайтайгаар бэхэлсэн байна.

10.16.Цамхагийг цахилгааны үндсэн тэжээлд холбогдсон байна. Хөдөө орон нутагт нар, салхины гэх мэт сэргээгдэх эрчим хүч ашиглаж байна. Аль тохиолдолд цахилгааны нөөц холболттой байна.

11. ЦАМХГИЙН ГЭРЭЛТҮҮЛЭГ БА ТЭМДЭГЛЭГЭЭ

11.1.Цамхагт заавал гэрэлтүүлэг хийсэн байх ба энэ нь ямар нэгэн саадаар халхлагдаагүй байх ба 20-50Вт-аас багагүй хүчин чадалтай байна.

11.2.Цамхгийн өндрөөс хамааруулан 50м тутамд хажуу талд улаан өнгийн 2 гэрэл, оройн хэсэгт улаан өнгийн анивчдаг 1 гэрэл байрлуулна.

11.3.Цамхгийн гэрэлтүүлэг өвлийн улиралд 17:00-08:00, зуны улиралд 22:00-06:00 цагийн хооронд цамхгийн гэрэлтүүлэг тасралтгүй асах нөхцөлийн хангах үүднээс үл тасалдах тэжээлийн системд заавал холбосон байна.

11.4.Цамхгийн гэрэлтүүлэгт холбогдсон бүх хяналтын төхөөрөмж, үзүүлэлт, дохиоллын системийг гурван сар тутамд шалгана. Шатсан гэрлийг яаралтай солихын тулд хангалттай хэмжээний чийдэнг байнга байлгана.

6-р хүснэгт - Цамхгийн гэрэлтүүлгийн шаардлага

Цамхгийн өндөр	Гэрэлтүүлгийн төрөл (ICAO)	Гэрлийн байрлал, тоо	Хамгаалалтын гэрэлтүүлгийн өнгө ба асалтын байдал
50 м хүртэлх	ICAO A эсвэл B төрөл	Оройн хэсэгт 1 гэрэл	Бага чадлын, улаан, анивчдаггүй
51 м - 100м	ICAO B төрөл	Хажуу талд 50 м тутамд 2 гэрэл, оройн хэсэгт 1 гэрэл	50 м-д бага чадлын улаан, анивчдаггүй Оройн хэсэг дунд чадлын анивчдаг
101 м дээш өндөр			50 м-д бага чадлын улаан, анивчдаггүй дунд чадлын анивчдаг гэх мэт

11.5.Харилцаа холбооны цамхаг болон хамгаалалтын хашаанд арилжаа, сурталчилгааны зориулалттай аливаа тэмдэг, самбар, зар сурталчилгаа байрлуулахыг хориглоно.

11.6.Цамхгийн аль нэг хөл болон хамгаалалтын хашааны хаалганд дараах мэдээлэл бүхий шошго/пайзыг байрлуулсан байна.

11.6.1.Тухайн цамхгийг эзэмшигч байгууллагын нэр, лого;

11.6.2. Байгууламжийн дугаар;

11.6.3.Суурилуулсан огноо;

11.6.4. Өндрийн хэмжээ (м);

11.6.5. Шуурхай холбоо барих утасны дугаар;

11.6.6.“A4” хэмжээс бүхий металл хавтан дээр лазераар шарж, үсгийн фонт нь “Arial”, хэмжээ нь 20-24 pt өндөртэйгөөр бичсэн байна.

11.7.Цамхагт байрлах антен болон радио төхөөрөмжид эзэмшигч байгууллагыг тодорхойлох дараах мэдээлэл бүхий шошго/пайзыг байрлуулна.

11.7.1.Тухайн төхөөрөмжийг эзэмшигч байгууллагын нэр;

11.7.2.Суурилуулсан огноо

11.7.3.Эзэмшигч байгууллагын холбоо барих утас болон албан

тушаалтны мэдээлэл

11.7.4.Суурилуулсан өндрийн хэмжээ (м);

11.7.5.Антенy төрөл, тоо;

11.7.6.Байршлын газарзүйн солбицол (WGS84);

11.7.7.Антенy идэвхтэй цацаргалтын чадал;

11.8.Сараалжин бүтэцтэй 212 м хүртэл өндөртэй цамхгийг 7 үе, 212 м-ээс дээш өндөртэй цамхгийг 9 үе хувааж улаан цагаан өнгө дараалах байдлаар будаж тэмдэглэнэ. Цамхаг нь үйлдвэрлэгчээсээ цайрдсан бол будахгүй байж болно.


11.9.Цамхгийн их биеийн доод ба дээд хэсэг заавал улаан өнгөөр тэмдэглэгдсэн байна.

12.ЦАМХГИЙН ГАЗАРДУУЛГА БА АЯНГА ЗАЙЛУУЛАГЧ

12.1.Цамхаг нь IEC 62305 болон холбогдох үндэсний стандартын шаардлагад нийцсэн газардуулга, аянга хамгаалах системтэй байна.


12.2.Газардуулгын хүрээний эсэргүүцэл нь хамгийн ихдээ $R \leq 10$ Ом байх шаардлагыг хангасан байна.

12.3. 5-р зурагт үзүүлсний дагуу татлагат цамхгийн хувьд татлага, цамхгийн их биеийг газардуулахаас гадна цамхагт байрлах антенy болон харилцаа холбооны тоног төхөөрөмжүүдийн газардуулга, тэдгээрийн агуулж байгаа байрыг тойруулан хийсэн газардуулгын хэлхээ зэргийг өөр хооронд нь заавал холбосон байна.



5-р зураг - Татлагат цамхгийн газардуулгын бүдүүвч зураг

12.4. 6-р зурагт үзүүлсний дагуу цамхгийн оройд 12 мм-ээс багагүй диаметртай аянга зайлуулах зэс саваа байрлаж түүнийг (25 мм) х (3 мм)-ээс багагүй хэмжээтэй туузан зэс утсаар газардуулгын хэлхээтэй холбоно.



6-р зураг - Цамхагт аянга зайлуулагч холбох бүдүүвч зураг

13.АШИГЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

13.1.Цамхгийн ашиглалт, засвар үйлчилгээг эзэмшигч байгууллага хариуцах бөгөөд ашиглалтын үеийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

13.2.Цамхгийн эзэмшигч байгууллага нь тогтмол үзлэг, шалгалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, илэрсэн гэмтэл, зөрчлийг тухай бүр арилгана.

13.3.Гэмтсэн, эвдэрсэн цамхгийг сэргээн засварлах, шинэчлэх ажлыг инженерийн дүгнэлт болон зураг төслийн үндсэн дээр гүйцэтгэнэ.

13.4.Цамхгийн өндөр, бүтээцийн хийц, антен болон тоног төхөөрөмжийн ачаалалд өөрчлөлт оруулах тохиолдолд бүтээцийн даацын тооцоог дахин хийж баталгаажуулсан байна.

13.5.Үзлэг, шалгалт болон техникийн үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай сэргээн засварлалт, хүчитгэл, зэврэлтээс хамгаалах

арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

13.6.Цамхгийн их биед ядралын зэрэг тогтоох шалгалтыг холбогдох мэргэжлийн байгууллагаар хийлгэж, баталгаажуулах ба цаашид цамхгийн төмөр хийцийн чанар муудахаас урьдчилан сэргийлэх, сэргээн засварлах зорилгоор 10 жилээс дээш насралттай цамхагт ядралын зэрэг тогтоох үзлэг шалгалтыг 8 жил тутамд хийнэ.

14. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

14.1.Цамхгийн угсралт, ашиглалт, засвар үйлчилгээний ажлыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ.

14.2.Цамхаг дээр ажил гүйцэтгэх ажилтан нь өндөрт ажиллах сургалтад хамрагдсан, холбогдох эрх бүхий байгууллагаас олгосон үнэмлэх, гэрчилгээтэй байна.

14.3.Өндөрт ажиллах үед хамгаалалтын бүс, хамгаалалтын олс, хамгаалалтын дуулга болон бусад шаардлагатай хамгаалах хэрэгслийг заавал хэрэглэнэ.

14.4.Цамхаг дээр ажил гүйцэтгэх үед уналтаас хамгаалах системийг ашиглаж, аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.

14.5.Аянга цахилгаантай, хүчтэй салхитай, мөстөлт үүссэн болон ажил гүйцэтгэхэд аюултай цаг агаарын нөхцөлд цамхаг дээр ажил гүйцэтгэхийг хориглоно.

14.6.Цахилгаан тоног төхөөрөмж болон тэжээлийн системд ажил гүйцэтгэхдээ цахилгааны аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байна.

14.7.Цамхаг дээр ажил гүйцэтгэх үед доод бүсэд хамгаалалтын бүс тогтоож, анхааруулах тэмдэг байрлуулсан байна.

14.8.Цамхаг дээр ажиллахад хэрэглэгдэх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг унахаас хамгаалсан бэхэлгээтэй байна.

НОМ ЗҮЙ

1. БД 11-116-14, Эрчим хүчний, харилцаа холбооны инженерийн байгууламжийн геодезийн ажил” ;

2. БД 43-101-03*12, Цахилгаан байгууламжийн дүрэм. Бүлэг 1,6 “Газардуулга ба цахилгааны аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ” ;

3. БНБД-2.02.01-94 “Барилга байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох норм ба дүрэм”;

4. БНБД3.04.03-90 “Байгууламж ба барилгын бүтээцийг зэврэлтээс хамгаалах”

5. БНБД 22-01-01/2006 “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм”;

6. БНБД 2.01.01-93 “Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлтүүд”

7. БНБД 2.01.07-90 “Ачаалал ба үйлчлэл” зэрэг бичиг баримтуудын холбогдох заалтуудын баримтална.

8. Олон Улсын Иргэний нисэхийн байгууллага (International Civil Aviation Organization-ICAO). Хавсралт 14, Боть 1, Аэродромын хийц ба ажиллагаа;

9. MTSFB 001:2009, Малайз улс, “Радио холбооны сүлжээний дэд бүтцийн техникийн стандарт ба дэд бүтцийн шаардлага”;

10. “Холбооны цамхаг байгуулах заавар, зөвлөмж”, 2010, Гана улс;

11. “Холбооны цамхаг, мачт суурилуулах техникийн үзүүлэлтүүд”, 2009, Нигер улс,

12. ANSI/TIA-222-G-2005, “Антен ба антены цамхгийн бүтцийн стандарт”;

13. UTL/GBT/0201, 2011, Балба улс, “30, 40 ба 50 м өндөртэй бааз станцын цамхгийн техникийн үзүүлэлтүүд”;

14. EN 12385-2, Ган татлаганы аюулгүй ажиллагаа. 2-р хэсэг: Ангилал болон тэмдэглэгээ, тодорхойлолт;

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 7673 дугаарт бүртгэв

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙДЫН
ТУШААЛ**

2026 оны 7 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар А/92

Улаанбаатар
хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13 дахь заалт, Инновацын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.14 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Инновацын бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах, мэргэжлийн шинжээчдийн ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Дижитал шилжилт, инновацын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Цэнгүүнжав)-т даалгасугай.

3.Энэ тушаалыг баталсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Журам батлах тухай” 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/275 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ч.НОМИН

*Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын
2026 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн А/92 дугаар
тушаалын хавсралт*

ИННОВАЦЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААР ДҮГНЭЛТ ГАРГАХ, МЭРГЭЖЛИЙН ШИНЖЭЭЧДИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Инновацын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт заасны дагуу инновацын төслийн бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах, мэргэжлийн шинжээчдийг / цаашид “шинжээч” гэх/ ажиллуулах, түүнтэй холбогдон үүсэх бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2.“инновацын бүтээгдэхүүн” гэж Инновацын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасныг хэлнэ.

Хоёр. Инновацын бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах зохион байгуулалт

2.1.Өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь инновацын төслийг хүлээн авч, инновацын бүтээгдэхүүнд дүгнэлт гаргуулна.

2.2.Өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь инновацын төслийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор энэ журмын 3.2-т заасан жагсаалтаас холбогдох салбарын нэгээс доошгүй шинжээч болон эдийн засаг, санхүү, бизнес, эрх зүйн чиглэлээр мэргэшсэн хоёроос доошгүй шинжээчээс бүрдсэн 5 хүртэлх гишүүнтэй багийг ажиллуулж дүгнэлт гаргуулна.

2.3.Инновацын төсөл нь шинжээчийн мэргэшсэн чиглэлд нийцээгүй болон энэ журмын 4.7.4-т заасан үндэслэлээр тухайн инновацын бүтээгдэхүүнд шинжээч дүгнэлт гаргахаас татгалзсан тохиолдолд дараагийн шинжээчийг сонгон ажиллуулна.

2.4.Өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь шаардлагатай тохиолдолд инновац, хөрөнгө оруулалт болон бусад чиглэлээр нарийн мэргэшсэн эрдэмтэн, судлаачдыг урьж зөвлөгөө авч болно.

2.5.Өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн инновацын төслийн цар хүрээ, төсөлтэй танилцах хугацааг шинжээчтэй тохиролцон гэрээ байгуулна.

2.6.Өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь шинжээч дүгнэлт

гаргаснаас хойш ажлын 3 өдрийн дотор шинжээчдийн үнэлгээ, дүгнэлтийг нэгтгэн, нэгдсэн дүгнэлтийг гаргана.

Гурав. Шинжээчид тавих шаардлага

3.1.Инновацийн бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах шинжээч дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.1.1.тухайн салбар, чиглэлээр мэргэшсэн магистр болон түнээс дээш боловсролын зэрэгтэй байх (тухайн чиглэлээр мэргэшсэн мэдлэгээ баталгаажуулсан холбогдох эрдмийн зэрэг, гэрчилгээ эсвэл түүнтэй адилтгах үнэмлэхтэй нэр дэвшигч нь шинжээчээр сонгогдоход давуу тал болно);

3.1.2.тухайн салбар, чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;

3.1.3.төрийн жинхэнэ албан хаагч биш байх.

3.2.Өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 3.1-т заасан шаардлага хангасан шинжээчийн жагсаалтыг үүсгэн, Өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталгаажуулна.

3.3.Шинжээч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дүгнэлт гаргах хугацааг хэтрүүлсэн болон энэ журмыг зөрчиж дүгнэлт гаргасан тохиолдолд тухайн шинжээчийг энэ журмын 3.2-т заасан жагсаалтаас хасна.

Дөрөв. Мэргэжлийн шинжээч дүгнэлт гаргах ажиллагаа

4.1.Шинжээч дүгнэлт гаргахдаа Инновацийн тухай хууль, холбогдох дүрэм, журам болон энэхүү журмыг мөрдөнө.

4.2.Инновацийн бүтээгдэхүүнд дүгнэлт гаргах үйл ажиллагаанд шинжээч нь дараах зарчмыг баримтална:

4.2.1.хууль дээдлэх;

4.2.2.хараат бус байх;

4.2.3.төрийн болон байгууллагын нууц, хүний хувийн мэдээллийг хадгалах;

4.2.4.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.

4.3.Шинжээч инновацын төсөлтэй танилцахаас өмнө ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдлийг гаргасан байна.

4.4.Шинжээч инновацын төслийн бүтээгдэхүүнд дүгнэлт гаргахдаа энэхүү журмын хавсралтад заасан шалгуур үзүүлэлт тус бүрээр 0-5 хүртэл онооны үнэлгээ өгнө. Үүнд:

4.4.1. 5 оноо - Маш сайн;

4.4.2. 4 оноо - Сайн;

4.4.3. 3 оноо - Хангалттай;

4.4.4. 2 оноо - Сайжруулах шаардлагатай;

4.4.5. 0-1 оноо - Шаардлага хангаагүй.

4.5.Инновацийн бүтээгдэхүүнд дүгнэлт гаргасан нийт шинжээчдийн үнэлгээний дундаж нь 70 хувь болон түүнээс дээш хувиар үнэлэгдсэн тохиолдолд тухайн инновацийн бүтээгдэхүүнийг шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан гэж үзнэ.

4.6.Энэхүү журмын 4.5-д заасан шаардлага хангаагүй тохиолдолд инновацийн бүтээгдэхүүнийг шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаагүй гэж үзнэ.

4.7.Шинжээч дараах эрх эдэлнэ:

4.7.1.инновацийн бүтээгдэхүүнд үнэлгээ хийж, дүгнэлт гаргах;

4.7.2.үнэлгээ хийж дүгнэлт гаргахад шаардлагатай нэмэлт баримт бичгийг холбогдох байгууллагаас гаргуулах;

4.7.3.шинжээчээр ажилласан ажлын хөлс авах.

4.7.4.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд дүгнэлт гаргахаас татгалзах.

4.8.Шинжээч дараах үүрэг хүлээнэ:

4.8.1.энэхүү журмын 4.1-т заасны дагуу дүгнэлт гаргах;

4.8.2.гаргасан дүгнэлтийнхээ үнэн зөвийг хариуцах;

4.8.3.шинжээчээр ажиллах үедээ олж мэдсэн байгууллага, хувь хүн, инновацийн төслийн мэдээллийг хувийн сонирхол болон бусад байдлаар ашиглахгүй байх;

4.8.4.үндэслэл бүхий нотолгоонд суурилсан дүгнэлт гаргах;

Тав. Бусад

5.1.Өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь шинжээчийн хөлсийг Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооноос тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр хүн өдрөөр тооцож олгоно.

5.2.Шинжээчийн хийсэн дүгнэлтийн талаар иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

5.3.Өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын инновацийн бодлогын хэрэгжилтийн асуудал хариуцсан нэгж нь инновацийн төслийн баримтаар архивын нэгж үүсгэнэ.

*Инновацийн бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах,
мэргэжлийн шинжээчдийн ажиллах журмын хавсралт*

**Инновацийн төслийн бүтээгдэхүүнд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах
хуудас**

№	Шалгуур үзүүлэлт	Эзлэх жин	Үнэлгээ /0-5 оноо/	Оноо
1.	Бүтээгдэхүүний оюуны өмч эсхүл давтагдаагүй байдал (Монгол Улсад шинээр үйлдвэрлэгдэж байгаа, эсхүл зах зээл дээрх ижил төстэй бүтээгдэхүүн, технологи, үйлчилгээтэй харьцуулахад өрсөлдөх чадвар, техник, эдийн засгийн үзүүлэлт)	15%		
2.	Технологийн боломж	15%		
3.	Өсөж тэлэх боломж	10%		
4.	Нийгэм, эдийн засгийн үр ашиг	10%		
5.	Зах зээлийн эрэлт хэрэгцээ	20%		
6.	Маркетинг болон бизнес төлөвлөгөө	10 %		
7.	Бүтээгдэхүүн, үйлчилгээний анхдагч загварыг гаргаж, технологийн туршилт, зүгшрүүлэлт хийсэн байдал	10 %		
8.	Хүний нөөц, санхүүгийн чадавх	10 %		
Нийт үнэлгээ		100 %		
Дүгнэлт:				

Жич: Программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн хувьд 7 дугаар шалгуур үзүүлэлтийн бүтээгдэхүүн, үйлчилгээний анхдагч загварыг гаргасан байдлыг үнэлнэ.

Үнэлгээ, дүгнэлтийг үнэн зөв гаргасан шинжээч:

Гарын үсэг: /...../

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙДЫН
ТУШААЛ**

2026 оны 8 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар А/95

Улаанбаатар
хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.14.а дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний дата төв УТҮГ (Б.Дагвасүмбэрэл)-т, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус яамны Дижитал шилжилт, инновацын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Цэнгүүнжав)-т тус тус даалгасугай.

3.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн “Журам батлах тухай” А/35 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ч.НОМИН

*Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын
2026 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн А/95 дугаар
тушаалын хавсралт*

**ТӨРИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САН ХАРИУЦСАН
БАЙГУУЛЛАГААС ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг.Ерөнхий зүйл

1.1.Энэ журмын зорилго нь төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас төрийн байгууллага, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээг тодорхойлох, үйлчилгээг хүргэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2.Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллага нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан байгууллага (цаашид “Үндэсний дата төв” гэх) байна.

1.3.Энэ журмаар зохицуулаагүй бусад харилцааг Үндэсний дата төвөөс үйлчилгээ авч буй төрийн байгууллага, хуулийн этгээд (цаашид “үйлчлүүлэгч” гэх)-тэй байгуулсан үйлчилгээний гэрээгээр зохицуулна.

1.4.Үндэсний дата төв дараах үйлчилгээг үзүүлнэ:

1.4.1.төрийн байгууллагад домэйн нэр олгох;

1.4.2.төрийн байгууллагын цахим шуудангийн хаяг олгох;

1.4.3.төрийн байгууллагын мэдээллийн сан байршуулах;

1.4.4.төрийн байгууллагын зохиомол сервер түрээсийн үйлчилгээ;

1.4.5.төрийн байгууллагын зогсуур түрээсийн үйлчилгээ;

1.4.6.“Төрийн мэдээлэл солилцооны систем”-д холбох үйлчилгээ;

1.4.7.“Танилт нэвтрэлтийн систем”-д холбох үйлчилгээ;

1.4.8.интернэтийн дундын холболтын үйлчилгээ.

1.5.Энэ журмын 1.4.6, 1.4.7-д заасан үйлчилгээг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.10-д заасан журмаар зохицуулна.

1.6.Энэ журмын 1.4.6, 1.4.7-д зааснаас бусад үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, үйлчилгээ үзүүлэхэд тавигдах техникийн нөхцөлийг Үндэсний дата төвийн захирал батална.

1.7.Үйлчлүүлэгчээс гаргасан үйлчилгээ авах хүсэлтийг ажлын 5 өдрийн дотор шийдвэрлэнэ. Үйлчилгээ үзүүлэхэд тавигдах техникийн нөхцөлийг хангаагүй хүсэлтээс татгалзана.

1.8.Үйлчлүүлэгч нь Үндэсний дата төвөөс шаардсан тухай бүрд

кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ¹ хийлгэнэ.

1.9.Үндэсний дата төвөөс төлөвлөгөөт техникийн үзлэгээс шалтгаалан үйлчилгээг тодорхой хугацаагаар зогсоох тохиолдолд энэ талаар Үйлчлүүлэгчид 48 цагийн өмнө мэдэгдэнэ.

1.10.Үндэсний дата төв дараах тохиолдолд үйлчилгээг түр зогсооно:

1.10.1.эрх бүхий байгууллагаас шаардсан;

1.10.2.үйлчилгээ үзүүлэхэд тавигдах техникийн нөхцөлийг зөрчсөн;

1.10.3.энэ журмын 1.8-д заасныг биелүүлээгүй, эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ аваагүй;

1.10.4.үйлчлүүлэгчийн системд мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл үүссэн, сэжигтэй хандалт илэрсэн, үйлчлүүлэгчийн кибер аюулгүй байдал алдагдсан;

1.10.5.гэрээнд зааснаас өөр зориулалтаар үйлчилгээг ашигласан, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй;

1.10.6.Үндэсний дата төвийн дэд бүтцийн хэвийн ажиллагаанд нөлөөлөхүйц эрсдэл үүссэн.

1.11.Үйлчлүүлэгчээс энэ журамд заасан үйлчилгээ үзүүлэхэд тавигдах техникийн багтаамж, хязгаарлалтаас давсан үзүүлэлт бүхий үйлчилгээг ашиглах хүсэлт гаргасан тохиолдолд кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, гэрээний хэрэгжилтийн байдлыг харгалзан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

1.12.Дэд бүтцийн бэлэн байдал, нөөцийн зохистой хэрэглээг хангах зорилгоор Үндэсний дата төвөөс үйлчлүүлэгчийн ашиглаж байгаа техникийн багтаамж, үзүүлэлтийг багасгах шийдвэрийг үйлчлүүлэгчид урьдчилан мэдэгдэнэ. Техникийн багтаамж, үзүүлэлтийг багасгах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна.

1.13.Үндэсний дата төвийн дэд бүтцээс гаднах сүлжээ, системд арсан гэмтэл, саатал, байгалийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан үйлчилгээ доголдсоны улмаас үйлчлүүлэгчид учирсан хохирлыг Үндэсний дата төв хариуцахгүй.

1.14.Энэ журамд заасан үйлчилгээтэй холбоотой санал, хүсэлт, гомдлыг Үндэсний дата төв шийдвэрлэнэ.

Хоёр.Төрийн байгууллагад домэйн нэр олгох үйлчилгээ

2.1.Домэйн нэр нь тухайн байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг илэрхийлсэн үг, эсхүл байгууллагын монгол, англи нэрийн товчлол байх ба орон нутаг, бүсийн товчилсон, галигласан нэр байж болно.

¹ Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 4.1.9-т заасан үйл ажиллагаа.

2.2.Төрийн байгууллагад ашиглах домэйн нэрийг дараах байдлаар олгоно:

Нэгдүгээр түвшин	Хоёрдугаар түвшин	Гуравдугаар түвшин	Дөрөвдүгээр түвшин
Олон улсын ICANN байгууллагаас Монгол Улсад оноосон дээд түвшний домэйн нэр	Төрийн захиргааны байгууллагад олгох дээд домэйн нэр	Төрийн захиргааны байгууллагын эзэмших домэйн нэр	Нэгж харьяа байгууллагад оноосон дээд домэйн нэр
.mn	.gov.mn	оноосон нэр.gov.mn	нэршил.оноосон нэр.gov.mn

2.3.Үндэсний дата төв нь 3, 4 дүгээр түвшний домэйн нэрийг доор дурдсан тохиолдолд олгоно:

2.3.1.Төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт гуравдугаар түвшний домэйн нэрийг, тэдгээрт шууд харьяалагдах төрийн захиргааны байгууллагад дөрөвдүгээр түвшний домэйн нэрийг;

2.3.2.Төрийн захиргааны төв байгууллагад харьяалагдах хэдий ч улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагад гуравдугаар түвшний домэйн нэрийг;

2.3.3.Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг орон нутагт байршилтай төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагад орон нутгийн харьяаллыг тусгасан дөрөвдүгээр түвшний домэйн нэрийг;

2.3.4.Нийслэлийн засаг захиргааны нэгжид харьяалагдах төрийн байгууллагад удирдах дээд шатны байгууллагын домэйн нэрийн дөрөвдүгээр түвшний домэйн нэрийг эсхүл орон нутаг, бүсийн нэрийн товчлол бүхий домэйн нэрийг;

2.4.Байгууллагад үйл ажиллагааны чиглэл, үйлчилгээний онцлогийг харгалзан нэмэлт домэйн нэр олгож болно.

2.5.Үндэсний дата төв домэйн нэрийн (gov.mn) системийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хариуцна.

2.6.Үйлчлүүлэгчийн хүсэлтээр домэйн нэрийг өөрчилсөн бол өмнөх домэйн нэрийг устгах талаар үйлчлүүлэгчид мэдэгдэж, мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дараа устгана.

Гурав.Төрийн байгууллагын цахим шуудангийн хаяг олгох үйлчилгээ

3.1.Төрийн байгууллагын цахим шуудангийн хаяг олгох үйлчилгээ дараах багтаамжийн хэмжээтэй байна:

3.1.1. 5 гигабайт (Gb) хүртэл;

3.1.2. 50 гигабайт (Gb) хүртэл.

3.2.Үндэсний дата төвөөс үйлчлүүлэгчид өөрийн байгууллагын цахим шуудангийн хаягийг удирдах админ эрхийг олгоно.

3.3.Үйлчлүүлэгч өөрийн цахим шуудангийн хаягт ирсэн сэжигтэй болон хортой код бүхий мэдээллийг холбогдох кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төвд нэн даруй мэдэгдэнэ.

3.4.Цахим шууданг хувийн мэдээлэл хадгалах, дамжуулах зориулалтаар ашиглахгүй байхад үйлчлүүлэгч хяналт тавьж ажиллана.

Дөрөв.Төрийн байгууллагын мэдээллийн сан байршуулах үйлчилгээ

4.1.Суурь мэдээллийн сан, үндсэн болон дэмжих системийн мэдээллийн санг Үндэсний дата төвийн үндсэн мэдээллийн сангийн системд байршуулна.

4.2.Энэ журмын 4.1–д зааснаас бусад мэдээллийн санг энэхүү журмын 1.4.4, 1.4.5-д заасан үйлчилгээг ашиглан байршуулж болно.

4.3.Байршуулсан мэдээллийн санд үйлчлүүлэгч төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, эсхүл нууцлал аюулгүй байдлын шаардлага хангасан сүлжээ (VPN)-ээр дамжуулан хандана.

Тав.Төрийн байгууллагын зохиомол сервер түрээсийн үйлчилгээ

5.1.Үйлчлүүлэгчээс сонгосон үзүүлэлтийн дагуу тооцоолуур (CPU), шуурхай санах ой (RAM), хатуу диск (Hard drive)-ийн багтаамж, интернэт протокол (IP) ашигласан хаягт зохиомол серверийг түрээслэх үйлчилгээг үзүүлнэ.

5.2.Зохиомол сервер дээр ажиллах системийн дэлгэрэнгүй мэдээллийг үйлчилгээ үзүүлэх гэрээнд тусгана.

5.3.Үйлчлүүлэгч шаардлагад нийцсэн үзүүлэлт бүхий өөрийн серверийг үүлэн тооцооллын дэд бүтцэд нэгтгэж, гэрээнд заасан нөхцөлийн дагуу ашиглаж болно.

5.4.Гэрээ дуусгавар болсноос хойш зохиомол серверт байршиж байгаа үйлчлүүлэгчийн өгөгдөл, мэдээлэл, түүний нөөцийг устгах талаар үйлчлүүлэгчид мэдэгдэж, мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дараа устгана.

Зургаа.Төрийн байгууллагын зогсуур түрээсийн үйлчилгээ

6.1.Зориулалтын орчин нөхцөлд байршуулсан серверийн зогсуур /rack/-т үйлчлүүлэгчийн сервер, тоног төхөөрөмжийг байршуулан ашиглах үйлчилгээг үзүүлнэ.

6.2.Төрийн байгууллагын байршуулсан тоног төхөөрөмж дээр ажиллах системийн дэлгэрэнгүй мэдээллийг үйлчилгээ үзүүлэх гэрээнд тусгана.

Долоо. Интернэтийн дундын холболтын үйлчилгээ

7.1.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн 9.4-т заасан тусгай зөвшөөрөлтэй этгээд интернэтийн дундын

холболтын үйлчилгээ авах хүсэлт гаргана.

7.2.Үйлчлүүлэгч дундын холболтын төхөөрөмжөөс өөрийн төхөөрөмж хүртэлх шилэн кабель, сүлжээний бүрэн бүтэн байдал болон холболтыг бүрэн хариуцаж, сүлжээгээр дамжин хийгдэж буй халдлагыг таслан зогсоох, сүлжээнд зүй бус ачаалал үүсгэхээс сэргийлэх арга хэмжээ авна.

Найм. Үйлчилгээний төлбөр

8.1.Үндэсний дата төвөөс үйлчлүүлэгчид үзүүлж байгаа үйлчилгээ нь төлбөртэй байна.

8.2.Энэ журмын 4.1-д заасан үйлчилгээнд 8.1 дэх заалт хамаарахгүй.

8.3.Энэ журмын 1.4.6, 1.4.7-д зааснаас бусад үйлчилгээний төлбөрийн хэмжээг Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.5-д заасан аргачлалын дагуу боловсруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Үндэсний дата төвийн захирал тогтооно.

Ес.Хяналт

9.1.Үндэсний дата төв энэ журмын 1.4-д заасан үйлчилгээ тус бүрээр гаргасан тайланг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал тутам хүргүүлнэ.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 6 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 258

Улаанбаатар
хот

“ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ” БАТЛАХ ТУХАЙ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.8, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1.“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-ын 2.16.1-2.16.9 дэх заалтыг 2026 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт мэдээлэхийг Ажлын алба (С.Цогтгэрэл)-нд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

*Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны
6 дугаар сарын 25-ны өдрийн
258 дугаар тогтоолын хавсралт*

**ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн зохистой засаглал, үйл ажиллагаа, хөрөнгийн хэмжээ, тайлан мэдээ болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн тайланд аудитын хуулийн этгээд, мэргэжлийн холбооны үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтооходой холбогдох харилцааг энэ журмаар зохицуулна.

**Хоёр.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл
ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлага**

2.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч (цаашид “ВХҮҮ” гэх) нь Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс” болон түүнд нийцүүлсэн дүрэм, журам, заавар, аргачлалыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

2.2.ВХҮҮ харилцагчийн эрх ашгийг хамгаалж, виртуал хөрөнгийн зах зээлийн шударга өрсөлдөөнийг дэмжиж ажиллана.

2.3.ВХҮҮ нь дараах шаардлагыг хангаж ажиллана:

2.3.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан;

2.3.2.Энэ журмын 2.4-2.14-т заасан бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц болон бусад шаардлага;

2.3.3.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1.1-6.1.5-д заасан үйлчилгээг эрхлэхэд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ тус бүр 400 сая төгрөгөөс доошгүй байх;

2.3.4.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 4.1.4, 7.2-т тус тус заасан холбогдох этгээд, эрх бүхий албан тушаалтан нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангасан байх.

2.4.Хувь нийлүүлсэн хөрөнгө нь зээлийн эх үүсвэрээс бусад мөнгөн хөрөнгөөс бүрдсэн байх ба энэ журмын 2.3.3-т заасан үйлчилгээг хавсран эрхэлж байх тохиолдолд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг тус бүрээр нэмэгдүүлэн тооцно.

2.5.ВХҮҮ нь тав буюу түүнээс дээш гишүүнтэй төлөөлөн удирдах зөвлөлтэй байх ба тэдгээрийн хоёроос доошгүй нь хараат бус гишүүн байна.

2.6.Энэ журмын 2.5-д заасан төлөөлөн удирдах зөвлөл дараах дүрэм, журам, бодлогын баримт бичгийг баталсан байна:

2.6.1.төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;

2.6.2.компанийн дөрвөн жилийн бизнес төлөвлөгөө;

2.6.3.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, удирдах талаар хэрэгжүүлэх төлөвлөгөө, дотоод хяналтын хөтөлбөр;

2.6.4.мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам;

2.6.5.MNS ISO/IEC 27001 стандартын шаардлага, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлсэн мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны журам;

2.6.6.дотоод мэдээллийг хууль бусаар ашиглахаас сэргийлэх журам;

2.6.7.арилжааг урвуулан ашиглахаас сэргийлэх, хяналт тавих журам;

2.6.8.үйл ажиллагааг түр зогсоох, хязгаарлалт тогтоох, татан буугдах, үйлчилгээ зогсох, кибер халдлага, түрэмгийлэлд өртөх зэрэг онцгой нөхцөл байдал үүссэн үед авах арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө;

2.6.9.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1.1-6.1.5-д заасан тухайн үйлчилгээг эрхлэхтэй холбоотой үйл ажиллагааны журам;

2.6.10.бусад шаардлагатай журам.

2.7.BXYУ нь Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1.1-6.1.2-т заасан үйлчилгээг эрхлэхтэй холбоотой журамд өөрийн программ хангамж дээр виртуал хөрөнгийг арилжих, арилжаанаас хасахтай холбогдох зохицуулалтыг тусгасан байна.

2.8.BXYУ нь Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1.5-д заасан үйлчилгээг эрхлэхтэй холбоотой журамд дараах зүйлсийг тусгасан байна:

2.8.1.нийтэд санал болгох виртуал хөрөнгө гаргагч болон тухайн виртуал хөрөнгө, түүний танилцуулгад тавигдах шаардлага;

2.8.2.нийтэд санал болгох виртуал хөрөнгө гаргагчийн биелүүлэх үүрэг, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлэх мэдээллийн агуулга, хугацаа;

2.8.3.нийтэд санал болгон гаргасан виртуал хөрөнгийг бүртгэлээс хасах нөхцөл;

2.8.4.бусад.

2.9.BXYУ нь дараах бүтэц, зохион байгуулалт, тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нөөцтэй байна:

2.9.1.дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх;

2.9.2.мэдээллийн технологи, аюулгүй байдал хариуцсан нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх;

2.9.3.харилцагчийн үйлчилгээний нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх;

2.9.4.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих болон комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хариуцсан нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх ба хэрэгжилтэд хяналт тавих этгээд нь төлөөлөн удирдах зөвлөл байх;

2.9.5.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1.1-6.1.5-д заасан үйлчилгээг эрхлэхтэй холбоотой үйл ажиллагааг хариуцсан нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байна.

2.10.Энэ журмын 2.9-д заасан ажилтан нь Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 7.2.2, 7.2.3-т заасан шаардлагыг хангасан, хуульд өөрөөр заагаагүй бол ашиг сонирхлын зөрчил болон виртуал хөрөнгө гаргагч, эзэмшигч, харилцагчид хохирол учруулахуйц нөхцөл байдал үүсгэх тохиолдолд давхар ажил хавсран эрхэлдэггүй байна.

2.11.Энэ журмын 2.9.1-2.9.3-д заасан нэгж, эсхүл ажилтны чиг үүргийг гэрээний үндсэн дээр бусад мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

2.12.ВХҮҮ нь виртуал хөрөнгийн үйлчилгээг шуурхай, тасралтгүй үзүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны онцлогт тохирсон тусгай программ хангамжтай байх бөгөөд уг программ хангамж нь дараах шаардлагыг хангасан байна:

2.12.1.арилжаанд оролцогчид нэгнийгээ таньж мэдэх боломжгүй байх;

2.12.2.харилцагчийн хувийн мэдээлэл гуравдагч этгээдээс нууц байх;

2.12.3.зах зээлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, шинэчлэх боломжтой байх;

2.12.4.олон нийтэд мэдээлэл хүргэх хэсэг буюу нээлттэй самбартай байх;

2.12.5.арилжааны хяналтын системтэй байх;

2.12.6.албан ёсны лицензтэй аюулгүй байдлыг хангах системтэй байх.

2.13.ВХҮҮ нь энэ журмын хавсралтад заасан MNS ISO/IEC 27001 мэдээлэл технологийн стандартын сүүлийн хувилбарыг хангаж, хөндлөнгийн эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан байна.

2.14.ВХҮҮ нь гадаад улсын виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, бусад мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг этгээдийн программ хангамж, үүлэн технологи, эсхүл дата төвийг ашигладаг бол энэ журмын хавсралтын 11 дэх хэсэг хамаарахгүй.

2.15.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан үйл ажиллагааг эрхлэхэд дараах шаардлагыг хангаж ажиллана:

2.15.1.харилцагчийн захиалгын үнэ ханш, цаг хугацааны дарааллын дагуу арилжааг шударгаар зохион байгуулах;

2.15.2.харилцагчийг арилжааны талаарх мэдээлэлтэй тухай бүр танилцах боломжоор хангах;

2.15.3.дотоод мэдээллийг хууль бусаар болон арилжааг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах захиалга, арилжаанд дотоод хяналт, шалгалтыг тогтмол хэрэгжүүлэх:

2.15.3.1.өндөр үнийн дүнтэй;

2.15.3.2.үнэ ханшийн өсөлт, бууралт ихтэй;

2.15.3.3.үнэ ханшид нөлөөлөхүйц үнээр, цөөн тоо ширхгээр арилжсан;

2.15.3.4.холбогдох болон нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн хооронд тав ба түүнээс дээш удаа арилжаа хийгдсэн;

2.15.3.5.хэвийн бус, анхаарал татсан гэж үзсэн бусад.

2.15.4.энэ журмын 2.15.3-т заасан захиалга, арилжаанд хийсэн хяналт, шалгалтаар Эрүүгийн хуулийн 18.19, 18.20 дугаар зүйлд тус тус заасан гэмт хэргийн шинжтэй үйлдэл байж болзошгүй гэж сэжиглэсэн тохиолдолд 24 цагийн дотор мэдээллийг нотлох баримтын хамт Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газарт хүргүүлж, Хороонд мэдээлэх.

2.15.5.виртуал хөрөнгийн арилжааны хэлцэл биелсний дараа дор дурдсан мэдээллийг харилцагч авах боломжтой байх:

2.15.5.1.виртуал хөрөнгийн нэр;

2.15.5.2.хэлцэл биелсэн хугацаа;

2.15.5.3.арилжсан виртуал хөрөнгийн хэмжээ, үнэ ханш;

2.15.5.4.бусад шаардлагатай мэдээлэл.

2.15.6.арилжааг дараах аргаар зохион байгуулах боломжтой байх:

2.15.6.1.зах зээлийн үнийн арга (market order);

2.15.6.2.нөхцөлт захиалгын арга (limit order).

2.15.7.арилжаанаас хассан виртуал хөрөнгийн мэдээллийг тайлбарын хамт 24 цагийн дотор Хороонд албан бичгээр хүргүүлэх.

2.16.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1.3-д заасан үйл ажиллагааг эрхлэхэд дараах шаардлагыг хангаж

ажиллана:

2.16.1.Шилжүүлэгч ВХҮҮ нь гурван сая төгрөг болон түүнээс дээш үнийн дүнтэй виртуал хөрөнгийг шилжүүлэхэд дараах мэдээллийг хүлээн авагч ВХҮҮ-д хүргүүлсэн байна:

2.16.1.1.шилжүүлэгчийн овог, нэр/хуулийн этгээдийн нэр;

2.16.1.2.шилжүүлэгчийн регистрийн дугаар;

2.16.1.3.шилжүүлгийн дугаар, эсхүл шилжүүлэгчийн хэтэвчний хаяг;

2.16.1.4.шилжүүлэгчийн бүртгэлтэй хаяг;

2.16.1.5.шилжүүлгийн зорилго;

2.16.1.6.хүлээн авагчийн овог, нэр /хуулийн этгээдийн нэр;

2.16.1.7.хүлээн авагчийн бүртгэлтэй хаяг;

2.16.1.8.хүлээн авагч талын улсын нэр;

2.16.1.9.хүлээн авагч талын ВХҮҮ-ийн нэр;

2.16.1.10.шаардлагатай бусад.

2.16.2.Хүлээн авагч ВХҮҮ нь гурван сая төгрөг болон түүнээс дээш үнийн дүнтэй виртуал хөрөнгийг хүлээн авахдаа шилжүүлэгч ВХҮҮ-ээс дараах мэдээллийг авсан байна:

2.16.2.1.шилжүүлэгчийн овог, нэр/хуулийн этгээдийн нэр;

2.16.2.2.шилжүүлэгчийн регистрийн дугаар;

2.16.2.3.шилжүүлгийн дугаар, эсхүл шилжүүлэгчийн хэтэвчний хаяг;

2.16.2.4.шилжүүлэгчийн бүртгэлтэй хаяг;

2.16.2.5.хүлээн авагчийн овог, нэр;

2.16.2.6.шилжүүлгийн дугаар, эсхүл хүлээн авагчийн хэтэвчний хаяг.

2.16.3.Бүртгэлгүй хэтэвчнээс шилжүүлэг хүлээн авах тохиолдолд энэ журмын 2.16.2-т заасан мэдээллийг авсан байх;

2.16.4.Шилжүүлэгч ВХҮҮ энэ журмын 2.16.2-т заасан мэдээллийг нэн даруй буюу шилжүүлэг хийхээс өмнө, эсхүл шилжүүлэг хийгдэх хугацаанд аюулгүй хэлбэрээр хүргүүлсэн байх;

2.16.5.Шилжүүлэгч болон хүлээн авагч ВХҮҮ нь энэ журмын 2.16.1, 2.16.2-т заасан мэдээллийг дамжуулах, хүлээн авахаас өмнө хамтрагч ВХҮҮ-ийг тодорхойлж, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан эсэхийг үнэлсний үндсэн дээр шилжүүлгийг хийх;

2.16.6.Шилжүүлэгч ВХҮҮ дундын ВХҮҮ-ээр дамжуулан шилжүүлгийг хийсэн тохиолдолд энэ журмын 2.16.1, 2.16.2-т заасныг хэрэгжүүлэх;

2.16.7.Шилжүүлэгч ВХҮҮ нь шилжүүлэг хийж байгаа харилцагчийн мэдээлэл, хүлээн авагч ВХҮҮ нь хүлээн авч буй

харилцагчийн мэдээллийн үнэн бодит байдлыг шалгасан байх;

2.16.8.ВХҮҮ харилцагчийг таньж мэдэх эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлж, өндөр эрсдэлтэй гэж үзсэн этгээд рүү шилжүүлэг хийхгүй болон түүнтэй бизнесийн харилцаа тогтоохгүй байх;

2.16.9.Шилжүүлэгч болон хүлээн авагч ВХҮҮ нь энэ журмын 2.16.1, 2.16.2-т заасан мэдээллийг эрх бүхий байгууллагад түргэн шуурхай гаргаж өгөхөд бэлэн хадгалах;

2.16.10.харилцагчийн виртуал хөрөнгийг шилжүүлэхдээ багадаа хоёр шатлалт танилт хийж, IP хаяг, хэтэвчний хаягийн үнэн зөв, бодит байдлыг баталгаажуулах.

2.17.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1.4-т заасан үйл ажиллагааг эрхлэхэд дараах шаардлагыг хангаж ажиллана:

2.17.1.ВХҮҮ өөрийн хөрөнгийг 100 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй харилцагчийн виртуал хөрөнгийг хадгалж, удирдах;

2.17.2.ВХҮҮ өөрийн хөрөнгийн хэмжээний шалгуурыг улирал бүр тооцож, энэ журмын 3.5.1-т заасан шаардлагыг хангаж ажиллах;

2.17.3.ВХҮҮ виртуал хөрөнгийг харилцагчийн даалгавраар хадгалах, удирдахдаа багадаа хоёр шатлалт танилт хийж, IP хаяг, хэтэвчний хаягийн үнэн зөв, бодит байдлыг баталгаажуулах.

2.18.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1.5-д заасан үйл ажиллагааг эрхлэхэд дараах шаардлагыг хангаж ажиллана:

2.18.1.ВХҮҮ виртуал хөрөнгийг нийтэд санал болгох, худалдахтай холбоотой ажлыг зохион байгуулахаас өмнө тухайн виртуал хөрөнгө гаргагчтай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан байх;

2.18.2.ВХҮҮ виртуал хөрөнгө гаргагчийн виртуал хөрөнгийг нийтэд санал болгох, худалдахтай холбоотой ажлыг зохион байгуулахаас өмнө дараах мэдээлэлд үндэслэж шийдвэр гаргасан байна:

2.18.2.1.виртуал хөрөнгө, түүний төсөл нь эдийн засгийн үр ашигтай, бодитой, хэрэгжихүйц эсэх;

2.18.2.2.виртуал хөрөнгө гаргагч, түүний эцсийн өмчлөгч, эрх бүхий албан тушаалтан нь эдийн засгийн гэмт хэрэгт холбогдож байгаагүй, хугацаа хэтэрсэн өр зээлгүй, бизнесийн нэр хүндтэй, мэргэжлийн багтай эсэх;

2.18.2.3.виртуал хөрөнгийн суурилсан блокчэйн нь бүрэн хөгжүүлэлт хийгдэж, кибер аюулгүй байдлыг хангасан эсэх;

2.18.2.4.бусад.

2.18.3.ВХҮҮ виртуал хөрөнгө гаргагчийн виртуал хөрөнгийг нийтэд санал болгох, худалдах танилцуулгад дор дурдсан мэдээллийг тусгуулсан байна:

2.18.3.1.танилцуулга нь монгол хэл дээр бичигдсэн байх;

2.18.3.2.виртуал хөрөнгийн хэрэглээ, гаргаж буй зорилго, блокчэйний төрөл;

2.18.3.3.виртуал хөрөнгө гаргагчийн оноосон нэр, оршин байгаа газрын шуудангийн болон холбоо барих хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагааны талаар;

2.18.3.4.виртуал хөрөнгө гаргагчийн хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл, эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь хэмжээ;

2.18.3.5.виртуал хөрөнгө гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны нэр, зураг, ажлын туршлага, бусад нэмэлт мэдээлэл;

2.18.3.6.виртуал хөрөнгө гаргагчийн сүүлийн нэг жилийн санхүүгийн тайлан, түүний талаар аудитын байгууллагаас гаргасан дүгнэлт;

2.18.3.7.нийтэд санал болгох виртуал хөрөнгийн тоо хэмжээ, санал болгох үнэ;

2.18.3.8.татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны төлөвлөгөө;

2.18.3.9.виртуал хөрөнгийн хуваарилалт, тархалтын мэдээлэл;

2.18.3.10.виртуал хөрөнгө гаргагчийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн талаарх мэдээлэл;

2.18.3.11.виртуал хөрөнгөнд хийсэн технологийн аудитын дүгнэлт;

2.18.3.12.шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

2.18.4.ВХҮҮ виртуал хөрөнгийн танилцуулга, холбогдох баримт, мэдээллийг нийтэд санал болгох, худалдах ажиллагааг зохион байгуулахаас өмнө ажлын 10 өдрийн дотор Хороонд хүргүүлнэ.

2.18.5.ВХҮҮ виртуал хөрөнгийн танилцуулга, токеномикс, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэн хагас жил тутамд тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

2.19.ВХҮҮ дараах мэдээллийг өөрийн программ хангамж болон цахим хуудсанд ил тод, нээлттэйгээр байршуулж ажиллана.

2.19.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 9.1.1-9.1.13, 10.13-д заасан мэдээлэл;

2.19.2.арилжааны программ хангамжийг ашиглахтай холбоотой заавар, зөвлөмж, гарын авлага;

2.19.3.олон нийттэй харилцах утас, цахим шуудан, олон нийтийн сүлжээний хаяг, үйл ажиллагаа явуулж буй хаяг байршил;

2.19.4.өөрийн программ хангамжаар дамжуулан арилжиж буй дотоодын нийтэд санал болгон, худалдсан виртуал хөрөнгийн танилцуулга;

2.19.5.бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн талаарх мэдээлэл;

2.19.6.виртуал хөрөнгийн блокчэйн дээрх бүртгэлийн дугаар, ялгах тэмдэг, нийт гаргасан болон арилжиж буй тоо ширхэг, үнэлгээ, ханш, арилжааны дүн;

2.19.7.виртуал хөрөнгийн бүртгэлийн шаардлага, шалгуур, дүрэм, журам;

2.19.8.харилцагчийн санал, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээлэл;

2.19.9.BXYҮ-ийн үндсэн үйл ажиллагааны танилцуулга, санхүүгийн тайлан, бизнест шууд нөлөө үзүүлэхүйц хэлцлийн талаар;

2.19.10.үйл ажиллагаанд ашиглах программ хангамж, систем болон мэдээлэл, технологийн өөрчлөлт, шинэчлэлтийн талаар;

2.20. BXYҮ өөрийн программ хангамжаар дамжуулан нийтэд санал болгон, худалдсан, арилжаалагдаж буй виртуал хөрөнгө гаргагчийн үйл ажиллагааны дараах өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухай бүр мэдээлнэ:

2.20.1.эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт;

2.20.2.виртуал хөрөнгийн танилцуулга, токеномикс, үйл ажиллагааны төлөвлөгөөний өөрчлөлт, тэдгээрийн гүйцэтгэл буурсан;

2.20.3.бүтэц, зохион байгуулалтад орсон өөрчлөлт;

2.20.4.эрх бүхий албан тушаалтан, ажилтан эдийн засгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүхээр тогтоогдсон;

2.20.5.BXYҮ-ийн үйл ажиллагааны дотоод журамд заасан бусад мэдээлэл;

2.20.6.виртуал хөрөнгө гаргагчийн сүүлийн нэг жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан.

2.21.BXYҮ харилцагчийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

2.21.1.харилцагчийн өргөдөл, гомдлын бүртгэл хөтөлж, хүлээн авснаас хойш ажлын 7 өдрийн дотор хариу хүргүүлэх;

2.21.2.харилцагч, олон нийтийн виртуал хөрөнгийн эрсдэлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн ажлыг улирал бүр зохион байгуулах;

2.21.3.өөрийн ажилтнаас харилцагчийн хувийн мэдээллийг гадагш задруулахгүй, ажлын шаардлагаас бусад зорилгоор ашиглахгүй

байх талаар баталгааг авах.

2.22.ВХҮҮ виртуал хөрөнгийн арилжааг урвуулан ашиглахаас сэргийлэх зорилгоор дараах мэдээллийг тогтмол, эсхүл тухай бүр программ хангамж болон цахим хуудсанд ил тод, нээлттэйгээр урьдчилан байршуулж, олон нийтэд мэдээлнэ:

2.22.1.арилжааны программ хангамж дахь виртуал хөрөнгийн үнэ ханш нь олон улсын зах зээл дээрх дундаж үнээс харьцангуй доогуур, эсхүл дээгүүр байх тохиолдолд үнийн зөрүүг тогтворжуулан хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хийж буй тухайн ВХҮҮ-ийн арилжааны талаар;

2.22.2.виртуал хөрөнгө гаргагч нь тухайн виртуал хөрөнгийн үнэ ханшийг огцом унахаас сэргийлэх зорилгоор ВХҮҮ-тэй тохиролцож, холбогдох гэрээ байгуулсны үндсэн дээр өөрөө эргүүлэн худалдан авах ажиллагааны талаар.

2.23.ВХҮҮ нь энэ журмын хавсралтад заасан мэдээлэл технологийн стандартын сүүлийн хувилбарыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

2.24.ВХҮҮ хууль тогтоомж, энэ журамд заасан мэдээллийг бүрэн гүйцэд, үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүйгээр тогтоосон хугацаа болон тухай бүрд харилцагч, олон нийтэд мэдээлж, Хороонд хүргүүлж тайлагнана.

2.25.ВХҮҮ жилийн санхүүгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор, хагас жил, улирлын санхүүгийн тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор Хороонд тогтмол хүргүүлнэ.

2.26.ВХҮҮ аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан жилийн санхүүгийн тайлан, дүгнэлтийг дараа оны 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хороонд хүргүүлнэ.

2.27.ВХҮҮ дараах мэдээллийг агуулсан үйл ажиллагааны жилийн тайланг дараа оны 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хороонд тогтмол хүргүүлж, олон нийтэд мэдээлнэ:

2.27.1.тайлант жилд ВХҮҮ-ийн орлогод нөлөөлсөн хүчин зүйлс;

2.27.2.санхүүгийн нөөцөөр бизнесийн үйл ажиллагаанаас бий болсон өр төлбөрийг бүрэн хариуцах болон шаардлагатай тохиолдолд гадаад, дотоод эх үүсвэрээс санхүүжилт татах боломжтой эсэх;

2.27.3.бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэчлэл, төрөлжилт, өөрчлөлт;

2.27.4.хадгалж, удирдаж байгаа харилцагчийн виртуал болон мөнгөн хөрөнгийн тоон үзүүлэлт;

2.27.5.ашиглаж буй программ хангамж, систем, мэдээлэл, технологийн дэд бүтцийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, нууцлал, аюулгүй байдалд хийлгэсэн эрсдэлийн үнэлгээний дүгнэлт, эрсдэлийг

бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ;

2.27.6.сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл, тухайн хэлцэлд оролцогч талууд;

2.27.7.эрсдэлийн удирдлагын хэрэгжилт, дотоод аудитын ажлын тайлан;

2.27.8.бусад мэдээлэл.

2.28.Энэ журмын 2.9-д заасан ажилтан нь давхар ажил эрхлэх тохиолдолд ажил олгогчдоо урьдчилан мэдэгдэнэ. Ажил олгогч тухайн ажил чиг үүрэг нь ашиг сонирхлын зөрчил болон виртуал хөрөнгө гаргагч, эзэмшигч, харилцагчид хохирол учруулахуйц нөхцөл байдал үүсгэх эсэхийг урьдчилан магадлан шалгасны үндсэн дээр ажилтанд давхар ажил эрхлэх зөвшөөрлийг олгоно.

2.29.Ажил олгогч нь энэ журмын 2.9-д заасан магадлан шалгах ажиллагааг хийж, ажилтанд зөвшөөрөл олгохоос өмнө холбогдох баримт бичгийг Хороонд ирүүлнэ.

2.30.ВХҮҮ-ийн оноосон нэр, хаяг байршил болон холбогдох этгээдээс бусад хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд компанийн дүрмийн баталгаажуулсан хуулбар, улсын бүртгэлийн гэрчилгээний лавлагааг ажлын таван өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

2.31.ВХҮҮ хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, холбогдох этгээд болон эрх бүхий албан тушаалтныг өөрчлөх тохиолдолд энэ хууль болон Хорооноос тогтоосон шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянуулахаар холбогдох баримт бичгийг Хороонд ирүүлнэ.

Гурав.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлага

3.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээд (цаашид “аудитын хуулийн этгээд” гэх) дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

3.1.1.дөрвөөс дээш орон тооны аудитортой байх;

3.1.2.аудитор нь мэргэжлийн хариуцлагын даатгалын гэрээг байгуулсан байх;

3.1.3.аудитор нь мэргэжлийн ёс зүйн зөрчилгүй байх;

3.1.4.аудитор нь Хороо болон Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10.8-д заасан мэргэжлийн холбооноос хамтран зохион байгуулсан багц сургалтад хамрагдсан байна.

Дөрөв.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн холбооны үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлага

4.1.Хороо нь Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн холбоо (цаашид “мэргэжлийн холбоо” гэх)-той санамж бичиг байгуулан хууль тогтоомжийн дагуу хамтран ажиллана.

4.2.Мэргэжлийн холбоо дараах шаардлагыг хангасан байна:

4.2.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн, оноосон нэр, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, харилцах данстай байх;

4.2.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй Хороонд бүртгэлтэй ВХҮҮ-ийн 51-ээс доошгүй хувийг гишүүнээр элсүүлсэн байх;

4.2.3.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 7.1.2, 7.1.5, 7.1.6-д заасан шаардлагыг хангасан талаар дүгнэлт гаргах мэргэжлийн чадамжтай байх;

4.2.4.ВХҮҮ-ийн салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөтэй, гишүүддээ мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх чадамжтай байх;

4.2.5.мэргэжлийн ёс зүйн хариуцлага хүлээлгэх дотоод хяналтын бүтэцтэй байх.

4.3.Мэргэжлийн холбооны удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шалгуурыг хангасан байна.

4.4.Мэргэжлийн холбооны бүх гишүүдийн хурлаар баталсан Мэргэжлийн холбооны дүрэм болон холбогдох бусад дүрэм, журам нь Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль болон Хорооны холбогдох журамд нийцсэн байна.

4.5.Мэргэжлийн холбоо дараах зарчмыг үйл ажиллагаандаа баримталж ажиллана:

4.5.1.хууль тогтоомж, Хорооноос баталсан журмыг мөрдөх;

4.5.2.гишүүдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, тэдгээрийн санал санаачилгыг дэмжих;

4.5.3.гишүүнчлэлийн хураамжийн зарцуулалт, тайлагнал ил тод, нээлттэй байх;

4.5.4.гишүүдийн мэдээллийн нууцыг хадгалах;

4.5.5.ВХҮҮ-ийн зах зээлийн нөхцөл байдал, гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөхдөө судалгаа шинжилгээнд суурилсан байх.

4.6.Мэргэжлийн холбоо нь гишүүд болон мэргэжлийн оролцогчдод зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулж, Хороотой хамтран батална.

4.7.Мэргэжлийн холбооны хаяг байршил, удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал өөрчлөгдөх тухай бүр Хороонд мэдэгдэнэ.

*“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл
ажиллагааны журам”-ын хавсралт*

**ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНДАА МӨРДӨХ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
СТАНДАРТЫН ЖАГСААЛТ**

№	Стандартын нэр	
1	MNS 5969	Мэдээллийн технологи-Аюулгүй байдлын арга техник-Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага
2	MNS 6244	Программ хангамжийн боловсруулалт – Программ хангамжийн бүтээгдэхүүний чанарын шаардлага болон үнэлгээ (SQuaRE) – Төлөвлөлт болон удирдлага
3	MNS 6197	Мэдээллийн технологи-Мэдээллийн аюулгүй байдал-Криптографийг хэрэгжүүлэх удирдамж
4	MNS 6242-2	Мэдээллийн технологи-Аюулгүй байдлын арга-Мэдээллийн технологийн сүлжээний аюулгүй байдал-2-р хэсэг: Сүлжээний аюулгүй байдлын архитектур
5	MNS ISO 12207	Программ хангамж боловсруулах үйл ажиллагааны циклүүд
6	MNS ISO 19011	Менежментийн тогтолцооны аудитын заавар
7	MNS ISO/IEC 27001	Мэдээллийн технологи: Аюулгүй байдлын арга техник-Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо-Шаардлага
8	MNS ISO/IEC 13335-1	Мэдээллийн технологи-Аюулгүй байдлын арга техник-Мэдээллийн ба холбооны технологийн байдлын удирдлага-1-р хэсэг: Мэдээлэл холбооны технологийн аюулгүй байдлын үндсэн ойлголтууд болон загварууд
9	IEEE 829	Программ хангамж турших болон баримт бичигжүүлэлтийн стандарт
10	MNS 6498	Харилцаа холбооны тоног төхөөрөмжид тавих аюулгүй байдлын шаардлага
11	MNS 6528	Дата төвийн цахилгаан холбооны дэд бүтэц

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 7676 дугаарт бүртгэв

**САНГИЙН САЙД,
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ**

2026 оны 8 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар А/180, А/305

Улаанбаатар
хот

ЖУРАМ, АРГАЧЛАЛ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.11 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.“Баталгаажсан үүлдэр, омгийн болон гойд ашиг шимт үржлийн мал, амьтны үнэлгээ хийх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Баталгаажсан үүлдэр, омгийн болон гойд ашиг шимт үржлийн мал, амьтны үнэлгээ хийх аргачлал”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Б.Анар), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Т.Жамбалцэрэн) нарт даалгасугай.

САНГИЙН САЙД

З.МЭНДСАЙХАН

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

Ц.ИДЭРБАТ

*Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын
хамтарсан 2026 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн А/180, А/305
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

БАТАЛГААЖСАН ҮҮЛДЭР, ОМГИЙН БОЛОН ГОЙД АШИГ ШИМТ ҮРЖЛИЙН МАЛ, АМЬТНЫ ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Баталгаажсан үүлдэр, омгийн болон гойд ашиг шимт үржлийн мал, амьтан (цаашид “мал” гэх)-ы үнэлгээ хийхтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2.4-т заасан амьтны үнэлгээг Засгийн газрын тогтоолоор батлагдсан Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг үндэслэн тодорхойлно.

1.3.Малын үнэлгээ хийхэд Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хууль, Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малын тоо толгойн албан татварын тухай хууль, Үнэлгээний олон улсын стандарт (цаашид “ҮОУС” гэх), бусад холбогдох хууль, журам, аргачлалыг баримтална.

1.4.Малын үнэлгээг Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан үндэслэлээр үнэлгээчин, үнэлгээний хуулийн этгээд (цаашид “үнэлгээчин” гэх) хийнэ.

1.5.Малын үүлдэр, омог шинээр бий болгох судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг Сангийн сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэлгээ хийх журам, аргачлал”-ыг баримтлан үнэлнэ.

1.6.Монгол Улсад өсгөн үржүүлсэн, Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталгаажсан үүлдэр, омгийн мал болон гадаад улсаас импортолсон цэвэр үүлдрийн малыг өмчийн харьяалал үл харгалзан үнэлгээнд хамруулна.

1.7.Энэ журмаар хийх хөрөнгийн үнэлгээнд дараах малыг хамруулахгүй:

1.7.1.баталгаажуулаагүй үүлдэр, омгийн мал;

1.7.2.журмын 1.6-д заасан шаардлагыг хангаагүй мал;

Хоёр. Хөрөнгийн үнэлгээнд тавигдах шаардлага

2.1.Үнэлгээчин нь үнэлгээ хийхдээ дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1.үнэлгээчний эрх, хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх;

2.1.2.хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагаас зохион байгуулсан малын үнэлгээ хийх сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх.

2.2.Үнэлгээчин нь Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтран баталсан “Баталгаажсан үүлдэр, омгийн болон гойд ашиг шимт үржлийн мал, амьтны үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан үнэлгээ хийнэ.

2.3.Үнэлгээчин нь хөрөнгийн үнэлгээ хийхдээ Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу үнэлгээний хараат бус байдлыг хангаж ажиллана.

2.4.Үнэлгээчин нь үнэлгээ хийхдээ мэргэжлийн байгууллагаас Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 23.1.5-д заасан олон улсын хөрөнгийн үнэлгээний тайлагналын стандартын дагуу боловсруулан гаргасан гэрээт ажлын захидал, үнэлгээний шалгах хуудас зэрэг үлгэрчилсэн загвар, заавар, хэрэглээний тайлбар, зөвлөмжийг мөрдөнө.

2.5.Үнэлгээчин нь үнэлгээний зорилго, зориулалт, хэрэглэх үнэ цэнийн суурь, үнэлгээний өдөр, үнэлгээ хийх хугацаа, үнэлгээний үр дүнг хэрэглэх нөхцөл зэрэг ажлын цар хүрээг үйлчлүүлэгчид танилцуулан гэрээт ажлын захидлаар баталгаажуулна.

2.6.Үнэлгээчин нь үнэлгээний ажлын цар хүрээг гэрээт ажлын өмнө тодорхойлж, үйлчлүүлэгчид танилцуулна.

2.7.Үнэлгээчин нь үнэлгээ хийх бэлтгэл ажлын хүрээнд тухайн мал, амьтны мэдээллийг Малын генетик нөөцийн бүртгэлийн мэдээллийн сантай тулган баталгаажуулж үнэлгээнд хэрэглэнэ.

2.8.Гэрээт ажлын захидал нь хөрөнгийн үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхтэй холбогдуулан үнэлгээний ажлын үндсэн нөхцөлүүд, ажлын цар хүрээг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг харилцан тохиролцож, зөвшөөрснийг нотлох гэрээний адил хүчин төгөлдөр бичиг баримт байна.

2.9.Малын онцлог, тодорхой бус, нарийн төвөгтэй байдлыг харгалзан мал зүйч, холбогдох салбарын мэргэжилтнийг үнэлгээнд оролцуулж болно.

Гурав.Хөрөнгийн үнэлгээний тайлан

3.1.Үнэлгээний тайланг Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 8.2-т заасан шаардлага, ҮОУС-д нийцүүлэн бэлтгэнэ.

3.2.Үнэлгээчин нь хөрөнгийн үнэлгээний тайланд мэргэжлийн байгууллагын тайлангийн мэдээллийн санд бүртгүүлсэн цахим дугаарыг хэрэглэнэ.

3.3.Үнэлгээчин нь үнэлгээний тайланг үйлчлүүлэгчид хүлээлгэн өгснөөс хойш ажлын 5 өдрийн дотор Хөрөнгийн үнэлгээний тухай

хуулийн 25.2-т заасан мэдээллийг хөрөнгийн үнэлгээний мэдээллийн санд оруулна.

3.4.Үнэлгээчин нь холбогдох хууль, дүрэм журмыг баримтлан үнэлгээ хийх явцад ҮОУС-д зааснаас өөр шаардлага тавигдан гажилт үүссэн тохиолдолд үнэлгээний тайланд тодруулга хийн, баримтжуулна.

Дөрөв.Үнэлгээний үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалт

4.1.Үнэлгээчин нь хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаандаа дотоод чанарын хяналтыг хэрэгжүүлнэ.

4.2.Үнэлгээчин нь хөрөнгийн үнэлгээ хийхэд ашигласан орц мэдээлэл болох үйлчлүүлэгчээс хүлээн авсан мэдээлэл, цуглуулсан судалгаа, нотолгоо баримт мэдээллийг үнэлгээний тайлангийн хамт архивын нэгж болгон хадгална.

4.3.Үнэлгээчин Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 13.2-т заасан хараат бус байх нөхцөл, шаардлагыг зөрчсөн гэж үзвэл захиалагч, үйлчлүүлэгч болон гуравдагч этгээд нь хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагад хандан гомдол гаргах эрхтэй.

4.4.Үнэлгээний тайлантай холбоотой гомдлыг хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын дэргэдэх Мэргэжлийн зөвлөл, үнэлгээчний ёс зүйтэй холбоотой гомдлыг Ёс зүйн зөвлөл хянан шийдвэрлэнэ.

*Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын
хамтарсан 2026 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн А/180, А/305
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт*

БАТАЛГААЖСАН ҮҮЛДЭР, ОМГИЙН БОЛОН ГОЙД АШИГ ШИМТ ҮРЖЛИЙН МАЛ, АМЬТНЫ ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Баталгаажсан үүлдэр, омгийн болон гойд ашиг шимт үржлийн мал, амьтан (цаашид “мал” гэх)-ы үнэлгээ хийхэд энэхүү аргачлалыг баримтална.

Хоёр.Хөрөнгийн үнэлгээ хийх ажлын үе шат

2.1.Үнэлгээчин нь үнэлгээ хийхдээ дараах үе шатыг баримтална:

2.1.1.үнэлгээний ажлын зорилго, зориулалтад нийцүүлэн үнэ цэнийн суурийг сонгож, ажлын цар хүрээг тодорхойлох;

2.1.2.үнэлгээний зүйлтэй танилцан үнэлгээний ажлын төлөвлөгөө, хуваарийг боловсруулах;

2.1.3.үйлчлүүлэгчтэй хөрөнгийн үнэлгээ хийх гэрээ байгуулж, гэрээт ажлын нөхцөлийг тохиролцож гэрээт ажлын захидлаар баталгаажуулах;

2.1.4.шаардлагатай мэдээллийн судалгаа хийж, мэдээллийн найдвартай, бодитой байдлыг нягтлан шинжилгээ хийх;

2.1.5.үнэлгээний тохиромжтой хандлага, аргуудыг сонгож, үнэ цэнийн тооцоолол хийх;

2.1.6.үнэлгээний үр дүнг нэгтгэн хөрөнгийн үнэлгээний тайлан бэлтгэж, үйлчлүүлэгчид танилцуулах.

2.2.Үнэлгээчин нь үнэлгээний зорилго, үнэ цэнийн суурийг дор дурдсанаар сонгон хэрэглэнэ:

2.2.1.санхүүгийн тайлагналын зорилгоор бодит үнэ цэнийн суурь;

2.2.2.хөрөнгөтэй холбоотой маргааныг оролцогч талуудад хамааралтайгаар тодорхойлох тохиолдолд тэгш шударга үнэ цэнийн суурь;

2.2.3.бусад тохиолдолд зах зээлийн үнэ цэнийн суурь.

2.3.Үнэлгээчин нь дор дурдсан мэдээллийн судалгаа хийнэ:

2.3.1.гойд ашиг шимт мал шалгаруулах үзэсгэлэн дуудлага худалдааны үнийн мэдээлэл;

2.3.2.“Төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг тогтоох журам”-аар тодорхойлсон бүсэд үржүүлсэн эсэх;

2.3.3.хувийн дугаар, гарвал, удам зүйн үнэлгээний мэдээлэл;

2.3.4.малын бүртгэл, мэдээллийн сангийн мэдээлэл;

2.3.5.малын ашиг шимийн үзүүлэлт, үнэлгээний мэдээлэл;

2.3.6.мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан эсэх талаар мэдээлэл;

2.3.7.малын зах зээлийн үнийн мэдээлэл;

2.3.8.ашиг шимийн гарц болох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн мэдээлэл;

2.3.9.өмчлөгч, эзэмшигч, ашиглагч байгууллагын удирдлага, хувь хүнтэй хийсэн уулзалт, ярилцлага, лавлагаагаар авсан дотоод мэдээлэл;

2.3.10.малын үүлдэр, омгийг тогтоосон стандарт, дүрэм, журам;

2.3.11.бусад.

2.4.Үнэлгээчин нь дараах хүчин зүйлийг харгалзан үнэлгээ хийх аргыг сонгоно:

2.4.1.үнэлгээний зорилго;

2.4.2.үнэлгээний гэрээт ажлын нөхцөл;

2.4.3.үнэ цэнийн суурь;

2.4.4.мэдээллийн найдвартай, бэлэн олдоцтой байдал;

2.4.5.бусад.

2.5.Цуглуулсан мэдээллийн бодитой, найдвартай байдлыг үнэлж, дүгнэхийн тулд дараах шинжилгээнүүдийг хийвэл зохино:

2.5.1.макро эдийн засгийн, салбарын, зах зээлийн шинжилгээ;

2.5.2.хөрөнгийн ашиглалтын байдал, өгөөжийн шинжилгээ;

2.5.3.бусад.

Гурав.Үнэлгээ хийх хандлага, аргууд

3.1.Үнэлгээчин нь зах зээлийн, орлогын, өртгийн хандлагын тохиромжтой аргыг ашиглан малын үнэлгээ хийнэ.

3.2.Үнэлгээний гэрээт ажлын нөхцөл, үнэлгээний зорилго, орц мэдээллийн найдвартай, бэлэн олдоцтой байдал, үнэлгээний хандлагыг хэрэглэх нөхцөлийг харгалзан хэд хэдэн аргыг сонгон хэрэглэсэн бол аргуудын үр дүнг шинжлэн тохируулж, үнэ цэнийн эцсийн дүгнэлтийг гаргана.

Дөрөв.Зах зээлийн хандлага

4.1.Зах зээлийн хандлагыг үнэлж байгаа малыг жишиж болох ижил, төстэй малын арилжааны үнийн мэдээлэл бэлэн олдоцтой байгаа тохиолдолд хэрэглэнэ.

4.2.Зах зээлийн хандлагаар малыг үнэлэхдээ шууд жиших арга, харьцуулан жиших аргын аль тохиромжтойг сонгоно:

4.2.1.шууд жиших арга (Direct match). Энэ аргаар үнэлж буй мал, амьтантай үүлдэр, омог, нас, хүйс ижил, биеийн хэмжээ, жин, ашиг шимийн гарц нь төстэй малын зах зээлийн үнэд ялгаатай байдлыг тохируулан үнэлдэг;

4.2.2.харьцуулан жиших арга (Comparable match). Энэ аргаар үнэлж буй мал, амьтантай төрөл, ашиг шимийн үндсэн чиглэл нь ижил, үүлдэр, омог, нас, биеийн хэмжээ, жин, ашиг шимийн гарц нь төстэй малын зах зээлийн үнэд ялгаатай байдлыг тохируулан үнэлдэг;

4.3.Зах зээлийн хандлагаар үнэлгээ хийхдээ дараах үе шатыг баримтална:

4.3.1.харьцуулалт хийх үзүүлэлт (тоо толгой, нас, хүйс)-ийг тодорхойлох;

4.3.2.тохиромжтой жиших нэгж (үүлдэр, омог, ашиг шимийн үндсэн чиглэл, ашиг шимийн гарц г.м)-ийг тодорхойлох;

4.3.3.үнэлгээний өдрөөс өмнө, ойрхон хийгдсэн арилжааны жишиж болохуйц зах зээлийн мэдээллийг цуглуулах;

4.3.4.жишиж буй болон үнэлж буй малын хоорондох ижил төстэй ба ялгаатай талуудын зэрэгцүүлсэн шинжилгээ хийх;

4.3.5.зэрэгцүүлсэн шинжилгээг үндэслэн тохируулга хийж арилжааны тохируулга хийгдсэн малын жиших үнийг тодорхойлох;

4.3.6.тохируулга хийгдсэн жишиг үнийг ач холбогдлын хувийн жингээр жинлэн үнэлж буй малын үнэ цэнийг тодорхойлох.

4.4.Ижил, төстэй ба ялгаатай талуудын тохируулгыг хийхдээ дараах хүчин зүйлсийг харгалзана:

4.4.1.арилжааны нөхцөл;

4.4.2.санхүүжилтийн нөхцөл;

4.4.3.хэлцлийн нөхцөл;

4.4.4.удам зүй, гарал үүсэл;

4.4.5.байршил;

4.4.6.биет байдал (нас, хүйс, амьдын жин, биеийн хэмжээ, ашиг шимийн гарц, гм);

4.4.7.арилжаа хийгдсэн цаг хугацаа, үнэ;

4.4.8.бусад.

4.5.Тохируулга хийгдсэн жишиг үнийг жинлэх ач холбогдлын хувийн жинг дор дурдсан дарааллаар тодорхойлно:

4.5.1.тохируулга хийж байгаа үзүүлэлт нь үнэлж буй ба жишиж буй хөрөнгийн хувьд ижил бол 1 гэсэн тохируулгын итгэлцүүр өгөх;

4.5.2.жиших хөрөнгө тус бүрийн хувьд тохируулга хийж дууссаны дараа 1 гэсэн тохируулгын итгэлцүүрийн тоог гаргах;

4.5.3.итгэлцүүрийн нийлбэр дүнг гаргах;

4.5.4.жиших хөрөнгө тус бүрийн итгэлцүүрийн тоог итгэлцүүрийн нийлбэр дүнд харьцуулан ач холбогдлын хувийн жинг тодорхойлно.

4.6.Зах зээлийн хандлагыг үнэлгээнд ашиглаагүй ч зах зээлийн орц мэдээллийг бусад хандлага, аргуудад ашиглаж болно.

Зах зээлийн хандлагын харьцуулан жиших аргаар малын үнэлгээ хийх үлгэрчилсэн загвар хүснэгт 1

№	Үзүүлэлт		Тооцоолол	Харьцуулах хөрөнгө		
				№1	№2	№3
1	Худалдсан он, сар					
2	Санал болгосон үнэ, мян.төг		A			
3. Ажил гүйлгээний тохируулга	1	Хөрөнгийн шилжүүлэх эрхийн тохируулга	$TA1$			
		Тохируулга хийгдсэн дүн	$B=A\pm TA1$			
	2	Санхүүжилтийн нөхцөлийн тохируулга	$TA2$			
		Тохируулга хийгдсэн дүн	$B=B\pm TA2$			
	3	Борлуулалт, хэлцлийн нөхцөлийн тохируулга	$TA3$			
		Тохируулга хийгдсэн дүн	$B=B\pm TA3$			
	4	Худалдан авсны дараа гарах зардлын тохируулга	$TA4$			
		Тохируулга хийгдсэн дүн	$B=B\pm TA4$			
4	5	Зах зээлийн нөхцөл байдлын тохируулга	$TA5$			
		Арилжааны тохируулга хийгдсэн жиших үнэ, мян.төг	$B=B\pm TA5$			
5. Хөрөнгийн тохируулга	1	Байршлын тохируулга	$T1$			
		Тайлбар				
	2	Биет байдлын тохируулга	$T2$			
		Тайлбар				
	3	Эдийн засгийн шинж чанарын тохируулга	$T3$			
		Тайлбар				
	4	Эрх зүйн шинж чанарын тохируулга	$T4$			
		Тайлбар				
5		Бусад тохируулга	$T5$			
		Тайлбар				
6	Хөрөнгийн тохируулгын хэмжээ		$Tj=\prod Ti$			
7	Тохируулга хийгдсэн нэгжийн жиших үнэ, мян.төг		$Ej=Dj*Tj$			
8. Жинлэл	1	Ач холбогдлын коэффициент	$\sum Wj=1$			
	2	Жинлэсэн дүн, мян.төг	$Fj=Ej*Wj$			
9	Үнэлж буй малын үнэ, мян.төг		$p=\sum Fj$			

Тав.Орлогын хандлага

5.1.Орлогын хандлагыг дараах тохиолдолд хэрэглэнэ:

5.1.1.малын ашиг, шим болон үржил, хээлтүүлгийн үйл ажиллагаанаас орлого, мөнгөн гүйлгээг олдог байх;

5.1.2.малын бий болгох мөнгөн гүйлгээг үндэслэлтэй тооцох боломжтой байх, уг мөнгөн гүйлгээ нь биет бус хөрөнгө, гудвилл, бусад хамтдаа ашиглагддаг хөрөнгө (эрчимжсэн аж ахуйгаас бусад)-тэй хамааралгүй тодорхойлох боломжтой байх.

5.2.Орлогын хандлагаар малыг үнэлэхдээ хорогдуулсан мөнгөн гүйлгээний аргыг хэрэглэнэ.

5.3.Хорогдуулсан мөнгөн гүйлгээний аргаар малын үнэ цэнийг тооцоход ашиглах мөнгөн гүйлгээ нь бизнесийн үйл ажиллагааны бус зөвхөн тухайн малыг бий болгох мөнгөн гүйлгээ байна. Мөнгөн гүйлгээнд хүүгийн орлого, хүүгийн зардал, даатгалын төлбөр, биет бус хөрөнгө болон ажлын капиталын өөрчлөлтийг тооцохгүй.

5.4.Хорогдуулсан мөнгөн гүйлгээний аргаар үнэлгээ хийхдээ дараах үе шатыг баримтална:

5.4.1.үнэлгээний зорилго, малын шинж чанараас хамаарч мөнгөн гүйлгээний төрлийг сонгох;

5.4.2.малын ирээдүйн ашиглалттай холбоотой мөнгөн гүйлгээний төсөөлөл хийх хугацаа, үечлэлийг тодорхойлох;

5.4.3.хугацааны үе тутамд цэвэр (олох мөнгөн гүйлгээнээс зарцуулах мөнгөн гүйлгээг хасаж) мөнгөн гүйлгээний дүнг тооцоолох;

5.4.4.төсөөлсөн хугацааны эцэст үлдэх (терминал) үнэ цэнийг тооцоолох;

5.4.5.хорогдуулгын хувийг тооцоолох;

5.4.6.үе тутмын цэвэр мөнгөн гүйлгээ болон үлдэх үнэ цэнийн өнөөгийн үнэ цэнийн нийлбэрээр үнэлж буй малын үнэ цэнийг тооцоолох.

5.5.Мөнгөн гүйлгээний төсөөллийг хийхдээ орлого ба үйл ажиллагааны зардлын мэдээллийг анхдагч мэдээллийн эх үүсвэр (эрх бүхий байгууллага, мал аж ахуй эрхлэгч, өмчлөгч, эзэмшигч, мал зүйч) ба хоёрдогч мэдээллийн эх үүсвэр (нийтэд зарласан мэдээллүүд)-ээс цуглуулна.

5.6.Мөнгөн гүйлгээний орлогын төсөөлөлд дор дурдсан орлогыг хамруулна:

5.6.1.малын төсөөлж буй ашиглалтаас хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээс хүлээгдэж буй орлого;

5.6.2.хууль, дүрэм журмын зохицуулалттай холбоотой татаас, хөнгөлөлт, урамшууллын орлого;

5.6.3.малын түрээсийн орлого.

5.7.Мөнгөн гүйлгээний зардлын төсөөлөлд дор дурдсан зардлыг хамруулна:

5.7.1.үржил, хээлтүүлгийн зардал;

5.7.2.тэжээл, маллагааны зардал;

5.7.3.эмчилгээ, вакцинжуулалтын зардал;

5.7.4.эрх бүхий байгууллагад төлөх төлбөр, хураамж, шимтгэл;

5.7.5.малын даатгалын зардал;

5.7.6.патент, лиценз, эзэмших эрхийн төлбөр;

5.7.7.шаардлагатай барилга, байгууламж, бусад хөрөнгийн түрээсийн төлбөр (шаардлагатай бол);

5.7.8.удирдлагын зардал (шаардлагатай бол).

5.8.Мөнгөн гүйлгээний төсөөлөлд татвар, өр зээл, элэгдлийн зардлыг тооцохгүй.

5.9.Энэ аргачлалын 5.4.5-д заасан хорогдуулах хувийг капитал хөрөнгийн үнэ тогтоох загвар арга (CAPM), капиталын жинлэсэн дундаж өртгийн загвар арга (WACC), нийлбэрийн аргын аль оновчтойг сонгон тодорхойлно.

Орлогын хандлагын хорогдуулсан мөнгөн гүйлгээний аргаар үржлийн зориулалттай эцэг малын үнэлгээ хийх үлгэрчилсэн загвар хүснэгт 2

№	Үзүүлэлт	Тооцоолол	Төсөөллийн жилүүд (хээлтүүлэх хугацаа, жилээр)			
			1	2	3	г.м
1	Хээлтэгчийн тоо	X				
2	Төл хүлээн авалтын хувь	Ta				
3	Төлийн хүлээгдэж буй тоо	$T = X * Ta$				
4	Төлийн хүлээгдэж буй жин (кг)	$ЖТ$				
5	Төлийн хүлээгдэж буй борлуулалтын үнэ, төг.кг	$ҮТ$				
6	Хээлтүүлэгчид төлөөс хуримтлагдах үнэ цэний хувь	$Хт$				
7	Төлийн зүй бус хорогдлын хувь	$Эх$				
8	Ашиглалтын бусад орлого, мян.төг	E_i				
9	Бодит орлого, мян.төг	$БО = T * ЖТ * ҮТ * Хт + E_i$				

	Хөрөнгийн ашиглалтын зардлууд, мян. төг:	$H3_i = \sum_{i=1}^n 3_i$					
	10.1 үржил, хээлтүүлгийн зардал	3_1					
	10.2 тэжээл, маллагааны зардал	3_2					
	10.3 эмчилгээ, вакцинжуулалтын зардал	3_3					
	10.4 эрх бүхий байгууллагад төлөх төлбөр, хураамж, шимтгэл	3_4					
10	10.5 малын даатгалын зардал	3_5					
	10.6 патент, лиценз, эзэмших эрхийн төлбөр	3_6					
	10.7 шаардлагатай барилга, байгууламж, бусад хөрөнгийн түрээсийн төлбөр (шаардлагатай бол)	3_7					
	10.8 удирдлагын зардал (шаардлагатай бол)	3_8					
11	Татварын өмнөх ашиг, мян.төг	$T\Theta A_i = 5O_i - H3_i$					
12	Орлогын татвар, мян.төг	$T_i = T\Theta A_i * 10\%$					
13	Цэвэр мөнгөн урсгал, мян.төг	$ЦМУ = T\Theta A_i - T_i$					
14	Амьдын жин (кг)	W					
15	Үлдэх үнэ цэнэ (Ашиглалтын эцэст борлуулалтын үнэ), мян.төг	TV	-	-	-	-	
16	Элэгдлийн зардал, мян.төг						
17	Хорогдуулах хувь	R_i					
18	Өнөөгийн үнэ цэнийн коэффициент	$K_i = 1/(1 + R)^i$					
19	Цэвэр мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ	$PV_i = ЦМУ_i * K_i$					
21	Үнэлж буй малын үнэ цэнэ, мян.төг	$P_2 = \sum_{i=1}^n PV_i + TV$					

Орлогын хандлагын хорогдуулсан мөнгөн гүйлгээний аргаар сүүний чиглэлийн эх малын үнэлгээ хийх үлгэрчилсэн загвар хүснэгт 3

№	Үзүүлэлт	Тооцоолол	Төсөөллийн жилүүд (төллөх хугацаа, жилээр)				
			1	2	3		г.м
1	Жилийн саалийн хугацаа (хоног)	D					
2	Хонгийн саалийн хэмжээ (л)	L					
3	Сүүний үнэ, төг	P					
4	Төлийн хүлээгдэж буй борлуулалтын үнэ, төг.кг	Y_T					
5	Ашиглалтын бусад орлого, мян.төг	E_i					

6	Бодит орлого, мян.төг	$BO = D * L * P + Y_T + E_i$					
7	Хөрөнгийн ашиглалтын зардлууд, мян. төг:	$H3_i = \sum_{i=1}^n 3_i$					
	7.1 үржил, хээлтүүлгийн зардал	3_1					
	7.2 тэжээл, маллагааны зардал	3_2					
	7.3 эмчилгээ, вакцинжуулалтын зардал	3_3					
	7.4 эрх бүхий байгууллагад төлөх төлбөр, хураамж, шимтгэл	3_4					
	7.5 малын даатгалын зардал	3_5					
	7.6 патент, лиценз, эзэмших эрхийн төлбөр	3_6					
	7.7 шаардлагатай барилга, байгууламж, бусад хөрөнгийн түрээсийн төлбөр (шаардлагатай бол)	3_7					
	7.8 удирдлагын зардал (шаардлагатай бол)	3_8					
8	Татварын өмнөх ашиг, мян.төг	$T\Theta A_i = BO_i - H3_i$					
9	Орлогын татвар, мян.төг	$T_i = T\Theta A_i * 10\%$					
10	Цэвэр мөнгөн урсгал, мян.төг	$\text{ЦМУ} = T\Theta A_i - T_i$					
11	Амьдын жин (кг)	W					
12	Үлдэх үнэ цэнэ (Ашиглалтын эцэст борлуулалтын үнэ), мян.төг	TV	-	-	-	-	
13	Хорогдуулах хувь	R_i					
14	Өнөөгийн үнэ цэнийн коэффициент	$K_i = 1 / (1 + R_i)^i$					
15	Цэвэр мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ	$PV_i = \text{ЦМУ}_i * K_i$					
16	Үнэлж хөрөнгийн үнэ цэнэ, мян.төг	$P_z = \sum_{i=1}^n PV_i + TV$					

Зургаа.Өртгийн хандлага

6.1.Өртгийн хандлагыг дараах тохиолдолд хэрэглэнэ:

6.1.1.идэвхтэй зах зээл байхгүй, ховор учир зах зээлийн хандлагыг хэрэглэх боломжгүй байгаа үед;

6.1.2.шууд орлого бий болгодоггүй учраас орлогын хандлагыг хэрэглэх боломжгүй байгаа үед.

6.2.Өртгийн хандлагаар үнэлгээ хийхдээ дараах үе шатыг баримтална:

6.2.1.үнэлж буй малтай адилтгах ашигт чанар бүхий малын орлуулалтын өртгийг тодорхойлох;

6.2.2.хэрэв өмнө хийгдсэн ашиг шимийн үнэлгээ нь үнэлгээний өдрийн байдлаар буурсан бол үнэлж буй хөрөнгийн насжилтыг тусгах зорилгоор эдийн засгийн хоцрогдлыг тодорхойлно;

6.2.3.үнэлж буй малын үнэ цэнийг орлуулалтын өртгөөс эдийн засгийн хоцрогдлыг хасах замаар тодорхойлно.

6.3.Малын үнэлгээнд орлуулалтын өртгийг тооцохдоо дараах аргуудаас аль тохиромжтойг сонгон хэрэглэнэ:

6.3.1.үйлдвэрлэлийн өртгийн арга (Cost of production). Энэ аргаар малаас олж авах өртөг болон ашиглалтын тодорхой үе (үнэлгээний өдөр) хүртэлх үйлдвэрлэлийн бүх зардлын нийлбэрээр орлуулалтын өртгийг тодорхойлдог;

6.3.2.түүхэн өртгийг арга (Historical cost). Энэ аргаар малаас олж бэлтгэхэд төлсөн бодит өртгөөр орлуулалтын өртгийг тодорхойлдог;

6.3.3.орлуулалтын өртгийн арга (Replacement cost). Энэ аргаар ижил ашигт шимт малыг олж бэлтгэх үнэлгээний өдрийн өртгөөр орлуулалтын өртгийг тодорхойлдог.

6.4.Үйлдвэрлэлийн өртгийн аргыг малын худалдан авалтаас хойш ашиг шим, ашиг шимийн гарцыг нэмэгдүүлж, үнэ цэнийг нэмэгдүүлэх зардал гаргасан тохиолдолд хэрэглэх ба үйлдвэрлэлийн өртөгт дор дурдсан зардлуудыг оруулж тооцоолно:

6.4.1.шууд зардал

- 1) малыг худалдан авах үнэ;
- 2) тэжээл, маллагааны зардал
- 3) эмчилгээ, вакцины зардал;
- 4) хээлтүүлэг, үржлийн зардал
- 5) тээврийн зардал;
- 6) гаалийн болон нэмэгдсэн өртгийн татвар;
- 7) бусад зардал.

6.4.2.шууд бус зардал

- 1) хяналт, шинжилгээний төлбөр;
- 2) удирдлагын зардал;
- 3) даатгалын зардал;
- 4) лиценз, тусгай зөвшөөрлийн зардал;
- 5) санхүүгийн зардал;
- 6) бусад зардал.

6.5.Түүхэн өртгийн аргыг үнэлж буй малыг саяхан худалдан авсан, эсхүл худалдан авалтаас хойш зах зээлийн төлөв байдал болон малын ашиглалт, ашиг шимт байдалд мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй үед хэрэглэнэ.

6.6.Орлуулалтын өртгийн аргыг малын худалдан авалтаас хойш ашиглалт, үр ашигт болон зах зээлийн төлөв байдалд мэдэгдэхүйц өөрчлөлт орсон, эсхүл түүхэн өртөг нь одоогийн орлуулалтын өртгийг илэрхийлж чадахгүй үед хэрэглэнэ. Орлуулалтын өртгийг тооцохдоо дараах зүйлсийг харгалзана:

6.6.1.худалдаж авсан эсхүл өсгөн үржүүлэхэд зайлшгүй гарах бүх зардлууд орсон эсэх, эдгээр зардлууд нь малын үнэ цэнд нөлөө үзүүлэх эсэхийг анхаарч үзнэ;

6.6.2.нээлттэй зах зээлийн оролцогчдод хамаарахгүй аливаа зардал, хөнгөлөлт, үнийн хямдруулалтыг тооцохгүй.

6.7.Энэ аргачлалын 6.2.2-т заасан эдийн засгийн хоцрогдлыг дараах үзүүлэлтийг харгалзан тодорхойлно:

6.7.1.салбарын зах зээл уналт;

6.7.2.ашиг шимийн гарцын бууралт;

6.7.3.ашиг шимийн бүтээгдэхүүний эрэлт, үнэ ханшийн бууралт;

6.7.4.зах зээлийн өрсөлдөөн их байх;

6.7.5.эрх бүхий байгууллагаас тариф, квот мөрддөг байх;

6.7.6.тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд хамааралтай хууль эрх зүй, даган мөрддөг стандартад өөрчлөлт орох.

6.8.Эдийн засгийн хоцрогдлыг тооцоолохдоо орц мэдээллийн хангалттай байдал, үнэлж буй хөрөнгийн онцлог байдлыг харгалзан ашиг шимийн түвшнийг сонгохдоо дараах зүйлийг анхааралдаа авсан байна:

6.8.1.махны чиглэлийн малын хувьд махан ашиг шимийг тодорхойлох үзүүлэлтүүд;

6.8.2.сүүний чиглэлийн малын хувьд сүүн ашиг шимийг тодорхойлох үзүүлэлтүүд;

6.8.3.үржлийн чиглэлийн малын ашиг шимийн суурь үзүүлэлт нь төл хүлээн авалт;

6.8.4.ноос, ноолуурын чиглэлийн малын ашиг шимийн суурь үзүүлэлт нь ноос, ноолуурын гарц;

6.8.5.хосолмол болон бусад ашиг шимийн суурь үзүүлэлтийг үнэлгээний зориулалтаас хамаарч оновчтой сонгон хэрэглэнэ.

6.9.Эдийн засгийн хоцрогдлыг дараах томъёогоор тодорхойлно:

$$\text{Эдийн засгийн хоцрогдлын хувь} = \left[1 - \frac{\text{Үнэлгээний үеийн ашиг шимийн түвшин}}{\text{Ашиг шимийн үнэлэгдсэн түвшин}} \right]$$

Өртгийн хандлагын орлуулалтын өртгийн аргаар малын үнэлгээ хийх үлгэрчилсэн загвар хүснэгт 4

№	Үзүүлэлт	Тооцоолол	Үнэлж буй объект
	Мал амьтны төрөл		
	Үүлдэр, угсаа, омог		
1	Бүртгэлийн дугаар	А	

2	Нас	B	
3	Хүйс	B	
4	Зүс	Γ	
5	Худалдан авсан (худалдан авах) өртөг, мян. төг	D	
6	Тохируулга		
6.1	Үнийн өсөлтийн	I_1	
6.2	Биет байдал	I_2	
6.3	Удамшил, генетик	I_3	
6.4	Үр шимийн чанар	I_4	
6.5	Бусад хүчин зүйлс	I_5	
7	Тохируулагдсан орлуулалтын нэгж өртөг, мян.төг	$\text{Нэгж Өртөг} = \Gamma * \prod_{i=1}^5 I_i$	
8	Бүрэн орлуулалтын өртөг, мян.төг	$BO\Theta = D \times \text{Нэгж Өртөг}$	
9	Үнэлгээний үеийн ашиг шимийн үзүүлэлт	$E_{\text{үнэлгээдэх үе}}$	
10	Ашиг шимийн үнэлгэгдсэн түвшин	$E_{\text{тогтоосон}}$	
11	Эдийн засгийн хоцрогдлын хувь	$\mathcal{E}_{\text{хувь}} = 1 - E_{\text{т}}$	
12	Эдийн засгийн хоцрогдол, мян.төг	$\mathcal{E}_{\text{дүн}} = BO\Theta * \mathcal{E}_{\text{хувь}}$	
13	Үнэлж буй малын үнэ цэнэ, мян.төг	$P_3 = BO\Theta - \mathcal{E}_{\text{дүн}}$	

Долоо.Хөрөнгийн үнэлгээний тайлан

7.1.Үнэлгээчин нь хөрөнгийн үнэлгээ хийсэн аргын сонголт, үнэлгээний үр дүнг эцэслэхэд хэрэглэсэн жинлэлт, үнэлгээний тооцоололд хэрэглэсэн гол хүчин зүйлүүдийн тодорхойлолт, тайлбар, судалгаа шинжилгээний дүгнэлт, үнэлгээний тооцооллын үндэслэлийг үнэлгээний тайланд тодорхой тусган тайлбарласан байна.

7.2.Үнэлгээчин нь малын биологи-аж ахуйн онцлог, ашиглалттай холбоотой гажилт нөхцөл, тэдгээрийн үнэлгээний үр дүн, тайлагналд нөлөөлсөн эсэх талаар үнэлгээний тайланд тусган тайлбарласан байна.

7.3.Үнэлгээний тайланд үнэлгээний үр дүнг хэрэглэх ба хязгаарлах нөхцөл, гажилт, хэрэглэсэн төсөөлөл нь нотлогдохуйц, үндэслэлтэй байна.

7.4.Салбарын мэргэжилтэн, мал зүйчийг үнэлгээний ажилд татан оролцуулсан тохиолдолд гаргасан дүгнэлт, тодорхойлолт, мэдээллийг нь үнэлгээний тайланд хавсаргасан байна.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН ТУШААЛ

2026 оны 07 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 138

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.5 дахь заалтад заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам”-ыг нэгдүгээр, “Галын аюулгүй байдлын дүгнэлтийн маягт”-ын загварыг хоёрдугаар, гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжүүлж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуянд даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Мөнх-Оргилд даалгасугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан, Монгол Улсын Шадар сайдын 2023 оны “Журам батлах тухай” 75 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

Н.НОМТОЙБАЯР

*Монгол Улсын Шадар сайдын 2026 оны 07 дугаар сарын 22-ны
өдрийн 138 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

**ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ
ГАРГАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Барилгын тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, галын аюулгүй байдлыг хангуулах норм, стандарт, дүрэм, журам нь энэхүү журмыг хэрэгжүүлэх үндэслэл болно.

1.2.Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах, цуцлах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.3.Гал түймрийн онц аюултай болон гал түймрийн аюултай 1, 2, 3 дугаар зэргийн барилга байгууламжид Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн гал түймрийн эрсдэлийн зэргийн ангилал”-д хамаарах барилга байгууламжийг ойлгоно.

Хоёр. Галын аюулгүй байдлын дүгнэлт олгох

2.1.Гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагч нь иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн албан хүсэлтийн дагуу хяналт шалгалтыг батлагдсан хяналтын хуудас эсхүл шалгалтын тэмдэглэл /цахим болон цаасан хэлбэр/-ээр хөтлөн зохион байгуулж шалгалтын дүнг үндэслэн Галын аюулгүй байдлын дүгнэлтийг дараах байдлаар олгоно. Үүнд:

2.1.1.газрын тосны бүтээгдэхүүний агуулахын галын аюулгүй байдлын дүгнэлтийг Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан бүтцийн нэгжийн Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч энэ тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан галын аюулгүй байдлын дүгнэлтийн маягыг хөтөлж, 2 жилийн хугацаатай;

2.1.2.гал түймрийн онц аюултай барилга байгууламжийн галын аюулгүй байдлын дүгнэлтийг Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч энэ тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан галын аюулгүй байдлын дүгнэлтийн маягыг хөтөлж, 2 жилийн хугацаатай;

2.1.3.газрын тосны бүтээгдэхүүн тээвэрлэх авто тээврийн хэрэгслийн галын аюулгүй байдлын дүгнэлтийг тухайн тээврийн хэрэгслийн улсын дугаараас хамаарч орон нутгийн улсын дугаартай тээврийн хэрэгсэлд тухайн аймгийн гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагч, Улаанбаатар хотын улсын дугаартай тээврийн хэрэгсэлд нийслэлийн Онцгой байдлын газрын гал түймрийн улсын

хяналтын ахлах байцаагч Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасны дагуу бичмэл дүгнэлт гаргаж, 2 жилийн хугацаатай олгоно.

2.1.4.гал түймрийн аюултай 1, 2, 3 дугаар зэргийн барилга байгууламжид иргэн, хуулийн этгээд өөрийн хүсэлтээр галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд энэ тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан маягтыг хөтөлж, 2 жилийн хугацаатай олгож болно.

2.1.5.бусад тохиолдолд иргэн, хуулийн этгээд бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаа мэдэгдэж, холбогдох зөвлөмжийг хүлээн авсан тохиолдолд галын аюулгүй байдлын дүгнэлттэй байхыг шаардахгүй.

2.1.6.гэрээт гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагч гэрээгээр ажиллаж байгаа байгууллагын хүсэлтээр журмын 2.1.2, 2.1.4-т заасны дагуу галын аюулгүй байдлын дүгнэлтийг олгоно.

2.2.Дүгнэлт олгосон Гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагч нь үнэт цаасан дүгнэлтийн хэвлэмэл маягтад гарын үсэг зурж тэмдэг дарах бөгөөд тухайн орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга, гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч гарын үсэг зуран тэмдэг дарж, баталгаажуулна.

2.3.Галын аюулгүй байдлын дүгнэлтийн хугацаа дууссан тохиолдолд дахин хүсэлтийн дагуу хяналт шалгалтыг зохион байгуулж шалгалтын дүнг үндэслэн дүгнэлтийг дахин олгож, хугацаа дууссан галын аюулгүй байдлын дүгнэлтийг хүчингүй болгон бүртгэл хөтөлнө.

2.4.Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн албан хүсэлтийг хүлээн авч хяналт шалгалтыг зохион байгуулж, Галын аюулгүй байдлын дүгнэлт олгох боломжтой эсэхийг ажлын 15 хоногийн дотор шийдвэрлэнэ.

Гурав. Галын аюулгүй байдлын дүгнэлтийг цуцлах, хүчингүй болгох

3.1.Гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагчийн албан ёсны шаардлагыг биелүүлээгүй, гал түймрийн зөрчил гарсан, галын аюулгүй байдлын шаардлага, дүрэм норм, стандартыг зөрчсөн тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу галын аюулгүй байдлын дүгнэлтийг дараагийн шатны гал түймрийн улсын хяналтын (ахлах, ерөнхий) байцаагч цуцална.

3.2.Цуцлагдсан, хүчингүй болгосон дүгнэлтийг сэргээж сунгахгүй. Гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагч дахин хяналт шалгалт хийж, шалгалтын дүнг үндэслэн галын аюулгүй байдлын дүгнэлтийг шинээр олгоно.

3.3.Галын аюулгүй байдлын дүгнэлт нь галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, норм дүрэм зөрчигдсөнөөс үүдэн гарсан

зөрчлийн болон эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Дөрөв. Иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг

4.1.Иргэн, хуулийн этгээдийн эрх

4.1.1.галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах хүсэлт гаргах;

4.1.2.галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах талаар зөвлөгөө, мэдээлэл авах;

4.1.3.галын аюулгүй байдлын дүгнэлт алдаатай буруу бол залруулах талаар хүсэлт гаргах;

4.1.4.эрх бүхий этгээдийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүй, шийдвэрийн талаар холбогдох хуульд заасны дагуу гомдол гаргах;

4.1.5.хуульд заасан бусад.

4.2.Иргэн, хуулийн этгээдийн үүрэг

4.2.1.Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах хүсэлт ирүүлэхдээ үйл ажиллагааны чиглэл, хаяг байршил, холбоо барих утсыг тодорхой бичих;

4.2.2.Үйл ажиллагаа эрхлэхдээ Галын аюулгүй байдлын тухай хууль, норм, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах;

4.2.3.Хуульд заасны дагуу тэмдэгтийн хураамж төлөх;

4.2.4.Галын аюулгүй байдлын дүгнэлтийн хугацаа дуусгавар болсон өдрөөс 1 сарын хугацаанд дахин сунгуулах;

4.2.5.Хуульд заасан бусад.

Тав. Галын аюулгүй байдлын дүгнэлт хэвлүүлэх, санхүүгийн тайлан гаргах тооцох

5.1.Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргахад Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу улсын тэмдэгтийн хураамжийг төрийн сангийн дансанд төвлөрүүлнэ.

5.2.Галын аюулгүй байдлын дүгнэлтийн маягт болон QR код бүхий цахим хуудсыг Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, хангалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж батлагдсан загварын дагуу хэвлүүлнэ.

5.3.Галын аюулгүй байдлын дүгнэлтийн QR код бүхий цахим болон үнэт цаасан хэвлэмэл маягт нь 20.2x28.7 см хэмжээтэй, тусгай дугаар, нууцлал бүхий тэмдгээр баталгаажсан байна.

5.4.Галын аюулгүй байдлын дүгнэлтийн QR код бүхий цахим хуудас болон үнэт цаасан хэвлэмэл маягт хуудас хэвлүүлэх зардлыг Онцгой байдлын ерөнхий газрын жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

5.5.Санхүүгийн мэдээ, тайланг төв орон нутгийн Онцгой байдлын байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, Сангийн яам, Татварын ерөнхий газраас батлан гаргасан зөвлөмж маягтын дагуу гаргаж, тухайн жилийн 07 дугаар

сарын 01, дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлнэ.

Зургаа. Хяналт, хариуцлага

6.1.Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 48 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Гал түймрийн улсын хяналтын дүрэм”-д заасны дагуу гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагчийн эрх, үүрэг, хариуцлагыг зохицуулна.

6.2.Галын аюулгүй байдлын дүгнэлт олгох, сунгах, хүчингүй болгох үйл ажиллагаанд Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан бүтцийн нэгж хяналт тавьж ажиллана.

6.3.Энэ журмыг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

өдрийн 138 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

28.7cm

№	Хяналт шалгалт хийх чиглэл	Хамрах стандарт, норм, дүрэм	Шалгалтад хамрагдсан	Шаардлага хангасан эсэх
1	Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж	Галыг ус, хөөсөөр унтраах төхөөрөмж		
		Утаа зайлуулах автомат систем		
		Гал түймрийг хянах ба хүлээн авах аппарат хэрэгслийн байрлал		
		Гал унтраагуур		
		Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл		
2	Гал унтраах бодис	Гал унтраах усан хангамж		
		Гал унтраах хөөс үүсгэгч бодис		
		Бусад		
3	Цахилгаан тоног төхөөрөмжийн байгууламж	Газардуулга ба цахилгааны аюулгүйн арга хэмжээ		
		Тусгай зориулалтын төхөөрөмжийн цахилгаан тоноглол		
4	Бусад	Хуваарилах байгууламж ба дэд өртөө		
		Авралтын зам гарц, тэмдэг, тэмдэглэгээ		

Шалгасан

Гал түймрийн улсын хяналтын байцаагч

.....цолтой.....

**Монгол Улсын Шадар сайдын 2026 оны 07 дугаар сарын 22-ны
өдрийн 138 дугаар тушаалын гуравдугаар хавсралт**

Монгол Улсын Шадар сайдын 2026 оны дугаар тушаалын гуравдугаар хавсралт	
ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ	
Дугаар	
Иргэн, хуулийн этгээдийн нэр:	
Хаяг:	
Эрхлэх үйл ажиллагааны чиглэл:	
Барилга байгууламж, газрын тосны бүтээгдэхүүн тээвэрлэх авто тээврийн хэрэгслийг ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно. /Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 19 дүгээр зүйлийн 19.2, 23 дугаар зүйлийн 23.3/ /Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4/	
Хяналт шалгалт хийсэн он сар өдөр	
Олгосон: он сар өдөр	
Хүчинтэй хугацаа: он сар өдөр хүртэл	
Баталгаажуулсан аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/ дарга цолтой	
Дүгнэлт олгосон аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/ Гал түймрийн улсын хяналтын байцаагч: цолтой	
/тэмдэг дарна/	

20.2cm

28.7cm

САНАМЖ

Галын аюулгүй байдлын дүгнэлтийг үйлчилгээний танхимд хүний нүдэнд харагдахуйц газар байрлуулсан байна.

Галын аюулгүй байдлын дүгнэлт нь үнэт цаас учраас гэмтээлгүй хадгалахаас гадна хувилж, үрэгдүүлж, олшруулж, хуурамчаар үйлдвэрлэсэн болон бусдад түрээслэх, худалдсан тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Галын аюулгүй байдлын дүгнэлт нь банкны зээлийн баталгаа, барьцаа болохгүй.

Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан норм, дүрэм, стандартыг зөрчсөн тохиолдолд Онцгой байдлын байгууллагын эрх бүхий албан тушаалтан хураан авах, цуцлах эрхтэй.

Галын аюулгүй байдлын дүгнэлтийн хугацаа дууссанаас хойш 1 сарын хугацаанд дахин сунгуулах.

Галын аюулгүй байдлын тухай хууль, норм, дүрэм стандарт зөрчигдсөнөөс үүдэн гарсан зөрчлийн болон эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

20.2cm

28.7cm

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 7678 дугаарт бүртгэв

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2026 оны 8 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар А/136

Улаанбаатар
хот

**ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙГ ЭРСДЭЛИЙН ЗЭРГЭЭР АНГИЛАХ
ЖУРМЫГ БАТЛАХ ТУХАЙ**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эмнэлгийн хэрэгслийг эрсдэлийн зэргээр ангилах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж, эмнэлгийн хэрэгслийг эрсдэлийн зэргээр ангилах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газар (Р.Энхсүрэн), Эмийн бүртгэлийн хэлтэс (Т.Мөнхтуул), Эмнэлгийн тоног төхөөрөмжийн салбар зөвлөл, Эмнэлгийн хэрэглэгдэхүүний салбар зөвлөл, Лабораторийн оношилгооны хэрэгслийн салбар зөвлөлд тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Хонгорзул)-т даалгасугай.

4.Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/125 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

П.АЛТАНЦЭЦЭГ

*Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын
2026 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн А/136 дугаар тушаалын
хавсралт*

ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙГ ЭРСДЭЛИЙН ЗЭРГЭЭР АНГИЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Үндэсний үйлдвэр болон импортын эмнэлгийн хэрэгслийг эрсдэлийн зэргээр ангилах, жагсаалт гаргах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журмын зорилго нь Монгол улсад үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах эмнэлгийн хэрэгслийг эрсдэлийн зэргээр ангилахад оршино.

1.3. Эмнэлгийн хэрэгслийг Монгол улсад үйлдвэрлэх, импортлох-ханган нийлүүлэх, худалдах харилцаанд оролцогч хуулийн этгээд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. Эрсдэлийн зэргээр ангилахад баримтлах зарчим

2.1. Эмнэлгийн хэрэгслийг эрсдэлийн зэргээр ангилсан жагсаалтад эмнэлгийн хэрэгслийг ерөнхий нэршлээр оруулна.

2.2. Эмнэлгийн хэрэглэгдэхүүн, эмнэлгийн тоног төхөөрөмжийг эрсдэлийн зэргээр бага (I), дунд (IIa, IIb), өндөр (III) эрсдэлтэй гэж ангилна.

2.3. Эмнэлгийн хэрэглэгдэхүүн, эмнэлгийн тоног төхөөрөмжийг эрсдэлийн зэргээр ангилахдаа дараах хүчин зүйлийг харгалзан үзнэ. Үүнд:

2.3.1. инвазив байдал (хүний биед нэвтэрдэг эсэх, нүх сүв эсхүл мэс заслын аргаар);

2.3.2. хэрэглэх хугацаа (түр зуур буюу ≤ 60 минут, богино хугацаа ≤ 60 минут ≤ 30 хоног, урт хугацаа > 30 хоног);

2.3.3. хүний биеийн аль хэсэгт хэрэглэгдэг эсэх (арьсан доор, судас дотор, төв мэдрэлийн системд гэх мэт);

2.3.4. хэрэглэх зориулалт (оношлох, эмчлэх, хянах гэх мэт);

2.3.5. идэвхтэй эсэх (цахилгаан болон бусад эрчим хүчээр ажилладаг эсэх).

2.4. Лабораторийн оношилгооны хэрэгслийг эрсдэлийн зэргээр бага (A), дунд (B, C), өндөр (D) эрсдэлтэй гэж ангилна.

2.5. Лабораторийн оношилгооны хэрэгслийг эрсдэлийн зэргээр ангилахдаа дараах хүчин зүйлийг харгалзан үзнэ. Үүнд:

2.5.1. шинжилгээний үр дүн алдаатай гарсан тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хувь хүний амь насанд эрсдэлтэй эсэх;

2.5.2.хэрэглэх зорилго, хамрах хүрээ (оношилгоо, донорын шалгалт, хяналт гэх мэт);

2.5.3.илрүүлж буй агентын шинж чанар (халдварт үүсгэгч, хорт хавдар, эсвэл энгийн биохимийн үзүүлэлт).

2.6.Эмнэлгийн хэрэгслийг эрсдэлийн зэргээр ангилахад хоёр ба түүнээс дээш эрсдэлийн зэрэгт хамаарч байвал хамгийн өндөр эрсдэлийн зэргийн жагсаалд оруулна.

Гурав. Эрсдэлийн зэргээр ангилах үйл ажиллагаа

3.1.Эмнэлгийн хэрэгслийг эрсдэлийн зэргээр ангилсан жагсаалтад тухайн бүтээгдэхүүн ерөнхий нэршлээр байхгүй тохиолдолд ханган нийлүүлэх байгууллага тухайн эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэгчийн нэр, бүтээгдэхүүний худалдааны нэр, загвар/ бүтээгдэхүүний дугаар, бүтээгдэхүүний тодорхойлолт, зориулалт, олон улсын нэршил (GMDN), түүний харгалзах код, үйлдвэрлэсэн улсдаа ямар эрсдэлийн зэрэгт хамрагддаг зэрэг мэдээллийг агуулсан баримт бичгийг албан хүсэлтийн хамт эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

3.2.Эмнэлгийн хэрэгслийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн ирүүлсэн албан хүсэлт, баримт бичигт үндэслэн танилцуулга бэлтгэж, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн салбар зөвлөл, Эмнэлгийн хэрэглэгдэхүүний салбар зөвлөл, Лабораторийн оношилгооны хэрэгслийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх хүсэлтийг ажлын 5 өдөр багтаан хүргүүлж, хэлэлцүүлнэ.

3.3.Салбар зөвлөлийн хуралдааны шийдвэрт үндэслэн Эмнэлгийн хэрэгслийг эрсдэлийн зэргээр ангилсан жагсаалтад нэмэлт, өөрчлөлт, хасалт хийх бөгөөд түүнийг эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

3.4.Эмнэлгийн хэрэгслийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн тухайн эмнэлгийн хэрэгслийг эрсдэлийн зэргээр ангилахад шаардлагатай нэмэлт баримт бичгийг ханган нийлүүлэх байгууллагаас шаардаж болно.

3.5.Хэрэв олон улсын нэршилд тухайн эмнэлгийн хэрэгсэл байхгүй тохиолдолд салбар зөвлөлийн шийдвэрийг үндэслэн шинэ нэршил үүсгэн нэршлийн дугаар олгож болно.

3.6.Тухайн эмнэлгийн хэрэгслийг эрсдэлийн зэргээр ангилахдаа үйлдвэрлэсэн улсдаа ямар эрсдэлийн зэрэгт хамаарч байгааг харгалзан үзэж болно.

3.7.Эмнэлгийн хэрэгслийг эрсдэлийн зэргээр ангилсан жагсаалтыг цахим системээр дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

Дөрөв. Эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг эрсдэлийн зэргээр ангилах арга

4.1. Хүний биед шууд хүрэлцдэггүй, эсхүл зөвхөн эрүүл арьс, салстад хүрэлцдэг, энэхүү журмын 4.2-оос 4.22-т хамаарахгүй бол инвазив бус эмнэлгийн хэрэгсэл бол бага эрсдэлтэй буюу I зэрэгт хамаарна.

4.2. Хүний цус, биеийн шингэн, эс, эд, шингэн, хий зэргийг тодорхой зорилгоор дамжуулах эсвэл хадгалах зориулалттай инвазив бус эмнэлгийн хэрэгслийг дараах байдлаар ангилах бөгөөд харин амьсгалын замаар эмийн бодисыг хүргэх зориулалттай инвазив, мэс заслын бус эмнэлгийн хэрэгслийг энэхүү журмын 4.20-д заасны дагуу ангилна:

4.2.1. хүний цус, биеийн шингэн, эс, эд, шингэн, хий зэргийг хүний биед тарих, хийх, хүргэх зорилготой дамжуулах, хадгалах үйлдэлтэй бүх инвазив бус эмнэлгийн хэрэгсэл дунд эрсдэлтэй буюу IIa зэрэгт хамаарна.

4.2.2. энэхүү журмын 4.2.1-д заасан эмнэлгийн хэрэгсэл дунд, өндөр эрсдэлтэй идэвхтэй эмнэлгийн хэрэгсэлтэй холбогддог бол, эсвэл цус болон биеийн бусад шингэнийг дамжуулах, хадгалах, мөн эрхтэн, эрхтний хэсэг, эд, эсийг хадгалах зориулалттай инвазив бус эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIa зэрэгт хамаарна.

4.2.3. цусны уут нь дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.2.4. энэхүү журмын 4.2.1, 4.2.2, 4.2.3-д зааснаас бусад эмнэлгийн хэрэгсэл бага эрсдэлтэй буюу I зэрэгт хамаарна.

4.3. Хүний эд, эс, цус, биеийн бусад шингэн, шингэнийг хүний биед суулгах, тарих зорилгоор биологи, химийн найрлагыг өөрчлөх зориулалттай инвазив бус эмнэлгийн хэрэгслийг дараах байдлаар ангилна:

4.3.1. хүний эд, эс, цус, биеийн бусад шингэн, шингэнийг хүний биед суулгах, тарих зорилгоор биологи, химийн найрлагыг өөрчлөх зориулалттай бүх инвазив бус эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.3.2. энэхүү журмын 4.3-д заасан эмнэлгийн хэрэгслийг ашиглан хийгдэж буй эмчилгээ нь шүүх, центрфугдэх болон дулаан, хийг солилцох үйлдэлтэй бол дунд эрсдэлтэй буюу IIa зэрэгт хамаарна.

4.3.3. хүний биеэс ялган авсан эд, эс, эрхтэнтэй шууд харьцах, эсвэл биед суулгахаас өмнө инвитро орчинд ашиглагдах бодис болон бодисын холимгоос бүрдэх, хүний биед ордоггүй бүх инвазив бус эмнэлгийн хэрэгсэл өндөр эрсдэлтэй буюу III зэрэгт хамаарна.

4.3.4. эмнэлгийн хэрэгсэл идэвхтэй эмнэлгийн хэрэгсэлтэй холбогдон ажилладаг бол энэхүү журмын 4.9, 4.11-д заасны дагуу

ангилна.

4.4. Гэмтсэн арьс, салстын мембрантай хүрэлцдэг эмнэлгийн хэрэгслийг дараах байдлаар ангилна:

4.4.1. тусдаа хэрэглэвэл эмийн бүтээгдэхүүн гэж тооцогдох, нэмэлт үйлчилгээтэй бодис агуулсан шархны наалтыг энэхүү журмын 4.14-д заасны дагуу III зэрэгт хамаарна. Харин хүний биед шимэгддэг, хэсэг газарт байрлуулахад тархдаг эмнэлгийн хэрэгслийг энэхүү журмын 4.21-д заасны дагуу ангилна.

4.4.2. эмнэлгийн хэрэгслийг механик хаалт байдлаар хэрэглэдэг буюу дарах, шүүрлийг шимэгдүүлэх үүрэгтэй бол бага эрсдэлтэй буюу I зэрэгт хамаарна.

4.4.3. арьсны гүн давхаргад хүрсэн болон салст бүрхүүлийн гэмтлийг зөвхөн хоёрдогч нөхөн төлжүүлэх аргаар эдгэрэх боломжтой шарханд зориулсан эмнэлгийн хэрэгсэл дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.4.4. гэмтсэн арьс, салстын бүрхүүлийн бичил орчныг зохицуулах (шархны гадаргуугийн чийгшлийг тогтворжуулах, шархнаас ялгарч буй шүүрлийг шингээх, биеийн температурыг барих гэх мэт) зориулалттай эмнэлгийн хэрэгсэл дунд эрсдэлтэй буюу IIa зэрэгт хамаарна.

4.4.5. энэхүү журмын 4.4-д зааснаас бусад бүх төрлийн эмнэлгийн хэрэгсэл дунд эрсдэлтэй буюу IIa зэрэгт хамаарна.

4.5. Мэс заслын аргаар бус хүний биеийн сүвээр дамжин нэвтэрдэг буюу нарийн мэргэшил (чих-хамар-хоолой, нүд, шүд, бүдүүн-шулуун гэдэс, урологи, эмэгтэйчүүд)-ийн оношилгоо, эмчилгээний инвазив эмнэлгийн хэрэгслийг дараах байдлаар ангилна:

4.5.1. мэс заслын аргаар бус хүний биеийн сүвээр дамжин нэвтэрдэг, идэвхтэй эмнэлгийн хэрэгсэлтэй холбох зориулалтгүй, эсхүл I буюу бага эрсдэлтэй идэвхтэй эмнэлгийн хэрэгсэлтэй холбох зориулалттай, түр зуур хэрэглэх зориулалттай эмнэлгийн хэрэгсэл бол бага эрсдэлтэй буюу I зэрэгт хамаарна.

4.5.2. богино хугацаанд хэрэглэдэг эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIa зэрэгт хамаарна.

4.5.3. амны хөндий, чихний суваг, хамрын хөндийд хэрэглэдэг, зөвхөн механик зориулалттай эмнэлгийн хэрэгсэл бол бага эрсдэлтэй буюу I зэрэгт хамаарна

4.5.4. удаан хугацааны хэрэглэдэг эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.5.5. амны хөндий, чихний суваг, хамрын хөндийд хэрэглэдэг, бодис агуулсан ч салст бүрхэвчээр шингэдэггүй эмнэлгийн хэрэгсэл бол IIa зэрэгт хамаарна.

4.5.6.биеийн сүвтэй харьцдаг, дунд буюу өндөр эрсдэлтэй идэвхтэй хэрэгсэлтэй холбогдох зориулалттай мэс заслын бус инвазив эмнэлгийн хэрэгсэл бол IIa зэрэгт хамаарна.

4.6.Түр зуурын хэрэглээтэй мэс заслын инвазив эмнэлгийн хэрэгсэл болох арьсанд нүх үүсгэх зориулалттай, мэс заслын багаж, олон төрлийн катетер, сорох гуурс гэх мэт инвазив эмнэлгийн хэрэгслийг дараах байдлаар ангилна:

4.6.1.энэхүү журмын 4.6.2-оос 4.6.7-д зааснаас бусад мэс түр зуурын хэрэглээтэй мэс заслын инвазив эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIa зэрэгт хамаарна.

4.6.2.зүрх, төв цусны эргэлтийн тогтолцооны гэмтэл, гажгийг удирдах, оношлох, хянах, гажгийг засах тусгай зориулалттай бөгөөд эдгээр эрхтэнтэй шууд хүрэлцдэг эмнэлгийн хэрэгсэл бол өндөр эрсдэлтэй буюу III зэрэгт хамаарна.

4.6.3.дахин ашиглагддаг мэс заслын багаж бол бага эрсдэлтэй буюу I зэрэгт хамаарна;

4.6.4.зүрх, төв цусны эргэлтийн тогтолцоо, төв мэдрэлийн тогтолцоотой шууд хүрэлцэх тусгай зориулалттай эмнэлгийн хэрэгсэл бол өндөр эрсдэлтэй буюу III зэрэгт хамаарна;

4.6.5.ионжуулагч цацраг (атомын бүтэц дэх электроныг салгах чадвартай өндөр энергийн цацраг) өгөх зориулалттай эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.6.6.биологийн үйлчлэл (биеийн эд эс, эсвэл физиологийн үйл ажиллагаанд шууд нөлөө үзүүлдэг)-тэй эсвэл бүхлээрээ, дийлэнх хэсэг нь шимэгддэг эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.6.7.эмийн бүтээгдэхүүнийг тусгай багаж ашиглан хүний бие рүү дамжуулдаг, тухайн багажийг буруу ашигласан тохиолдолд ноцтой үр дагавар гарч болзошгүй эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.7.Богино хугацааны хэрэглээтэй мэс заслын инвазив эмнэлгийн хэрэгсэл буюу мэс заслын эсвэл мэс заслын дараах үеийн хэрэгсэл (хавчаар, цорго гэх мэт), шахуургын хэрэгсэл (гуурс, зүү гэх мэт), олон төрлийн катетерыг дараах байдлаар ангилна:

4.7.1.энэхүү журмын 4.7.2-оос 4.7.7-д зааснаас бусад мэс заслын аргаар хүний биед нэвтэрдэг, богино хугацаанд хэрэглэдэг эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIa зэрэгт хамаарна.

4.7.2.зүрх, төв цусны эргэлтийн тогтолцооны гэмтэл, гажгийг удирдах, оношлох, хянах, гажгийг засах тусгай зориулалттай, эдгээр эрхтэнтэй шууд хүрэлцдэг эмнэлгийн хэрэгсэл бол өндөр эрсдэлтэй буюу III зэрэгт хамаарна.

4.7.3.зүрх, төв цусны эргэлтийн тогтолцоо, төв мэдрэлийн тогтолцоотой шууд хүрэлцэх тусгай зориулалттай эмнэлгийн хэрэгсэл бол өндөр эрсдэлтэй буюу III зэрэгт хамаарна;

4.7.4.ионжуулагч цацраг өгөх зориулалттай эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.7.5.биологийн үйлчлэлтэй эсвэл бүхлээрээ, дийлэнх хэсэг нь шимэгддэг эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна

4.7.6.бие махбод руу ороод химийн өөрчлөлт (бие дотор урвалд орж, бодис ялгаруулах, биологийн үйлдэл үзүүлэх)-д ордог, шүдэнд байрлуулдаггүй эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.7.7.эмийн бүтээгдэхүүнийг тусгай багаж ашиглан хүний бие рүү дамжуулдаг, тухайн багажийг буруу ашигласан тохиолдолд ноцтой үр дагавар гарч болзошгүй эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.8.Удаан хугацаагаар хэрэглэдэг мэс заслын инвазив эмнэлгийн хэрэгсэл буюу согог засал, шүд, нүд, зүрх судас, мэдрэл, гоо сайхны мэс заслын хөхний болон зөөлөн эдийн суулгацыг дараах байдлаар ангилна:

4.8.1.энэхүү журмын 4.8.2-оос 4.8.10-д зааснаас бусад мэс суулгац болон удаан хугацаагаар хэрэглэдэг мэс заслын эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.8.2.шүдэнд байрлуулдаг эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIa зэрэгт хамаарна.

4.8.3.зүрх, цусны төв эргэлтийн тогтолцоо, төв мэдрэлийн тогтолцоотой шууд хүрэлцдэг эмнэлгийн хэрэгсэл бол өндөр эрсдэлтэй буюу III зэрэгт хамаарна.

4.8.4.биологийн үйлчлэлтэй эсвэл бүхлээрээ эсхүл дийлэнх хэсэг нь шимэгддэг эмнэлгийн хэрэгсэл бол өндөр эрсдэлтэй буюу III зэрэгт хамаарна.

4.8.5.бие махбод руу ороод химийн өөрчлөлтөд ордог, шүдэнд байрлуулдаггүй зориулалттай эмнэлгийн хэрэгсэл бол өндөр эрсдэлтэй буюу III зэрэгт хамаарна.

4.8.6.эмийн бүтээгдэхүүнийг тусгай багаж ашиглан хүний бие рүү дамжуулах зориулалттай эмнэлгийн хэрэгсэл бол өндөр эрсдэлтэй буюу III зэрэгт хамаарна.

4.8.7.идэвхтэй суулгац болон тэдгээрийн дагалдах хэрэгсэл бол өндөр эрсдэлтэй буюу III зэрэгт хамаарна.

4.8.8.хөхний суулгац, мэс заслын тор бол өндөр эрсдэлтэй буюу III зэрэгт хамаарна.

4.8.9.бүтэн болон хэсэгчилсэн сольдог үе солих суулгац (эрэг, боолт, тусгаарлагч, багажууд зэрэг туслах хэрэгсэл үүнд хамаарахгүй) бол өндөр эрсдэлтэй буюу III зэрэгт хамаарна.

4.8.10.нурууны нугалам хоорондын жийргэвч солих суулгац, эсвэл багана нуруутай шууд хүрэлцдэг (эрэг, боолт, тусгаарлагч, багажууд зэрэг туслах хэрэгслүүд үүнд хамаарахгүй) суулгац бол өндөр эрсдэлтэй буюу III зэрэгт хамаарна.

4.9.Энергийг дамжуулах, солилцох зориулалттай идэвхтэй эмчилгээний болон эмнэлгийн хэрэгслийг удирдах, хянах, шууд нөлөөлөх зориулалттай идэвхтэй эмнэлгийн хэрэгслийг дараах байдлаар ангилна:

4.9.1.энергийг дамжуулах эсхүл солилцох зориулалттай мэс заслын цахилгаан тоног төхөөрөмж (лазер, мэс заслын генератор гэх мэт), булчин, мэдрэлийн эсийг идэвхжүүлэх тоног төхөөрөмж, эмчилгээний зорилгоор ионжуулагч цацраг ялгаруулдаг тоног төхөөрөмж, мөн эдгээр хэрэгслийг удирдах, хянах, үйл ажиллагаанд шууд нөлөөлдөг биед суулгадаг идэвхтэй эмнэлгийн хэрэгсэл хамаарна.

4.9.2.суулгадаг идэвхтэй хэрэгслийг эрсдэлийн зэргээр энэхүү журмын 4.8, эмчилгээний идэвхтэй хэрэгслийг энэхүү журмын 4.22-д заасны дагуу тус тус ангилна.

4.9.3.энерги дамжуулах, солилцох зориулалттай идэвхтэй эмчилгээний эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIa зэрэгт хамаарна.

4.9.4.тухайн энергийн шинж чанар, нягтрал, энергийг хүргэж буй байршил зэргээс шалтгаалж хүний бие рүү энерги дамжуулах эсхүл солилцохдоо аюул учруулж болохуйц эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.9.5.дунд эрсдэлтэй эмчилгээний идэвхтэй хэрэгслийн үйл ажиллагааг удирдах, хянах эсхүл үйл ажиллагаанд шууд нөлөөлөх зориулалттай идэвхтэй эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.9.6.эмчилгээний зорилгоор ионжуулагч цацраг ялгаруулдаг, мөн эдгээр хэрэгслийг удирдах, хянах, үйл ажиллагаанд шууд нөлөөлөх эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.9.7.хүний биед суулгадаг эмнэлгийн хэрэгслийн үйл ажиллагааг удирдах, хянах, үйл ажиллагаанд шууд нөлөөлөх зориулалттай идэвхтэй хэрэгсэл бол өндөр эрсдэлтэй буюу III зэрэгт хамаарна

4.10.Оношлох, хянах зориулалттай идэвхтэй хэрэгсэл болон оношлох, эмчлэх зориулалттай радиологийн хэрэгсэл, физиологийн дохиоллыг бүртгэж авдаг идэвхтэй эмнэлгийн хэрэгслийг дараах

байдлаар ангилна:

4.10.1.оношилгооны рентген зураг авдаг хэрэгслийг энэхүү журмын 4.17, суулгац идэвхтэй хэрэгслийг хянадаг өвөрмөц хэрэгслийг энэхүү журмын 4.8, 4.9-д тус тус заасны дагуу ангилна.

4.10.2.оношилгоо, хяналтын зориулалттай идэвхтэй эмнэлгийн хэрэгсэл, мөн хүний биед шингэх эсхүл сарнидаг эрчим хүч (цахилгаан гүйдэл, дулаан, хэт авиан долгион цацраг туяа гэх мэт)-ийг дамжуулдаг эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIa зэрэгт хамаарна.

4.10.3.хүний биеийг харагдах гэрлийн спектрийн гэрлээр гэрэлтүүлэх (үзлэгийн гэрэл гэх мэт) зориулалттай эмнэлгийн хэрэгсэл бол бага эрсдэлтэй буюу I зэрэгт хамаарна.

4.10.4.инвиво орчинд цацраг идэвхт изотоп агуулсан эмийн бодисын тархалтыг зураглан харуулах зориулалттай эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIa зэрэгт хамаарна.

4.10.5.физиологийн чухал үйл ажиллагааг оношлох, хянах зориулалттай эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIa зэрэгт хамаарна.

4.10.6.хянаж буй физиологийн амин үзүүлэлт болон тэдгээрийн өөрчлөлт өвчтөнд нэн даруй аюул (зүрхний үйл ажиллагааны өөрчлөлт, амьсгалын өөрчлөлт, төв мэдрэлийн тогтолцооны идэвх гэх мэт) учруулж болохуйц, эсвэл яаралтай тусламж, эрчимт эмчилгээнд буюу нэн даруй аюултай нөхцөлд оношилгоо хийх зориулагдсан эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.10.7.ионжуулагч цацраг ялгаруулах болон оношилгоо, эмчилгээний зориулалттай радиологийн хэрэгсэл, эдгээр хэрэгслийг удирдах, хянах үйл ажиллагаанд шууд нөлөөлөх эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.11.Оношилгоо, эмчилгээний шийдвэрт туслах мэдээллээр хангадаг болон физиологийн үйл явцыг хянах зориулалттай программ хангамж болох идэвхтэй эмнэлгийн хэрэгслийг дараах байдлаар ангилна:

4.11.1.программ хангамжийн эмнэл зүйн шийдвэр гаргахад өгч буй мэдээллийн ач холбогдол болон өвчтөний эрүүл мэндийн байдалд үзүүлэх эрсдэлийг харгалзан ангилна.

4.11.2.оношилгоо, эмчилгээний шийдвэр гаргахад ашиглагдах мэдээллээр хангах зориулалттай программ хангамж бол дунд эрсдэлтэй буюу IIa зэрэгт хамаарна.

4.11.3.тухайн программ хангамжийн шийдвэрийн улмаас өвчтөний амь нас эрсдэх, эсвэл өвчтөний биеийн байдал эрс дордож, бүрэн эдгэрэхгүй байх эрсдэлийг үүсгэх программ хангамж бол өндөр эрсдэлтэй буюу III зэрэгт хамаарна.

4.11.4. тухайн программ хангамжийн шийдвэрийн улмаас эрүүл мэндэд ноцтой нөлөө үзүүлж болох ч бүрэн эдгэрэх боломжтой, зарим тохиолдолд мэс засал хийлгэх эрсдэлийг үүсгэх программ хангамж бол дунд эрсдэлтэй IIb зэрэгт хамаарна.

4.11.5. физиологийн үйл ажиллагааг хянах зориулалттай программ хангамж бол дунд эрсдэлтэй буюу IIa зэрэгт хамаарна.

4.11.6. хүний амь насанд шууд нөлөөлж болох амин үзүүлэлтийг хянах зориулалттай программ хангамж бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.11.7. энэхүү журмын 4.11.1-4.11.6-д зааснаас бусад программ хангамж бол бага эрсдэлтэй буюу I зэрэгт хамаарна.

4.12. Эм, биеийн шингэн, эсвэл бусад бодисуудыг биеэс гаргах, эсвэл бие рүү хүргэх зориулалттай идэвхтэй хэрэгслийг дараах байдлаар ангилна:

4.12.1. энэхүү журмын 4.12-д эмийг дамжуулах систем болон мэдээгүйжүүлгийн тоног төхөөрөмжийг голчлон хамаарна. Хэрэв эм хүргэх бай нь амьсгалын замаар уушгинд хүргэх бол энэхүү журмын 4.20-д заасны дагуу ангилна.

4.12.2. эмийн бүтээгдэхүүн, биеийн шингэн, эсвэл бусад бодисыг биеэс гаргах, эсвэл бие рүү хүргэх зориулалттай идэвхтэй хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIa зэрэгт хамаарна.

4.12.3. тухайн бодисын шинж чанар, биеийн аль хэсэгт хэрэглэж байгаа, хэрэглэх арга зэргээс шалтгаалан аюул учруулж болзошгүй эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.13. Энэхүү журмын 4.9-өөс 4.12-д зааснаас бусад идэвхтэй хэрэгсэл бол бага эрсдэлтэй буюу I зэрэгт хамаарна.

4.14. эмнэлгийн хэрэгслийн салшгүй нэг хэсэг болсон хүний цус эсвэл цусны сийвэнгээс гаргаж авсан эмийн бүтээгдэхүүнийг тусад нь хэрэглэхэд эм гэсэн ангилалд хамаарах, үүнд хүний цус эсвэл цусны сийвэнгээс гаргаж авсан эмийн бүтээгдэхүүн багтсан бөгөөд тухайн бодис нь хэрэгслийн үндсэн үйл ажиллагаанд туслах үйлдэлтэй эмнэлгийн хэрэгсэл бол өндөр эрсдэлтэй буюу III зэрэгт хамаарна.

4.15. Жирэмслэлтээс хамгаалах, бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх эмнэлгийн хэрэгслийг дараах байдлаар ангилна:

4.15.1. жирэмслэлтээс хамгаалах эсвэл бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх зориулалттай эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.15.2. хүний биед суулгадаг эсвэл урт хугацаанд хэрэглэдэг инвазив эмнэлгийн хэрэгсэл бол өндөр эрсдэлтэй буюу III зэрэгт хамаарна.

4.16.Халдваргүйжүүлэх, ариутган цэвэрлэх, угаах, чийглэх, ариутгах зориулалттай эмнэлгийн хэрэгслийг дараах байдлаар ангилна:

4.16.1.контакт линзийг халдваргүйжүүлэх, цэвэрлэх, угаах, эсвэл шаардлагатай тохиолдолд чийгшүүлэх зориулалттай эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.16.2.эмнэлгийн хэрэгслийг халдваргүйжүүлэх, ариутгах зориулалттай эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIa зэрэгт хамаарна.

4.16.3.инвазив эмнэлгийн хэрэгслийн сүүлийн шатны халдваргүйжүүлэлт хийдэг халдваргүйжүүлэх уусмал, угаагч-халдваргүйжүүлэгч эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.16.4.контакт линзнээс бусад эмнэлгийн хэрэгслийг зөвхөн механик аргаар цэвэрлэхэд зориулалттай эмнэлгийн хэрэгсэл бол энэхүү журмын 4.16-д хамаарахгүй.

4.17.Рентген туяаг ашиглан оношилгооны зориулалтаар зураг, бичлэг хийдэг эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIa зэрэгт хамаарна.

4.18.Хүн, амьтны гаралтай эд, эс эсхүл тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүнийг ашиглан хийгдсэн эмнэлгийн хэрэгслийг дараах байдлаар ангилна:

4.18.1.дахин сэргэх боломжгүй хүний, амьтны гаралтай эд, эсээр хийгдсэн тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнээр хийгдсэн эмнэлгийн хэрэгсэл бол өндөр эрсдэлтэй буюу III зэрэгт хамаарна.

4.18.2.дахин сэргэх боломжгүй хүний, амьтны гаралтай эд, эсээр хийгдсэн тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнээр хийгдсэн эмнэлгийн хэрэгсэл нь зөвхөн эрүүл арьстай хүрэлцэх зориулалттай бол бага эрсдэлтэй буюу I зэрэгт хамаарна.

4.19.Нано материал агуулсан болон нано материалаар хийгдсэн эмнэлгийн хэрэгслийг дараах байдлаар ангилна:

4.19.1.дотоод эрхтэн, цусны урсгал, эсийн дотор орж, хүний биед шууд нөлөөлөх, биохимийн болон иммунологийн өндөр, дунд эрсдэлтэй эмнэлгийн хэрэгсэл бол өндөр эрсдэлтэй буюу III зэрэгт хамаарна.

4.19.2.дотоод эрхтэн, эд эс, эсийн дотор нэвтрэх бага боломжтой, ихэвчлэн арьс, салст давхарга зэрэг гадаргуу дээр хэрэглэдэг эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.19.3.дотоод эрхтэн, эд эс, эсийн дотор шууд ордоггүй, зөвхөн гадаргуу дээр хэрэглэдэг эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу

IIa зэрэгт хамаарна.

4.20.Амьсгалын замаар эмийн бүтээгдэхүүнийг биед хүргэх инвазив эмнэлгийн хэрэгслийг дараах байдлаар ангилна:

4.20.1.амьсгалын замаар эмийн бүтээгдэхүүнийг биед хүргэх зориулалттай мэс заслын бус аргаар хүний биед нэвтрэх инвазив эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIa зэрэгт хамаарна.

4.20.2.амьсгалын замаар эмийн бүтээгдэхүүнийг биед хүргэх зориулалттай, тухайн эмийн үйлчилгээ шууд нөлөө үзүүлдэг, хүний амь насанд аюултай учруулж болзошгүй эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.21.Арьсны гадаргуу дээр шууд хэрэглэдэг эсхүл хүний биеийн нүх, сүвээр нэвтэрдэг химийн бодисоос бүрдсэн эмнэлгийн хэрэгслийг дараах байдлаар ангилна:

4.21.1.арьсны гадаргуу дээр шууд хэрэглэдэг эсхүл хүний биеийн нүх, сүвээр нэвтэрдэг химийн бодисоос бүрдсэн эмнэлгийн хэрэгсэл нь тухайн орчны эд, эсэд үйлчилдэг, хүний биед бүхлээрээ шингэж үйлчилдэг бол өндөр эрсдэлтэй буюу III зэрэгт хамаарна.

4.21.2.химийн бодисоос бүрдсэн эмнэлгийн хэрэгсэл нь ходоод, гэдэсний замаар дамжин хүний биед бүхэлдээ шингэж, цусанд очиж үр нөлөөг үзүүлдэг бол өндөр эрсдэлтэй буюу III зэрэгт хамаарна.

4.21.3.хамар, ам, залгиурын хөндийд түрхэж, цацаж хэрэглэдэг, тухайн хэсэгт үйлчилдэг эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIa зэрэгт хамаарна.

4.21.4.энэхүү журмын 4.21.1-ээс 4.21.3-д зааснаас бусад эмнэлгийн хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу IIb зэрэгт хамаарна.

4.22.Оношилгоо хийх үйлдэлтэй эмчилгээний идэвхтэй хэрэгслийн оношилгооны функц нь эмчилгээний шийдвэрийг шууд гардаг эмнэлгийн хэрэгсэл (хаалттай инсулины насос, автомат гадна дефибриллятор, хүний биед суулгах зориулалттай дефибриллятор гэх мэт) бол өндөр эрсдэлтэй буюу III зэрэгт хамаарна.

Тав. Лабораторийн оношилгооны хэрэгслийг эрсдэлийн зэргээр ангилах арга

5.1.Хувь хүний амь нас болон хүн амын эрүүл мэндэд эрсдэл өндөр лабораторийн оношилгооны хэрэгслийг дараах байдлаар ангилна:

5.1.1.Цус, цусны бүрэлдэхүүн хэсэг, эс, эд, эрхтэн, тэдгээрээс гарган авсан (альбумин, уураг, эсийн шингэн, эмийн түүхий эд гэх мэт) донорын гаралтай бүтээгдэхүүнд халдвар үүсгэгч байгаа эсэх, тэдгээрийг бүтээгдэхүүнийг цус сэлбэх, эд, эрхтэн шилжүүлэн суулгах, эсийн эмчилгээнд ашиглахад аюулгүй, тохиромжтой эсэхийг үнэлэх зориулалттай лабораторийн оношилгооны хэрэгсэл (цусны доноруудын тэмбүүгийн болон HTLV I/II, HIV 1/2, Hepatitis B, Hepatitis C)

бол өндөр эрсдэлтэй буюу D зэрэгт хамаарна.

5.1.2.хувь хүний амь насанд аюултай, мөн түргэн тархах (өндөр халдварлах эрсдэлтэй) өвчнийг үүсгэдэг халдвар дамжуулагч бичил биетийг илрүүлэх зориулалттай лабораторийн оношилгооны хэрэгсэл (SARS-CoV-2 вирусийн ачаалал тодорхойлох, Hepatitis B, Hepatitis C Virus, Hepatitis D Virus, Haemorrhagic fever viruses /Ebola, Marburg, Lassa гэх мэт/, HIV 1/2, хоруу чанар өндөртэй цар тахлын томуу вирус - Highly virulent pandemic influenza virus, HTLV I/II, MERS Coronavirus, Smallpox virus, Variant Creutzfeldt-Jakob disease) бол өндөр эрсдэлтэй буюу D зэрэгт хамаарна.

5.1.3.хувь хүний амь насанд аюултай халдварт өвчний халдварын ачааллыг тодорхойлох, эдгээр нь өвчтөний эмчилгээний явцад хяналт зайлшгүй шаардлагатай үед ашиглахад зориулалттай лабораторийн оношилгооны хэрэгсэл (Hepatitis B Virus /DNA тоолох/, Hepatitis C Virus, HIV) бол өндөр эрсдэлтэй буюу D зэрэгт хамаарна.

5.2.Цусны бүлэг тогтоох, эх, ургийн цусны бүлгийн үл нийцэл, эс, эд, эрхтэний нийцвэрийг тодорхойлох зорилготой лабораторийн оношилгооны хэрэгслийг дараах байдлаар ангилна:

5.2.1.цус сэлбэх, эрхтэн шилжүүлэн суулгах (донор, өвчтөний дархлааны нийцэл), эсийн эмчилгээ хийхийн өмнө цус, цусан бүрэлдэхүүн, эс, эд, эрхтнүүдийн дархлааны нийцтэй байдлыг баталгаажуулах лабораторийн оношилгооны хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу C зэрэгт хамаарна.

5.2.2.энэхүү журмын 5.2.1-д заасан лабораторийн оношилгооны хэрэгсэл нь дараах маркерийн аль нэгийг тодорхойлох зориулалттай бол өндөр эрсдэлтэй буюу D зэрэгт хамаарна:

5.2.2.1.ABO систем: A (ABO1), B (ABO2), AB (ABO3);

5.2.2.2.Rhesus систем: RH1 (D), RHW1, RH2 (C), RH3 (E), RH4 (c), RH5 (e);

5.2.2.3.Kell систем KEL1 (K);

5.2.2.4.Кидд систем JK1 (Jka), JK2 (Jkb);

5.2.2.5.Даффи систем FY1 (Fya), FY2 (Fyb);

5.3.Хувь хүний амь насанд өндөр эрсдэлтэй, хүн амын эрүүл мэндэд дунд эсхүл бага эрсдэлтэй лабораторийн оношилгооны хэрэгслийг дараах байдлаар ангилна:

5.3.1.бэлгийн замаар дамждаг халдварт үүсгэгчийн байгаа эсэх, эсхүл тухайн халдварт өртсөн эсэхийг илрүүлэх зориулалттай лабораторийн оношилгооны хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу C зэрэгт хамаарна.

5.3.2.хүнээс хүнд амархан халдварладаггүй, эсхүл өргөн цар хүрээтэй халдварладаггүй халдвар үүсгэгчийг тархи, нугасны шингэн

болон цусанд байгаа эсэхийг илрүүлэх зориулалттай лабораторийн оношилгооны хэрэгсэл дунд эрсдэлтэй буюу С зэрэгт хамаарна.

5.3.3. шинжилгээний үр дүн алдаатай гарснаар хувь хүн нас барах, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээл үүсэж болохуйц ноцтой эрсдэлтэй, ураг, үр хөврөл амьгүй болох, ноцтой гэмтэлд хүргэж болзошгүй халдвар үүсгэгчийг илрүүлэх зориулалттай лабораторийн оношилгооны хэрэгсэл дунд эрсдэлтэй буюу С зэрэгт хамаарна.

5.3.4. жирэмсэн эх халдвар үүсгэгчийн эсрэг дархлаа (IgG, IgM эсрэг бие, HBsAg, Anti-HBs гэх мэт)-тай эсэхийг тодорхойлох зориулалттай лабораторийн оношилгооны хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу С зэрэгт хамаарна.

5.3.5. шинжилгээний үр дүн алдаатай гарснаар өвчтөний эмчилгээний шийдвэрт нөлөөлж, тухайн хувь хүн нас барах, ургийн амьгүй болох эрсдэл үүсгэж болзошгүй, халдварт өвчин эсхүл дархлааны байдлыг тодорхойлох зориулалттай лабораторийн оношилгооны хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу С зэрэгт хамаарна.

5.3.6. тухайн эмчилгээ эсхүл эмтэй хамт хэрэглэгдэх, тухайн өвчтөнд тухайн эмчилгээ тохирох, эмийг хэрэглэх эсэхийг тодорхойлох зориулалттай лабораторийн оношилгооны хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу С зэрэгт хамаарна.

5.3.7. шинжилгээний үр дүн алдаатай гарснаар өвчтөний эмчилгээний шийдвэрт нөлөөлж, тухайн хувь хүн нас барах, ургийн амьгүй болох эрсдэл үүсгэж болзошгүй, өвчний үе шатыг тодорхойлоход зориулалттай лабораторийн оношилгооны хэрэгсэл дунд эрсдэлтэй буюу С зэрэгт хамаарна.

5.3.8. шинжилгээний үр дүн алдаатай гарснаар өвчтөний эмчилгээний шийдвэрт нөлөөлж, тухайн хувь хүн нас барах эрсдэл үүсгэж болзошгүй, хавдрын эрт илрүүлэлт, оношилгоо, үе шатыг тодорхойлох хэрэглэх тусгай зориулалттай лабораторийн оношилгооны хэрэгсэл дунд эрсдэлтэй буюу С зэрэгт хамаарна.

5.3.9. хүнээс авсан биологийн дээж (цус, шээс, уураг, эс гэх мэт)-ид генетик шинжилгээ хийх буюу генетикийн мэдээллийг тодорхойлох, өвчин, өвөрмөц шинж тэмдэг, өвөрмөц мутаци, эмчилгээний хариу урвал, төрөлхийн гажиг зэргийн эрсдэлийн үнэлэх, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчилгээ төлөвлөх зориулалттай лабораторийн оношилгооны хэрэгсэл дунд эрсдэлтэй буюу С зэрэгт хамаарна.

5.3.10. шинжилгээний үр дүн алдаатай гарснаар өвчтөний эмчилгээ, хяналтын шийдвэр буруу гарч улмаар тухайн хувь хүн нас барах, ургийн амьгүй болох эрсдэл үүсгэж болзошгүй, эмийн бүтээгдэхүүн, бодис, биологийн бүрэлдэхүүний түвшинг хянахад зориулалттай лабораторийн оношилгооны хэрэгсэл дунд эрсдэлтэй

буюу С зэрэгт хамаарна.

5.3.11.амь насанд аюултай нөхцөл байдлаас болж шаналж буй өвчтөний эмчлэх, хянах, оношлох, эсвэл эмчилгээний үр дүнг хянах зориулалттай лабораторийн оношилгооны хэрэгсэл дунд эрсдэлтэй буюу С зэрэгт хамаарна.

5.3.12.ураг эсвэл үр хөврөлийн төрөлхийн гажиг, эмгэгийг илрүүлэх зориулалттай лабораторийн оношилгооны хэрэгсэл дунд эрсдэлтэй буюу С зэрэгт хамаарна.

5.3.13.нярай хүүхдийн төрөлхийн гажиг, бодисын солилцооны гажиг, эсвэл удамшлын эмгэгийг эрт илрүүлэх, уг эмгэгийг эмчлээгүй, илрүүлээгүй тохиолдолд амь насанд аюултай нөхцөл байдал, эсвэл хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэл үүсгэж болзошгүй лабораторийн оношилгооны хэрэгсэл дунд эрсдэлтэй буюу С зэрэгт хамаарна.

5.4. Хувь хүнд дунд болон бага эрсдэлтэй, хүн амын эрүүл мэндэд бага эрсдэлтэй буюу мэргэжлийн эмчийн туслалцаагүйгээр хувь хүн өөрөө шинжилгээ хийх зориулагдсан лабораторийн оношилгооны хэрэгслийг дараах байдлаар ангилна:

5.4.1.жирэмслэлт, үр тогтоох чадамж, холестерины түвшинг тодорхойлох, шээсэнд агуулагдах глюкоз, эритроцит, лейкоцит, бактерийг илрүүлэх зориулалттай лабораторийн оношилгооны хэрэгсэл дунд эрсдэлтэй буюу В зэрэгт хамаарна.

5.4.2.энэхүү журмын 5.4.1-д зааснаас бусад өөрөө хэрэглэх зориулалттай лабораторийн оношилгооны хэрэгсэл дунд эрсдэлтэй буюу С зэрэгт хамаарна.

5.4.3.үйлчлэх цэгт гүйцэтгэх шинжилгээ (лабораторид биш харин эмнэлгийн орчинд өөрөө хийх)-нд хэрэглэх зориулалттай лабораторийн оношилгооны хэрэгсэл бол түүний зориулалт, эрсдэлд үндэслэн энэхүү журмын бусад дүрмийн дагуу эрсдэлийн зэргээр ангилна.

5.5.Хувь хүний амь насанд дунд, бага эрсдэлтэй, хүн амын эрүүл мэндэд бага эрсдэлтэй лабораторийн оношилгооны хэрэгслийг дараах байдлаар ангилна:

5.5.1.лабораторийн ерөнхий хэрэглээнд зориулагдсан бүтээгдэхүүн, тусгайлсан зориулалтгүй дагалдах хэрэгсэл, буфер уусмал, угаах уусмал, ерөнхий өсгөвөрлөх орчин, гистологийн будаг зэргийг үйлдвэрлэгчээс тодорхой шинжилгээнд хэрэглэх зориулалттай гэж заасан, оношилгооны шийдвэр гаргахгүй, шинжилгээг дэмжих үүрэггүй лабораторийн оношилгооны хэрэгсэл бол бага эрсдэлтэй буюу А зэрэгт хамаарна.

5.5.2.лабораторийн оношилгоонд ашиглах зорилготойгоор

үйлдвэрлэгчийн зүгээс тусгайлан зориулсан багаж, төхөөрөмж бол бага эрсдэлтэй буюу А зэрэгт хамаарна.

5.5.3.биологийн дээжийг хураах, тээвэрлэх, хадгалах зориулалттай оношилгооны урвал явагддаггүй, дээжийг хамгаалах, чанарыг хадгалах үүрэгтэй сав бол бага эрсдэлтэй буюу А зэрэгт хамаарна.

5.6.Энэхүү журмын 5.1-ээс 5.5-д хамаарахгүй, клиник биохимийн шинжилгээ (даавар, витамин, фермент, бодисын солилцооны маркер, электролит, субстрат гэх мэт), эмгэг судлалын ихэнх иммуногистохимийн шинжилгээ, эдгээр шинжилгээ нь хүн амь насанд шууд ноцтой аюултай биш, голчлон эмчилгээний шийдвэрт дэмжлэг үзүүлдэг, эдийн бүтэц, эсийн молекул шинжийг илрүүлдэг, хүнээс хүн рүү амархан дамжихгүй халдварын агентыг илрүүлэх зориулалттай лабораторийн оношилгооны хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу В зэрэгт хамаарна.

5.7.Тоон болон чанарын утга заагаагүй хяналтын лабораторийн оношилгооны хэрэгсэл бол дунд эрсдэлтэй буюу В зэрэгт хамаарна.

5.8.Харшил төрүүлэгч шинжилгээний уусмал бол дунд эрсдэлтэй буюу В зэрэгт хамаарна.

5.9.Лабораторийн анализатор бол дунд эрсдэлтэй буюу В зэрэгт хамаарна.

Зургаа. Хариуцлага

6.1.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2026 оны 8 дугаар сарын 17-ны өдөр хүлээн авсан

**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2026 оны 8 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 26/70

Улаанбаатар
хот

ЖУРМЫН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.14, 35.1.16 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 68 дугаар зүйлийн 68.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/29 дүгээр тогтоолоор батлагдсан “Худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн эрх үүргийг тодорхойлсон нийтлэг журам”-ын 4.1, 5.1.5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2.Журмын өөрчлөлтийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (М.Халтар)-нд үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ИХБАЯР

**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙДЫН
ТУШААЛ**

2026 оны 7 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар А/191

Улаанбаатар
хот

ЖУРАМД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.8 дахь заалт, Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8, 20 дугаар зүйлийн 20.11 дэх хэсэг, Засгийн газрын 2026 оны “Боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 147 дугаар тогтоолын 2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Боловсролын сайдын 2025 оны “Журам, шаардлага батлах тухай” А/559 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх журам”-д оруулах нэмэлтийг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тушаалыг баталсантай холбогдуулан урьдчилсан магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага, аргачлалыг шинэчилж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл (Б.Амарсанаа)-д даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, танилцуулахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (В.Түвшинжаргал)-т даалгасугай.

САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

*Боловсролын сайдын 2026 оны
07 дугаар сарын 06-ны өдрийн
А/191 дүгээр тушаалын хавсралт*

**“МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН, ДЭЭД БОЛОВСРОЛЫН
СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА БОЛОН ХӨТӨЛБӨРИЙГ МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ, МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ ХИЙХ ЖУРАМ”-Д
ОРУУЛАХ НЭМЭЛТ**

1. Боловсролын сайдын 2025 оны “Журам, шаардлага батлах тухай” А/559 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх журам”-д дор дурдсан агуулгатай 3.6 дахь хэсэг, 3.7, 3.8 дахь заалт нэмэх:

“1/3.6.Хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлийн зохицуулалт:

2/3.6.1.Дээд боловсролын шинэ хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэл нь тухайн хөтөлбөрийн боловсруулалт, сургалтын төлөвлөгөө, багшлах хүний нөөц, сургалтын орчин, материаллаг бааз, дотоод чанарын баталгаажуулалтын бэлэн байдлыг сургалтын байгууллагын өөрийн үнэлгээний тайлан болон Дээд боловсролын цахим мэдээллийн санд бүртгэгдсэн өгөгдөл, нотлох баримтад үндэслэн үнэлж, дүгнэлт гаргах үйл ажиллагаа байна.

3/3.6.2.Сургалтын байгууллага нь шинэ хөтөлбөрөөр сургалт эрхлэх хүсэлтээ боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана. Төрийн захиргааны төв байгууллага тухайн сургалтын байгууллагад олгосон зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг Дээд боловсролын цахим мэдээллийн сангийн өгөгдөлд үндэслэн хянан үзэж, шаардлага хангасан тохиолдолд урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгүүлэхээр хүсэлтийг магадлан итгэмжлэлийн байгууллагад шилжүүлнэ.

4/3.6.3.Урьдчилсан магадлан итгэмжлэлийн хөндлөнгийн үнэлгээг магадлан итгэмжлэлийн байгууллагаас томилсон тухайн хөтөлбөрийн чиглэлээр мэргэшсэн гурван шинжээчээс бүрдсэн баг гүйцэтгэнэ. Шинжээчийн баг нь сургалтын байгууллагын өөрийн үнэлгээний тайлан, холбогдох баримт бичиг болон Дээд боловсролын цахим мэдээллийн санд бүртгэгдсэн өгөгдөл, нотлох баримтыг судлан, шаардлагатай тохиолдолд газар дээрх үнэлгээ хийж дүгнэлт гаргана.

5/3.6.4.Магадлан итгэмжлэлийн байгууллага баримт бичгийн бүрдэл хангасан хүсэлтийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор энэхүү журмын 3.6.3-т заасан дүгнэлтийг тухайн сургалтын байгууллага,

боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлнэ.

6/3.6.5.Шинэ хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлийн дүгнэлт нь Дээд боловсролын тухай хуулийн 12.12-т заасан хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шийдвэрийг орлохгүй.

7/3.6.6.Урьдчилсан магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны зардлыг хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн суурь төлбөрийн 50 хүртэлх хувиар тогтооно.

8/3.6.7.Урьдчилсан магадлан итгэмжлэлийн дүгнэлт гарснаас хойш хоёр жилийн хугацаанд сургалтын үйл ажиллагаа эхлүүлээгүй бол урьдчилсан магадлан итгэмжлэлийн үнэлгээг дахин хийлгэнэ.

9/3.7.Бакалаврын түвшний энгийн зөвшөөрөлтэй хөтөлбөрөөр дэд бакалаврын сургалт эрхлэхэд урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэхгүй байж болно.

10/3.8.Магадлан итгэмжлэлийн байгууллага сургалтын байгууллагын хүсэлтийг үндэслэн хөтөлбөрийн хамаарах ерөнхий чиглэл, боловсролын түвшнээр багцлан шинжээчийн багийг нэгтгэн томилж, үйл ажиллагааны зардлыг багцлан тооцож болно.”

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2026 оны 8 дугаар сарын 17-ны өдөр хүлээн авсан

**БУЛГАН АЙМГИЙН СЭЛЭНГЭ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
VIII ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2026 оны 6 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар VIII/06

Сэлэнгэ сум

ТОГТООЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, мөн хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Малын тоо толгойн албан татвар тогтоох тухай Сэлэнгэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 03/02 дугаар тогтоолын үндэслэл хэсэгт “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “д” хэсэг” гэснийг “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 заалт” гэж, “Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.5, 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалт” гэснийг “Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.15, 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалт” гэж тус тус өөрчилсүгэй.

ДАРГА

Х.ХҮДЭРЧУЛУУН

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 7 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар А/84

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалт, 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/52 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн ёс зүйн дүрэм”-д дор дурдсанаар нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

1.1/Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийн “ёс зүйн зөвлөлд” гэснийг “ёс зүйн дэд хороонд” гэж өөрчилсүгэй.

1.2/Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “нөлөөлөх, нөлөөлөхөөр оролдохгүй байвал зохино.” гэсний дараа “Ийнхүү үйлдэл гаргасан тохиолдолд албан хаагчид хувийн сонирхлын бүртгэл хөтлөгдөнө.” гэж нэмсүгэй.

1.3/Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д “Энэ дүрмийн 6.1-т заасныг зөрчсөн тохиолдолд албан хаагчид хувийн сонирхлын бүртгэл хөтлөгдөх бөгөөд холбогдох шалгалтын ажиллагааг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хариуцсан нэгжээс явуулна.” гэснийг, 6.1.2-т “Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хариуцсан нэгж шалгалтын дүнг Ёс зүйн зөвлөлд танилцуулна” гэснийг тус тус хассугай.

1.4/Дүрмийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг “Төрийн аудитын байгууллагын албан хаагчийг ёс зүйн зөрчил гаргасан тухай Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэл, эсхүл Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан ёс зүйн хариуцлага хүлээлгэх эсэхийг Монгол Улсын Ерөнхий аудитор шийдвэрлэнэ.” гэж өөрчлөн найруулсугай.

2.Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн ёс зүйн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлж, холбогдох хөдөлгөөн хийлгэхийг Үндэсний аудитын газрын Тамгын газар (Б.Бундхорол)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Чанарын удирдлага, эрсдэлийн газар (Я.Самбууням)-т даалгасугай.

ЕРӨНХИЙ АУДИТОР

С.МАГНАЙСҮРЭН

ТЭМДЭГЛЭЛ